



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕС ДЭХ УДААГИЙН  
БҮРЭН ЭРХИЙН АНХДУГААР ЧУУЛГАНЫ

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1-2
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3-33
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	34-135
<i>1.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай</i>	
<i>2.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</i>	37-39
<i>3.Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/</i>	39-46
<i>4.Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай</i>	46-56
<i>5.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	56-58
<i>6.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	58-87
<i>7.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай</i>	87-92
<i>8.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	92-108
<i>9.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	108-110
<i>10.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах</i>	110-112
<i>11.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах</i>	112-115
<i>12.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</i>	115-116
<i>13.Засгийн газрын гишүүнийг томилох тухай Ерөнхий сайдын танилцуулга сонсох</i>	116-122
<i>14.Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай /</i>	122-127

<i>15.Дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай</i>	<i>127-130</i>
<i>16.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа</i>	<i>131-134</i>
<i>17. Анхдугаар чуулганы хаалт</i>	<i>134-135</i>

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы  
2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн ирж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 08 цаг 13 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: М.Нарантуяа-Нара;*

*Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар;*

*Тасалсан: М.Бадамсүрэн, Х.Баттулга, Н.Номтойбаяр, Д.Пүрэвдаваа, С.Цэнгүүн.*

**Нэг.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу Засгийн газраас 2024 оны 7 дугаар сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцүүлэх тухай мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу санал хураалтыг биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр идэвхжих цахим систем ашиглан явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан: 43  
 Бүгд: 83  
 48.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81  
 Татгалзсан: 6  
 Бүгд: 87  
 93.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 80  
 Татгалзсан: 7  
 Бүгд: 87  
 92.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг цахим систем ашиглан явуулахаар тогтов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг яаралтай хэлэлцүүлэх горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78  
 Татгалзсан: 9  
 Бүгд: 87  
 89.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул уг асуудлыг яаралтай горимоор хэлэлцэхээр тогтов.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэхийг дэмжсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 08 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан *тогтоолын төслийг танилцуулав.*

*Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.*

**Д.Амарбаясгалан:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 15

Бүгд: 89

83.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Тогтоолын эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар санал хэлж, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан *тайлбар хийв.* Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./08:37/

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Байнгын хороодын хуралдааныг хуралдуулах болсон тухай мэдэгдэв. Чуулганы нэгдсэн хуралдаан 08 цаг 37 минутаас 14 цаг 53 минутад завсарлав.*

***Гурав.Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Б.Баасандорж оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатангуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх, томилох тухай саналыг Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар танилцуулав.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Б.Баасандорж хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Батбаатар нар үг хэлэв.

*Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх саналыг нууц санал хураалтаар явуулав.*

**Д.Амарбаясгалан:** Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
 Татгалзсан: 103  
 Бүгд: 103  
 0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
 Татгалзсан: 102  
 Бүгд: 103  
 1.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
 Татгалзсан: 38  
 Бүгд: 104  
 63.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 68  
 Татгалзсан: 36  
 Бүгд: 104  
 65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

*Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигчийг томилох саналыг нууц санал хураалтаар явуулав.*

**Д.Амарбаясгалан:** Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
 Татгалзсан: 34  
 Бүгд: 105  
 67.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх

санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 105 гишүүнээс 72 гишүүн дэмжиж, 68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.*

*Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:18/*

*Уг асуудлыг 15 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Дөрөв.Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа, Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар тус тус танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал хариулж, тайлбар хийв.

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 50



Бүгд: 113  
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсенг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78  
Татгалзсан: 35  
Бүгд: 113  
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Амарбаясгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 113 гишүүнээс 79 гишүүн дэмжиж, 69.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74  
Татгалзсан: 39  
Бүгд: 113  
65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 80  
Татгалзсан: 33  
Бүгд: 113  
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 78  
Татгалзсан: 35  
Бүгд: 113  
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Лутаагийн Энхнасанг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73  
Татгалзсан: 40  
Бүгд: 113  
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддоржийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72  
Татгалзсан: 41  
Бүгд: 113  
63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нэр дэвшигчийг дэмжсэн тул Байнгын хорооны даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:58/

*Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Байнгын хороодын хуралдаан дуусаагүй байгааг мэдэгдэж, хэлэлцэх асуудлын дарааллын тав дугаар асуудал болох Дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудлыг түр хойшлуулав./15:59/*

***Тав. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 76  
Татгалзсан: 37  
Бүгд: 113  
67.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их

Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:03/

*Уг асуудлыг 16 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлийн хурал хуралдах тухай мэдэгдэж, хуралдаан 16 цаг 03 минутаас 18 цаг 45 минутад завсарлав.*

***Зургаа.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохихсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, О.Цогтгэрэл, С.Ганбаатар, Б.Батбаатар, Б.Мөнхсоёл, Б.Уянга, Г.Дамдинням, М.Мандхай, С.Эрдэнэбат, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Батбаатар, Ж.Баярмаа, П.Сайнзориг, Б.Мөнхсоёл, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 53

Бүгд: 117

54.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Р.Сэддорж, Д.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 117 гишүүнээс 67 гишүүн дэмжиж, 57.3 хувийн саналаар Байнгын хорооны

санал дэмжигдлээ.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 20 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	44
Татгалзсан:	73
Бүгд:	117

37.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	46
Татгалзсан:	71
Бүгд:	117

39.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан дууссаны дараа үргэлжлүүлэн хуралдахыг мэдэгдэж, түр завсарлав./20:52/

*Чуулганы нэгдсэн хуралдаан 2024 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 20 цаг 52 минутад түр завсарлаж, 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 01 цаг 33 минутад санал хураалтаар үргэлжлэв.*

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62  
Татгалзсан: 51  
Бүгд: 113  
54.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 50  
Бүгд: 113  
55.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./01:38/

*Уг асуудлыг 01 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохихсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 04 цаг 41 минутаас хуралдааныг даргалав.*

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, О.Цогтгэрэл, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа хариулж, тайлбар хийв.

*Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### ***1.Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийн талаар:***

#### **Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Х.Булгантуяа:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Дам.Цогтбаатар нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн "4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам" гэснийг "4/Хууль зүй, дотоод хэргийн яам" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56  
Татгалзсан: 58  
Бүгд: 114  
49.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 57 гишүүн дэмжиж, 50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 54  
Бүгд: 114  
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 61 гишүүн дэмжиж, 53.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Х.Булгантуяа:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Дам.Цогтбаатар нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн "4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам" гэснийг "4/Хууль зүй, дотоод хэргийн яам" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	53
Бүгд:	114

53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 62 гишүүн дэмжиж, 54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “9/Гэр бүл, хүний хөгжлийн яам” гэснийг “9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	49
Бүгд:	114

57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 66 гишүүн дэмжиж, 57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “10/Зам, тээврийн хөгжлийн яам” гэснийг “10/Зам, тээврийн яам” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	50
Бүгд:	114

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 65 гишүүн дэмжиж, 57.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийн талаар:**

**Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Х.Булгантуяа:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан, гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60  
Татгалзсан: 54  
Бүгд: 114  
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 61 гишүүн дэмжиж, 53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд;” гэснийг “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55  
Татгалзсан: 59  
Бүгд: 114  
48.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 56 гишүүн дэмжиж, 49.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Номингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын гишүүн Ч.Номингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 56  
Бүгд: 114  
50.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 114 гишүүнээс 59 гишүүн дэмжиж, 51.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.



Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.

**Х.Булгантуяа:** 2.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд;” гэснийг “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 51  
Татгалзсан: 65  
Бүгд: 116  
44.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 116 гишүүнээс 52 гишүүн дэмжиж, 44.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа санал хураалтыг гар өргөж явуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 05 цаг 17 минутаас хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан санал хураалт явуулах ерөнхий журмын талаар тайлбар хийв.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83  
Татгалзсан: 33  
Бүгд: 116

71.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** 2.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд;” гэснийг “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 84  
Татгалзсан: 32

Бүгд: 116  
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн "17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайд" гэснийг "17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 85  
Татгалзсан: 31  
Бүгд: 116  
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун, О.Номинчимэг, Дам.Цогтбаатар, Б.Пүрэвдорж нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалтын "Шударга ёс," гэснийг, "Зам тээврийн" гэсний дараах "хөгжлийн" гэснийг тус тус хасах; "Гэр бүл," гэсний дараах "хүний хөгжлийн" гэснийг "хөдөлмөр, нийгмийн хамгааллын" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 84  
Татгалзсан: 32  
Бүгд: 116  
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд "лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт," гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 85  
Татгалзсан: 31  
Бүгд: 116  
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний "чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлт" гэснийг "чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт" гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 80  
Татгалзсан: 36  
Бүгд: 116  
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "З/Монгол Улсын Засгийн газрын

гишүүн-Монгол Улсын Шадар сайд' гэсний дараа “/бүсчилсэн хөгжлийн асуудал эрхэлсэн/” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 83  
Бүгд: 116  
28.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Гэр бүл, хүний хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний “хөдөлмөрийн нөхцөл,” гэсний дараа “хөдөлмөрийн аюулгүй байдал,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 81  
Татгалзсан: 35  
Бүгд: 116  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Боловсролын сайдын эрхлэх ажлын хүрээнд “-зэргийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах;” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 81  
Татгалзсан: 35  
Бүгд: 116  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээний “иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;” гэснийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

8.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний “биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого” гэсний өмнөх “нийтийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 83  
Татгалзсан: 33  
Бүгд: 116  
71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх

ажлын хүрээний “гадаадын хөрөнгө оруулалтын” гэснийг “гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 82  
Татгалзсан: 34  
Бүгд: 116  
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайд болон Засгийн газрын гишүүн бүрийн эрхлэх ажлын хүрээнд “-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84  
Татгалзсан: 32  
Бүгд: 116  
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11. Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Л.Энх-Амгалан нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого” гэсний дараа “, төлөвлөлт” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 85  
Татгалзсан: 31  
Бүгд: 116  
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12. Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажлын хүрээний “залуучуудын хөгжлийг дэмжих бодлого” гэснийг “залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

**4.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “бүсчилсэн хөгжлийн” гэж, мөн зүйлийн 7.6 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийн “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “Бүсчилсэн хөгжлийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.8 дахь заалтын “бүс нутгийн хөгжлийн” гэснийг “эдийн засаг, хөгжлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83  
 Татгалзсан: 33  
 Бүгд: 116  
 71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

***5.Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар:***

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Зулпхар, Г.Лувсанжамц, С.Эрдэнэбат, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун нарын гаргасан, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 85  
 Татгалзсан: 31  
 Бүгд: 116  
 73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Найруулгын санал**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 85  
 Татгалзсан: 31  
 Бүгд: 116  
 73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:**

***1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжиний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажлын хүрээний “хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал” гэснийг Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд шилжүүлэх гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин саналаа татан авч байгаа тухай мэдэгдэж, дээрх саналаар саналт хураалт явуулаагүй болно.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжиний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд “иргэний боловсролын албан болон албан бус хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх;” гэж нэмэх гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 55

Бүгд: 116

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Тогтоолын төслийн хавсралтын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсгийн “-Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэснийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 02 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдахыг мэдэгдэж, чуулганы нэгдсэн хуралдаан 02 цаг 52 минутаас 03 цаг 53 минутад завсарлав.*

***Ес.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.07.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохицсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул,

референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** 1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний “залуучуудын хөгжлийг дэмжих бодлого” гэснийг “залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого” гэж өөрчлөх гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 58  
Бүгд: 117  
50.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 04 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

#### ***Арав.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.*

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** 1.Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 51

Бүгд: 117

56.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 49

Бүгд: 117

58.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 46

Бүгд: 117

60.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 46

Бүгд: 117

60.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 46

Бүгд: 117

60.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 45

Бүгд: 117

61.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.



7.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 43

Бүгд: 117

63.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 44

Бүгд: 117

62.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 44

Бүгд: 117

62.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75

Татгалзсан: 42

Бүгд: 117

64.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76

Татгалзсан: 41

Бүгд: 117

65.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76

Татгалзсан: 41

Бүгд: 117

65.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 04 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван нэг.Баталсан хуулиудын эцсийн найруулгыг танилцуулах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Засгийн газрын бүтцийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Засгийн газрын бүтцийн *тухай хуулийн эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.* Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:17/

2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай *хуулийн эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Дам.Цогтбаатар үг хэлэв.* Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:21/

***Дагалдан гарсан:***

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:21/

4.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:21/

5.Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:21/

6.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:22/

7.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:22/

8.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт,

санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:22/

9.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:22/

10.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:23/

11.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./04:23/

12.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./04:23/

13.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./04:23/

*Уг асуудлыг 04 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

*Чуулганы нэгдсэн хуралдаан 04 цаг 25 минутаас 05 цаг 43 минутад завсарлав.*

***Арван хоёр.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	51
Бүгд:	118

56.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./05:49/*

*Уг асуудлыг 05 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван гурав.Засгийн газрын гишүүнийг томилох тухай Ерөнхий сайдын танилцуулга сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Л.Гантөмөр, С.Амарсайхан, Т.Доржханд, Н.Учрал, Э.Одбаяр, Р.Эрдэнэбүрэн, Б.Тулга, Б.Батцэцэг, Б.Жавхлан, О.Алтангэрэл, Ц.Туваан, С.Бямбацогт, С.Одонтуяа, П.Наранбаяр, Л.Энх-Амгалан, Б.Дэлгэрсайхан, Ч.Номин, Ж.Батсуурь, Ж.Энхбаяр, Ц.Баатархүү, Б.Чойжилсүрэн, Т.Мөнхсайхан болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохихсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад нэр дэвшигч Лувсаннъямын Гантөмөр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигч Сайнбуянгийн Амарсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигч Тогмидын Доржханд, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад нэр дэвшигч Ням-Осорын Учрал, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргад нэр дэвшигч Эрдэнэбилэгийн Одбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргад нэр дэвшигч Равжихын Эрдэнэбүрэн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргад нэр дэвшигч Буяагийн Тулга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдад нэр дэвшигч Батмөнхийн Батцэцэг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдад нэр дэвшигч Болдын Жавхлан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдад нэр дэвшигч Оюунсайханы Алтангэрэл, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад нэр дэвшигч Цэвэгдоржийн Туваан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдад нэр дэвшигч Сандагийн Бямбацогт, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад нэр дэвшигч Салдангийн Одонтуяа, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайдад нэр дэвшигч Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад нэр дэвшигч

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдад нэр дэвшигч Борхүүгийн Дэлгэрсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад нэр дэвшигч Чинбатын Номин, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад нэр дэвшигч Жамбын Батсуурь, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад нэр дэвшигч Жадамбын Энхбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад нэр дэвшигч Цэндийн Баатархүү, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдад нэр дэвшигч Баттогтохын Чойжилсүрэн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдад нэр дэвшигч Тогтмолын Мөнхсайхан нарыг томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нэр дэвшигч тус бүрээр танилцуулав.

Ерөнхий сайдын танилцуулга болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Ч.Лодойсамбуу нарын тавьсан асуултад нэр дэвшигч Ж.Энхбаяр, Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Батбаатар, Б.Бейсен, С.Эрдэнэболд, Б.Заяабал, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гишүүдийг томилох тухай Ерөнхий сайдын танилцуулгыг сонслоо.

*Уг асуудлыг 06 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

*Чуулганы нэгдсэн хуралдаан Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангах болон зарим Байнгын хорооны хуралдааны дараа үргэлжлүүлэн хуралдахаар 06 цаг 16 минутаас 06 цаг 55 минутад түр завсарлав.*

### ***Арван дөрөв.Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар тус тус танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81  
Татгалзсан: 38  
Бүгд: 119

68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83  
Татгалзсан: 36  
Бүгд: 119

69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83  
Татгалзсан: 36  
Бүгд: 119

69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83  
Татгалзсан: 36  
Бүгд: 119

69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай” тогтоол баталсанд тооцов.

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./07:11/*

*Уг асуудлыг 07 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

***Арван тав.Дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан

ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүний талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нар тус тус танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.*

**Д.Амарбаясгалан:** “Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	82
Татгалзсан:	37
Бүгд:	119

68.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./07:22/

*Уг асуудлыг 07 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Арван зургаа.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа***

Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Л.Гантөмөр, С.Амарсайхан, Т.Доржханд, Н.Учрал, Э.Одбаяр, Р.Эрдэнэбүрэн, Б.Тулга, Б.Батцэцэг, Б.Жавхлан, О.Алтангэрэл, Ц.Туваан, С.Бямбацогт, С.Одонтуяа, П.Наранбаяр, Л.Энх-Амгалан, Б.Дэлгэрсайхан, Ч.Номин, Ж.Батсуурь, Ж.Энхбаяр, Ц.Баатархүү, Б.Чойжилсүрэн, Т.Мөнхсайхан болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх П.Зохихсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга

Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, референт Д.Батжаргал, шинжээч Б.Мөнхбилгүүн нар зохион байгуулав.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэн байрлуулж, Төрийн сүлдний зүүн, баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

*Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 10-т “Засгийн газрын гишүүд танхимын голд Монгол Улсын Төрийн сүлд рүү харан эгнэн зогсон тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Салдангийн Одонтуяа тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлэв.*

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах дарааллаар Засгийн газрын гишүүдийн нэрийг дуудав.*

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Эрдэнэбилэгийн Одбаяр;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Равжихын Эрдэнэбүрэн;



8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд Болдын Жавхлан;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Салдангийн Одонтуяа;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр;

15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан;

16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан;

17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Чинбатын Номин;

18/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Жамбын Батсуурь;

19/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр;

20/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Цэндийн Баатархүү;

21/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн;

22/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан.

Тангараг өргөсний дараа нэр дуудагдсан Засгийн газрын гишүүн суудлаасаа босож Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын 22 гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд баяр хүргэж, үг хэлэв.

*Тангараг өргөх ёслолын ажиллагаа 07 цаг 50 минутад өндөрлөв.*

***Арван долоо. Анхдугаар чуулганы хаалт***

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганыг хааж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланг үг хэлж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 17 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 8 цаг 00 минут үргэлжилж, 126 гишүүнээс 126 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр 7 дугаар сарын 10-ны өдрийн 07 цаг 50 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРАЛ**

2024 оны 07 дугаар сарын 09-ний  
өдөр, Мягмар гараг  
Төрийн ордон “Их хуралдай”  
танхим  
08 цаг 13 минут

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна.

Ирц 59.5 хувьтай, 126 гишүүнээс 75 гишүүн ирсэн байна. Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 14 асуудлыг хэлэлцэхээр байна.

1-рт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай асуудлыг хэлэлцэнэ.

2.Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудал.

3.Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал.

4.Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай асуудал.

5.Дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудал.

6.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

7.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Засгийн газраас 2024 оны 7 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал орно.

8 дугаарт, Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, анхны хэлэлцүүлэг.

9.Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Эцсийн хэлэлцүүлэг.

10.Хуулийн төслүүд эцэслэн батална. Нийт 22 төсөл байгаа.

11.Засгийн газрын гишүүнийг томилох тухай Ерөнхий сайдын танилцуулга.

12.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай асуудал. Ёс зүй, дэгийн байнгын хорооны саналыг гаргана. Хуралдааны шийдвэрийг.

13.Засгийн газрын гишүүд тангараг өргөх ёслолын ажиллагаа.

14. Анхдугаар чуулганы хаалт гэсэн 14 асуудлыг хэлэлцэнэ. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

**Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэхээр байгаа.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлын Анхдугаар чуулганаар хэлэлцэх асуудлын санал хураалтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу гар өргөж явуулах горимын санал гаргасныг Улсын Их Хурлын гишүүд 100 хувь дэмжсэн байгаа.

Энэ гишүүд яриагаа гарч байгаад хийх үү? Давхар яриад байх юм.

Улсын Их Хурлын Тамгын газрын санал хураалтын төхөөрөмжийн шинэчлэл, техникийн тохируулалтыг бүрэн хийж дууссан байна. Иймд

өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлуудын санал хураалтыг санал хураалтын төхөөрөмж ашиглан явуулах горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтын төхөөрөмж ашиглалтад орсон учраас төхөөрөмжөөр санал хураалт явуулах санал хураалтыг явуулъя.

Энэ дээр бас дадлага хийх шаардлагатай байх шиг байна тийм ээ? Тэгэхээр горимын санал гаргаад саяын саналаа унагаагаад, дахин санал хураалт явуулъя гэсэн горимын санал.

Бямбацогт гишүүн.

**С.Бямбацогт:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Төхөөрөмж маань шинэ тавигдсан, гишүүд маань бас шинэ сонгогдсон анх удаа бас санал өгөх гэж байгаа учраас хэд хэдэн удаа бас дадлага хийж асуудалгүй болсныхоо дараа 100 хувь өгөөд асуудалгүй боллоо гэснийхээ дараа л саналаа хурааж эхэлье. Тэр болтол горимын саналаар дадлага хийх, дасгал хийх горимын санал гаргаж байна. Тэгэхээр горимын саналаар дахин санал хураалт явуулъя. Явуулахын өмнө туршилтын 3 удаагийн санал явуулах уу? Тайлбарыг нь хийх үү? Энэ ширээн дээрэнэ санал хураалтын холбогдсон тайлбар байж байна. Алга байна уу?

Би уншаад танилцуулъя тэгвэл. Санал хураалтын төхөөрөмж ашиглах санамж гэж байгаа юм. Хуралдааны ирцэд бүртгүүлэхдээ хуруугаа хөдөлгөөнгүй 1-ээс 2 секунд байрлуулж, хурууны хээг уншуулна. Зөв уншуулсан тохиолдолд хуруугаа уншуулаад уншсан тохиолдолд таниад бүртгэл сэргээгдэнэ гэж байна.

Хүсэлт илгээх, үг хэлэхтэй холбоотойгоор бол хүсэлт илгээхдээ товчлуурыг дарах ба хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд микрофоны ногоон гэрэл асна гэж байгаа юм. Микрофон нээгдэхэд улаан гэрэл асаж, хугацааны

тоолуур ажиллаж, дэлгэцэд нэр татна гэж байгаа юм. Тэгэхээр үг хэлэх, нэр өгөхдөө бол энэчээ товчлуурыг дарна гэж байна.

Санал хураалтад орохдоо санал хураалт эхлэхэд хуруугаа хөдөлгөөнгүй 1-ээс 2 секунд байрлуулж “хурууны хээ” гэсэн бичиг гартал уншуулна. Таныг хурууны хээгээ уншуулсны дараа “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн сонголт гарч ирэхэд саналаа өгнө гэж байгаа юм.

Тэгэхээр хурууны хээгээ санал хураалтад орохдоо уншуулах нь байна. Уншуулсны үр дүнгээр “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн сонголт гарч ирнэ. Тэгэхээр дэлгэц дээр “зөвшөөрсөн”, “татгалзсан” дээрээ саналаа өгч оролцох юм байна.

Ингээд туршилтын 3 санал хураалтыг явуулъя. Эхний удаа бүгдээрээ зөвшөөрснөөр нь санал өгч үзэх нь зүйтэй байх. Дараачийн удаа татгалзсанаар өгч үзье. Тэгээд 3 дахь удаа өөр өөрийн сонголтоор хийгээд, өөрөө өөрийгөө харах ч боломж байхгүй. Гэхдээ процентоо харах нь зүйтэй байх гэж бодож байна. Ингээд 3 удаагийн туршилтын санал явуулъя.

Эхнийх. Энд чинь татгалзсан гээд гишүүд гарч байна. Байхгүй гишүүд үү? Л.Энхнасан гишүүн сая байсан уу? Зөвшөөрсөн гэж санал өгсөн үү?

Дарж амжсангүй. 11 гишүүн татгалзсан. Одоо төхөөрөмжийнхөө хурданд тааруулахаас өөр аргагүй л болно доо. Одоо сурах байлгүй.

Хоёр дахь санал хураалтыг явуулъя. Одоо бүгдээрээ. Энэ сая дараагүй байхад тэр дэлгэц дээр секунд нь дуусаад, энэ дэлгэц дээр дөнгөж гарч ирээд алга болчхож байна шүү дээ. Тийм байна. Дахиад санал хураалт эхлүүлбэ. Татгалзсанаар.

Гурав дахь санал хураалтаа явуулъя. Гурав дахийг бүгдээрээ дахиад зөвшөөрснөөр. Бүгд зөвшөөрснөөр санал өгөөд үзээдэхье гишүүд ээ. Зөвшөөрсөн дээр. Дамдинням гишүүн ээ бүгдээрээ зөвшөөрсөн дээр санал хураалт өгөөдөхье. Санал эхлүүлбэ. Батнайрамдал гишүүн саналаа өгсөн юм уу? Гацаад байна уу? Баасанжаргал гишүүн байна уу? Санал өгсөн үү? Болохгүй байна. Замира гишүүн? Амжсангүй. Төхөөрөмж хоцроод байна уу? Өөрөө хоцроод байна уу? Мөнхбаясгалан гишүүн саналаа өгсөн үү сая? Энэ зарим төхөөрөмж дээр жоохон хоцрогдож очоод байна уу, үгүй юу тээ? Сүлжээний асуудал байх шиг байна. Яах вэ, явах уу тэгвэл?

Тэгвэл санал хураалтдаа орёё. Түрүүчийн томьёоллоо уншъя. Улсын Их Хурал, хүчингүй болгочихсон байгаа. Бямбацогт гишүүний гаргасан горимын саналаар төхөөрөмж шинэ, гишүүд маань бас бүрэн дасаагүй байгаа учраас түрүүчийн санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулъя гэсэн горимын санал гаргасан. Горимын саналаар эхлээд санал хураая. Дэмжье.

Зөвшөөрсөн 81, татгалзсан 6.

Тэгэхээр дахин санал хураалтыг явуулъя. Техникийн тохируулгыг бүрэн хийж дууссан. Иймд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын санал хураалтыг санал хураалтын төхөөрөмж ашиглан явуулах горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн 80, татгалзсан 7 гээд төхөөрөмжөөр санал хураах санал дэмжигдлээ.

Одоо Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана.

78 гишүүн дэмжиж, 9 хүн татгалзсанаар гарсан байна. Тийм байна. Энэ сая нэмэлт мэдээлэл ирж байна. Гишүүд дахин дахин уншуулснаас болоод төхөөрөмж гацаад 2 минутад ресет /reset/ хийгддэг юм байна. Тэгэхээр тэрийг хүлээхгүй бол болохгүй гэж хэлж байна. Тэгэхээр ер нь энэ төхөөрөмжтэй харьцахдаа удаа дараа уншуулах байдал бол бас төхөөрөмжөө гацаагаад байгаа ийм талтай юм байна шүү. Энэ шинэ төхөөрөмж суурилулагдсан учраас асуудал эцэслэн шийдвэрлэгдэх байх гэж ингэж бодож байна.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 78 гишүүн нь буюу 89.7 хувь нь дэмжсэн байна. 11 гишүүн татгалзсан байна. Ингээд Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүдийг яаралтай горимоор хэлэлцүүлэхийг Улсын Их Хурлын гишүүд дэмжлээ.

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж, хуулийн төслөө хэлэлцэж эхэлнэ.

Хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэх саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

08.27 цаг

**Хоёр дахь асуудал. Намын бүлгүүдийн бичгийг сүүлийн байдлаар авъя. Байнгын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай асуудал.**

Ингээд намын бүлгүүд болон бүлэггүй нам, эвслийн гишүүдээс бас санал, хүсэлтүүд ирсэн байгаа. Ингээд тэр хүсэлтийг нэгтгээд Улсын Их

Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”,

Ганбаатар гишүүн хоёулаа ээлжилж ярих уу? Эс үгүй бол та энд суугаад хурал хийе.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Болдын Уянга нарыг Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Бадрахын Найдалаа, Өлзийхүүгийн Шижир, Лутаагийн Энхнасан нарыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Пүрэвсүрэнгийн Наранбаярыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Наранцэцэгийн Алтаниагай, Сүхбаатарын Эрдэнэболд нарыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Баатаржавын Мөнхсоёл, Цэвэгдоржийн Туваан нарыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Жамбын Батсуурийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Очирбатын Амгаланбаатар, Тогмидын Доржханд, Бадамдоржийн Пунсалмаа нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Оюунсайханы Алтангэрэлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Цэндийн Баатархууг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2. Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаниагай, Нанзадын



Наранбаатар, Өлзийхүүгийн Шижир, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Болдын Уянгыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Очирбатын Амгаланбаатар, Бадрахын Найдалаа, Сүхбаатарын Эрдэнэбат нарыг Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны, Бадамдоржийн Пунсалмааг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Мөнгөнцогийн Ганхүлэг, Лутаагийн Энхнасанг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Өлзийхүүгийн Шижирийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Баатаржавын Мөнхсоёл, Банзрагчийн Түвшин, Даваагийн Цогтбаатар нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Хүрэлбаатарын Баасанжаргал, Сүхбаатарын Эрдэнэболд нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Жамбын Батсуурийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэндээ ингээд уншиж танилцууллаа.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна.

83.1 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Байнгын хорооны гишүүний бүрэлдэхүүн өнөөдөр өөрчлөлт орж байгаа. Өнөөдөр Засгийн газар бүрэлдэхүүнээ батлуулсантай холбогдуулан Байнгын хорооны бүрэлдэхүүнд дахиж өөрчлөлт орохоор байгаа. Тухайлбал, одоо Засгийн газрын гишүүнээр ажиллаж байгаа гишүүн Дэгийн тухай хуулиар зөвхөн 1 Байнгын хороонд харьяалагдахаар заагдсан байгаа.

Тэгэхээр Засгийн газрын гишүүнээс зарим Улсын Их Хурлын гишүүд чөлөөлөгдсөний дараа 2 дахь Байнгын хороондоо орох эрх нь нээгдэж байна.

Засгийн газрын гишүүд шинээр сонгогдоод явсны ард дээр 2 Байнгын хороонд байгаа гишүүд маань 1 Байнгын хорооноосоо чөлөөлөгдөх нөхцөл үүснэ. Тэгэхээр тэрийг нөхөж сонгох бусад Улсын Их Хурлын гишүүдийн ирсэн хүсэлтийг хангах боломж үүснэ гэдгийг бас энд тодруулж хэлье.

Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

**Б.Батбаатар:** Их Хурлын Тамгын газар маань манай гишүүдийн заримынх нь хүсэлтийг нь авалгүй орхиод, ер нь бол ярихгүй байна. Парламент 126 гишүүн. Үндсэн хуулиараа ч 126, Улсын Их Хурлын тухай хуулиараа ч 126 гишүүнийг парламент гэдэг гэж заачихсан байдаг. Тэгэхэд олонх, цөөнхийн бүлэг гэдэг л юм яригдаад байдаг. Бусад нь парламентын гишүүн биш, нэг ёсондоо парламентын бүрэлдэхүүн хэсэг биш аятай яваад байдаг. Одоо цаашилаад энэ Байнгын хороо, дэд хороо, Монголын парламентын бүлгэм, дараа дараагийн

ажлууд олонх, цөөнх гэдгээр явах юм бол энэ ерөөсөө болохгүй.

Парламент чинь өөрөө 5 намын 5 нам, эвслийн төлөөлөлтэй байгаа. Тэгэхээр парламентаа бид нар 126 гишүүнээс бүрдэнэ гэдэг Үндсэн хуулийн болон Улсын Их Хурлын тухай хуулийн агуулгаар нь бодохгүй бол уржигдар хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ч тэр, бусад зүйл дээр ч ярьж байгаа өнцөг нь дандаа олонх, цөөнх гэж байгаа. Тэгээд олонх, цөөнх чинь өөрөө алга болчихож байгаа шүү дээ. Нэг л том олонх болж байгаа шүү дээ одоо бүрдэж байгаа засгаараа. 126 гишүүний 118 гишүүн нь нийлээд 1 бүлэг болчихож байгаа. Засгийн газраа хамтарч байгуулна гэдэг Улсын Их Хурлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, энэ эвсэл болох асуудлууд чинь бүгд сөхөгдөөд яваад эхэлнэ.

Тийм болохоор тэр дээрээ Их Хурлын дарга тэр Тамгын газар эд нар дээрээ анхаармаар байна. Энэ саналыг ярих гэж өчигдөр Их Хурлын даргын өрөөний үүдэнд 2 удаа очсон. Орж чадаагүй. Төрийн тусгай хамгаалалтынхан утсаа хураалгуул, биеэ нэгжүүл гэдэг аятай л хандаад байдаг юм байна лээ. Тийм л зүйл хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Батбаатар гишүүнд энэ шинээр батлагдсан Дэгийг Улсын Их Хурлын Тамгын газраас сайтар танилцуулж өгөхийг Тамгын газарт даалгавар болгож байна. Дэгийн тухай хуулиар бүх зүйл зохицуулагдаж байгаа. Улсын Их Хуралд бүлэгтэй улс төрийн нам бүлгээрээ дамжуулж, бүлэггүй намын төлөөлөл, гишүүд өөрийн биеэр, өөрийн хүсэлтээр асуудалд хандах учиртай зохицуулалт байгаа.

Тэгэхээр мэдээж Улсын Их Хурлын гишүүдэд нэгдсэн зар хүргэх, зохион байгуулалт хийх ажил дээр Тамгын газар бол онцгой анхаарч ажиллах нь зүйтэй.

Нөгөө талаас гишүүд мэдээллийг өөрсдөө бас бүрэн авч, асуудлыг өөрсдийн туслахаар болон зөвлөхүүдээр дамжуулж Тамгын газартайгаа харилцаж явахыг бас хүсье.

Материалыг нь аваад томилоод эхэлчихсэн байх учиртай даа. Ингээд Батбаатар гишүүний хүсэлтийг хангаж өгнө.

Эцсийн найруулга дээр өөр асуулт, саналтай гишүүд байхгүй учраас сонссонд тооцлоо.

Одоо Байнгын хороод хуралдаж Байнгын хорооны даргыг сонгох тухай, дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудлуудыг, мөн Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж Байнгын хорооны даргыг сонгох тухай болон Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх ёстой тул хэлэлцэх ёстой. Энэ Ерөнхий нарийн бичгийн даргын асуудал чинь бас орох ёстой тийм ээ? Төрийн байгуулалтын байнгын хороогоор тийм ээ? Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын асуудлыг хэлэлцэх учраас чуулганы хуралдааныг түр завсарлуулъя.

08.37 цаг

Мягмар гараг, 09 Долоодугаар сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
14 цаг 53 минут.

**Д.Амарбаясгалан:** Үдээс хойших хуралдааныг эхлүүлъя.

**Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэж эхэлъя.**



Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх саналыг Улсын Их Хурлын дарга танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршилагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилуулахаар санал оруулж байна.

Барсүрэнгийн Баасандорж нь 1979 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.

1987-1997 онд нийслэлийн 5 дугаар дунд сургуулийг, 1997-2001 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр, 2009-2011 онд АНУ-ын Калифорнийн Олон улсын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Ажлын туршилага 2001-2002 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын туслах

2002-2006 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Хуулийн хэлтсийн шинжээч

2006-2008 онд Хууль зүйн байнгын хорооны референт

2008-2009 онд Хууль зүйн байнгын хорооны зөвлөх

2011-2013 онд Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

2013-2015 онд Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газрын дарга

2015-2018 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

2018-2020 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга

2020-2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

2022-2023 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга

2023 оноос одоог хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргаар ажиллаж байна.

Баасандорж нь төрийн албанд 23 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлж батлуулах чиглэлээр 16 жил, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 5 жил, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр 2 жил, үүнээс төрийн албаны удирдах албан тушаалд 15 жил тус тус ажилласан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршилагатай байх шаардлагыг бүрэн хангаж байгаа нэр дэвшигч болно.

Төрийн албанд гүйцэтгэх албан тушаалаас удирдах албан тушаал хүртэл шатлан дэвшиж ажилласан. Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ажиллаж байсан туршилагатай.

Хүний эрхийн салбар, нийтийн мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийг хангах, шүүхийн шинэтгэл, улсын бүртгэлийн шинэтгэлийн зэрэг хууль

тогтоомжийн төслүүдийг боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулж байсан.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 126 гишүүнтэй парламент хувь тэнцүүлсэн болон олонхын сонгуулийн тогтолцооны өөрчлөлтийн төслийг боловсруулах болон иргэд олон нийтээр хэлэлцүүлэх Засгийн газрын дэд ажлын хэсгийг ахалж ажилласан.

Мөн төрийн захиргааны үйл ажиллагаа төрийн үйлчилгээнд процесс суурьтай, оновчтой, үр дүнтэй засаглалыг бэхжүүлэх зорилгоор гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын хүрээнд процессын дахин инженерчлэлийг эхлүүлж, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбар, эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, ирээдүйн загварыг гаргах ажлыг амжилттай хэрэгжүүлж ажилласан.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилуулах саналыг танилцуулж байна.

Уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн Улсын Их

Хурлын даргаас Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилуулах саналыг 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн болно.

Улсын Их Хурлын даргын дээрх саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар танилцуулж байна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Дамдины Энхбатыг чөлөөлөх тухай саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж, байр сууриа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилох, чөлөөлөх тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Барсүрэнгийн Баасандорж хүрэлцэн ирсэн байна.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Байвал нэрээ өгье. Дараачийн удаа. Асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

*Байхгүй байна уу? За тасаллаа. Айн? Энэ миний дэлгэц дээр гарахгүй байх юм.*

*Ингээд Батын Батбаатар гишүүнээр тасаллаа. 3 гишүүн асуулт асууж, үг хэлэх нь байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн. Пүрэвжавын Сайнзориг гишүүний микрофоныг өгье.*

**П.Сайнзориг:** *Гишүүддээ бас энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Баасандорж даргыг дэмжиж байна. Бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор холимог тогтолцоогоор сонгогдсон энэ 126 гишүүнтэй парламентын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллах ажлын дадлага, туршлага, бүх зүйл байгаа гэдэгт итгээж байгаа. Би нэр дэвшигчээс 2 асуулт л асуумаар байгаа юм.*

*Өнөөдөр Улсын Их Хурлын энэ Байнгын хороодын чиг үүрэгтэй холбоотой асуудлуудыг бас эргэж харах энэ асуудал Ерөнхий нарийн бичгийн дарга бас саналаа холбогдох Байнгын хороонд оруулах эрхтэй байж байгаа.*

*Ялангуяа Эдийн засгийн байнгын хороон дээр өнөөдөр өмчийн суурь харилцаа болох газрын хуулиуд ингээд хамааралтай байдаг. Энэ 2002 онд Газрын багц хууль хийснээс хойш шинэчлэлийн асуудлыг яриад ерөөсөө энэ Байнгын хороон дээрээ өнгөрсөн жилүүдэд таг гацдаг байсан. Тэгээд энэ хууль өөрөө эргээд Хууль зүйн байнгын хорооны буюу хууль зүйн үр дагавар дагуулсан ийм асуудлууд байгаа. Тэгэхээр ядаж үндсэндээ газрын ерөнхий хуулийг Хууль зүйн байнгын хороо эсвэл Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцдэг байх энэ өөрчлөлтийг зайлшгүй хийх ёстой гэж бас харж байгаа юм.*

*Энэ өөрөө эргээд газрын асуудал өмчийн харилцаанаас гадна, төрийн байгууламжийн нэгдмэл байдлыг хангах уу, үгүй юу гэдэг энэ асуудал байдаг.*

*Дээрээс нь яг Хууль зүйн байнгын хороонд хамааралтай компанийн гэдэг юм уу, төрийн өмчийн компанийн засаглалын асуудлууд бүгд Эдийн засгийн байнгын хороон дээр бас харьяалагддаг. Бас уг асуудлууд ерөөсөө явдаггүй ийм зүйлүүд байна.*

*Эргээд бизнест орж болж байгаа. Бизнес ороход бол манайд гайгүй. Бизнесээс гарах буюу тэр дампуурал төлбөрийн чадваргүйдлийн харилцаа бас Хууль зүйн байнгын хорооны буюу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үргэлжлэл байдаг. Энэ ажиллагаа бас Эдийн засгийн байнгын хороон дээр явдаг, бас асуудлууд нь ерөөсөө шийдэгддэггүй. 1997 онд батлагдсан Дампуурлын хуулиа бид нар шинэчлэх гээд үндсэндээ 4, 5 жилийн өмнө хууль өргөн бариад ингээд явдаггүй ингээд гацчихсан ийм зүйлүүд байх юм.*

*Энэ нь өөрөө эргээд Монгол Улсыг бас бизнес эрхлэхийн индексээр хойш татаад байгаа маш олон реформууд Хууль зүйн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хорооны асуудлууд Эдийн засгийн байнгын хороонд хамааралтай бөгөөд ингээд хавсарга байдлаар үлддэг энэ асуудлыг засах тийм бололцоо энэ тэр дээр нь бас судалж үзэх, энэ дээр өөрийн чинь байр суурийг бас сонсъё гэж бодож байна.*

*Хоёрдугаарт, энэ Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаа дээр зөвлөхүүдийн үйл ажиллагаа гэдэг энэ Байнгын хороо ажлын хэсгүүдийн ажиллах нөхцөл байдлуудыг ерөөсөө хангаж байгаа хамгийн том хөшүүрэг байж байгаа. Энэ дээр зөвлөхүүд үндсэндээ ингээд тойргийн зарчмаар ажиллаад байгаа. Хуучин бол Байнгын хороо болгон өөрсдөө ийм мэргэшсэн зөвлөхтэй байдаг байсан. Яг Хууль зүйн байнгын хороо тэн дээр 2-3 мэргэшсэн зөвлөх байдаг. Эдийн засаг төсөв мөн адил. Одоо ингээд орж ирж байгаа хуулиуд ингээд яг тухайн асуудалтай мэргэшил гэдэг юм уу, ажиллаж байсан*

туришлагын хувьд хамааралгүй ингээд зөвлөхүүдэд хуваарилагдчихдаг. Асуудлаа судлах гэдэг ч юм уу ийм байх юм.

Тэгэхээр энэ дээр бүтцийн өөрчлөлт гэдэг юм уу энэ талаас нь бас харах, бодолцох зүйл байгаа гэдэг зүйлийг ийм 2 асуулт асууя.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн 23 дугаар микрофоныг өгье.

**Б.Баасандорж:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд дээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Үндсэн 2 асуулт асууж байна. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга гэдэг яг Их Хурлын тухай хуулиараа дэгийн зөвлөх гэж явж байгаа нэгдүгээр чиг үүрэг нь. Тэгээд яг дэгийн асуудлаар хэрвээ Улсын Их Хурлын гишүүд маань итгэл үзүүлээд намайг томилох юм бол яг Их Хурлын тухай хуульд заасан журмын дагуу Ёс зүй, дэгийн байнгын хороонд дэгийн асуудлаар саналаа өгнө гэж бодож байгаа. Би сая Сайнзориг гишүүний асуусан тэр газрын асуудал, төрийн өмчтэй холбоотой асуудал, ялангуяа дампууралтай холбоотой асуудлууд, төрийн өмч болон ТӨК-тай холбоотой асуудлууд байна. Энэ бол ялт ч үгүй яг Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ёстой гэдэг дээр бол санал нэг байна. Би өөрөө Хууль зүйн байнгын хороонд Их Хурлын Тамгын газар 2005 оноос 2018 хүртэл ажиллаж байсан.

Мөн яг газрын асуудлыг хараад үзэхээр газрын асуудал маань өөрөө 3 газар хуваагдчихсан байдаг. Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо гээд 3 хуваагдсан байдаг. Хууль зүйн байнгын хороон дээрээ байдаггүй. Тэгэхээр энэ асуудлаар яг эрх хэмжээнийхээ хүрээнд Их Хурлын

гишүүдтэйгээ хамтарч ажиллаад саналаа өгөхөд бол бэлэн байна гэдгийг Сайнзориг гишүүндээ хэлье.

Мөн энэ мэргэшсэн, парламентын мэргэшсэн ажлын албатай холбоотой асуудал асууж байна. Энэ бол яг чухал. Яг олон улсад мэргэшсэн парламентын тогтолцоо нь өөрөө Байнгын хороодын ажлын албаараа их явдаг.

Ялангуяа мэргэшсэн парламент нь өөрөө Байнгын хороод нь илүү мэргэших ёстой байдаг. Яг салбар салбараараа. 11 салбарын Байнгын хороо байгаа бол 11 салбарын Байнгын хороодын ажлын албууд өөрсдөө мэргэших ёстой байдаг. Мөн үүнийгээ дагаад энэ 126 гишүүний анхны Тамгын газар одоо яг ажиллах гэж байна. Тэгэхээр энэ Тамгын газар маань өөрөө яг процесс суурьтай, оновчтой бүтэц, тогтолцоотой байх ёстой.

Өөрөөр хэлбэл, энэ Тамгын газрын маань процесс нь 126 гишүүн рүүгээ 11 Байнгын хороод руугаа оновчтой хууль тогтоох процесс нь өөрөө оновчтой байна уу, хяналт тавих Үндсэн хуулиар заасан Их Хурал өөрөө 18 онцгой бүрэн эрхтэй. Үүний 1, 2-т нь хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих гэсэн онцгой 2 бүрэн эрх байдаг. Энэ 2 хяналтыг хууль тогтоох, эрх хэрэгжилтийг хийх процесс нь өөрөө оновчтой байна уу, бүтэц зохион байгуулалт, тогтолцоо нь өөрөө оновчтой байна уу гэдэг дээр өөрөө процессын дахин инженерчлэлийн хүрээнд бас онцгой анхаарч ажиллана. Үүнийгээ оновчтой хийж чадах юм бол өөрөө тэр зөвлөхүүд нь, референтүүд нь өөрөө оновчтой процесс хэрвээ бий болгож чадах юм бол сайн, муу зөвлөхүүд, мэргэшсэн, мэргэшээгүй албан хаагчид маань өөрөө ялгараад гараад ирнэ гэдэг дээр үзэж байгаа, бодож байгаа.

**Д.Амарбаясгалан:** Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна.



**Х.Баасанжаргал:** Хоёр санал давхар хэлчихье. Түрүүн Сайнзориг хуульчийн хэлсэн дээр нэмэх нь Арилжааны хууль тогтоомжуудын асуудлыг бас анхаараад Байнгын хорооны харьяаллынх нь асуудлыг бас гаргаарай гэсэн үг.

Хоёрдугаарт гэвэл Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын энэ албан тушаал нь өөрөө улс төрийн албан тушаалтнуудтай харилцах, өөрөөр хэлбэл энэ удаагийн сонгуулийн үр дүн, сонгуулийн хэн олонх болсон тэр улс төрийн намын ийм бас холбоотой буюу өөрөөр хэлбэл улс төрийн албан тушаалтнуудтай ингэж харилцах ийм албан тушаал байгаа.

Тэгэхээр цаашид Улсын Их Хурлын Тамгын газар гээд энэ бүтцийн асуудлууд, тэнд ажиллах төрийн албан хаагчдын асуудлууд, тэд нарын төрийн албан хаагчдын ангиллын асуудлууд яригдана. Тэгэхээр энэ нөхцөл байдлыг бас харгалзаж үзэх ёстой болов уу гэж бодож байна.

Хамгийн сүүлд нь, гуравдугаарт нь Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль хоёр хоёулаа шинэчилсэн найруулгаар батлагдсан. Бид бид нарт цаасаар тараагдаж өгсөн байгаа. Тэгээд үүнтэй холбоотой нарийвчилсан заавар, дүрэм, журам бас яг шинээр томилогдсон Их Хурлын гишүүдэд ямар ч тийм заавар ерөөсөө огт өгөөгүй байгаа. Тэгэхээр энэ дээр бас даруйхан бас арга хэмжээ аваасай гэдэг ийм хүсэлттэй байна. 3 санал.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн 23 дугаар микрофоныг өгье.

**Б.Баасандорж:** Баасанжаргал гишүүн сая санал, 3 санал хэллээ. Тэгээд би Баасанжаргал гишүүнтэй санал нэг байна. Яг Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнд байгуулагддаг байгууллагын

бүтэц, зохион байгуулалт нь өөрөө төрийн захиргааны бусад байгууллагаа бодвол өөрөө бас харьцангуй онцлогтой байх ёстой гэдэг дээр би тантай санал нэг байна.

Яагаад гэвэл бусад төрийн захиргааг бодвол яг Улсын Их Хурал гэдэг юм уу, Ерөнхийлөгчийн институт гэдэг юм уу эд нар энэ хоёроос бусад нь дандаа өөр журмаар явдаг. Энэ байгууллагууд манай Улсын Их Хурлын сонгуулийн үр дүн байгуулагддаг. Тэгэхээр энэ дээр бүтэц, зохион байгуулалт нь харьцангуй бусад байгууллагуудаасаа өөр онцлогтой байх ёстой гэдэг дээр санал нэг байна.

Дэгийн асуудал дээр, Их Хурлын асуудал дээр Улсын Их Хурал Улсын Их Хурлын гишүүдэд Тамгын газрын зүгээс дэмжлэг үзүүлэх, тогтолцоог оновчтой зохион байгуулалттай болгох тал дээр бүх талын би оролцоог хангаж ажиллана гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Батбаатар:** Асуулт гэхээр юм ч алга даа. Улсын Их Хурал бол бага ард түмэн гэж ярьдаг. Төлөөллийн төв байгууллага. Нийт ард түмнийг төлөөлж байгаа. Үндсэн хуулиараа төрийн эрх барих дээд байгууллага. Тэгэхээр Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын хууль санаачлах, хэлэлцэх, тогтоох энэ процесст дэмжлэг үзүүлж ажиллахдаа мөн Улсын Их Хуралд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахад нь зөв зүйтэй талаас нь тусалж дэмжээд, тэгээд анзаарч нэг зүйлийг ажиллаасай гэж бодож байна.

Манай Их Хурлын дарга бол улс төрийн нам, кабинетын зарчмаар ажилладаг Засгийн газарт ажиллаж байсан урьд нь парламентад сонгогдож байгаагүй. Тийм учраас төлөөллийн төв байгууллага гэдэг талаасаа, ард түмний төлөөлөл энд суучихсан байгаа гээд гэдэг талаасаа хандахгүй байх алдаа гаргах

вий тэрэнд нь хажууд нь сайн тусалж, дэмжиж, өрөөнд нь шивнэх зүйл байвал шивнээд тэгээд ажиллаж байгаасай л гэж хүсэж байна. Өөр юм алга даа.

**Д.Амарбаясгалан:** Асуулт байсангүй санал хэлчихлээ. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа, санал хэллээ. Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулах юм байна.

Тэгэхээр энэ хуулиараа нууцаар санал хураадаг ийм дэгтэй юм байна. Тэрнээс өмнө Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Дамдины Энхбатыг чөлөөлөх асуудлаар санал хураалтыг явуулах юм байна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Дамдины Энхбатыг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалтыг явуулна. Ингэхийн тулд эхлээд нууц санал хураалтыг бас анх удаа явуулах гэж байгаа учраас 2 удаа тест хийж үзэх нь зүйтэй байх гэж ингэж бодож байна. Ингээд тестийн санал хураалтыг явуулъя.

2 дахь туршилтын санал хураалтыг явуулъя.

Баярлалаа. Ингээд Дамдины Энхбатыг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна.

Энэ систем гацчихлаа. Дахиж эхлүүлэх үү? Гацчихлаа. Төхөөрөмж гацсан тул саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Бас гацчихлаа. Яах вэ? Бүх гишүүдийн дэлгэцэн дээр гацчихсан. Энэ гацаад байгаа учраас туршилтын санал хураалтыг дахиж явуулж үзье.

Тэгэхээр түрүүн санал хураалт төхөөрөмж гацсан учраас санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя.

63.5 хувиар санал хураалт хүчингүй боллоо. Энэ дунд нь жосоохон паузтай явахгүй бол төхөөрөмж нь хурд нь гүйцэхгүй байх шиг байна.

Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Дамдины Энхбатыг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя.

65.4 хувиар санал дэмжигдлээ.

Чөлөөлөх саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол. “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Ингээд тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Одоо шинээр Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох санал хураалтыг явуулна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Барсүрэнгийн Баасандоржийг томилох саналыг дэмжжэ гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулна. Санал хураалтыг эхлүүлэе.

67.6 хувиар санал дэмжигдлээ.

Томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Та бүхэнд тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн III дүгээр зүйлийн III.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа. Эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Уучлаарай Эрдэнэболд гишүүн. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

**С.Эрдэнэболд:** Түрүүн танд хэлсэн сая энэ нь гацсаар, будилсаар байгаад л би эсрэг саналд тооцогдчихлоо. Түрүүн Засгийн газрын бүтцийн асуудал орж ирсэн бас гацсаар байгаад л эсрэг саналд тооцогдчихлоо. Технологиос болоод дэмжээд дэмжихгүй байгаа юм шиг ингээд шууд уншигдаад байна. Тэгээд энэ асуудлыг энэ технологийнхон шийдэхгүй болохлоор. Наадах чинь сая 67 хувиар батлагдсан гээд байгаа. Тэгээд би дэмжжэ гэсэн тэгээд яс юман дээрээ өөр болчихоод байгаа байхгүй юу. Энэ технологийн асуудлаа шийдэж байж та яг алхаа цохиоч.

**Д.Амарбаясгалан:** Тэгэхээр энэ санал хураалтын төхөөрөмжийн үйл ажиллагаа жигдрээгүй байгаатай холбоотой зарим Улсын Их Хурлын гишүүдийн санал буруу гарч байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийн саналын дагуу протоколд саналыг засварлаж оруулахыг бас Тамгын газрын ажилчдад даалгая.

15.19 цаг

**Зарим Байнгын хороодын даргыг сонгох тухай асуудал руу орё. Хэлэлцэх асуудлын дарааллаар.**

Аж үйлдвэржилтийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Батбаяр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дараах

санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл нар Улсын Их Хуралд сонгогдсон, сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ.

С.Ганбаатар нь 1970 онд Баянхонгор аймгийн Баянхонгор сумд төрсөн 54 настай, эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр 1988 онд Баянхонгор аймгийн 1 дүгээр 10 жилийн дунд сургууль, 2010 онд Хөдөлмөрийн дээд сургуулийг Хөдөлмөрийн эдийн засагч мэргэжлээр төгссөн. Эдийн засгийн магистр.

С.Ганбаатар нь 2001-2002 онд “Хаан” банканд Тусгай академийн газрын захирал, 2002-2003 онд Санхүү, эдийн засгийн дээд сургуульд багш, 2003-2004 онд Удирдлагын академид багш, 2004-2005 онд Улсын Их Хурлын даргын орон тооны бус зөвлөх, 2007-2012 онд Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч, Боловсрол, соёл, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны даргаар ажиллаж байсан бөгөөд 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр тус тус сонгогдсон.

Байнгын хорооны хуралдааны үед нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан нар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах

төрийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар болон малчдын орлогыг нэмэгдүүлэх, ЖДҮ-үүдийг хөгжүүлэх, төвийн бүсэд хөнгөн үйлдвэрүүдийг хөгжүүлэх боломжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг Байнгын хороо нь томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа аж үйлдвэржилтийн салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа ЖДҮ-лэл эрхлэгчдийг дэмжиж ажиллаж үйлдвэрлэгч улс болох, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад анхаарч, санхүү, татварын бодлогоор дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Үндэсний үйлдвэрлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжиж үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалт, зах зээлийг дэмжих бүтцийг бий болгоход анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал дэд бүтэц, усан хангамжийг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд хүнд, хөнгөн үйлдвэрүүдийн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагатай нягт хамтран ажиллах нь зүйтэй гэсэн саналуудыг хэлсэн болно.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатарыг нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын



хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

**Т.Аубакир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл нэр дэвшигчийн сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсенг дэвшүүлж хэлэлцүүлээ.

Мөн Байнгын хорооны хуралдаанд танхимаас Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн Пүрэвийн Батчимэг нэрээ дэвшүүлэн хэлэлцүүлсэн болно.

Буланы Бейсен нь 1972-1982 онд Өлгий сүмийн 10 жилийн 1 дүгээр сургууль, 1982-оос 1988 онд Анагаах ухааны дээд сургуулийг Хүний их эмчийн

мэргэжлээр төгссөн. Анагаах ухааны магистр, клиникийн профессор цолтой.

Бейсен нь 1989-1991 онд Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн Бөөрний мэс заслын их эмч, 1991-1995 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын их эмч, 1995-1998 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн эрхлэгч, 1998-2004 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын их эмч, 2004-2012 онд аймгийн Мэс заслын тасгийн эрхлэгч бөгөөд зөвлөх эмч, 2012-2016 онд Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга, 2016 оноос Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын зөвлөх эмч, 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Т.Аубакир, Б.Уянга, З.Мэндсайхан, Р.Сэддорж, Ц.Идэрбат, У.Отгонбаяр нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсенг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсенг нэр дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлт, “Байнгын хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*

**Д.Амарбаясгалан:** Одоо Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Дамдинням:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх асуудлыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар танилцуулаа.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм нь 1982 онд төрсөн. Англи, Орос, Япон хэлтэй. Нийслэлийн 23 дугаар сургуулиас сурагч солилцооны хөтөлбөрөөр АНУ-ын Терри Сенфорд ахлах сургуульд суралцаж, 1999 онд бүрэн дунд боловсрол эзэмисэн.

2004 онд ИБУИНВУ-д Олон улсын Америкийн их сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр, мөн сургуульд 2005 онд магистрын зэрэг тус тус хамгаалсан. 2010 онд Япон улсын Нагояа их сургуулийн Эдийн засгийн сургуульд Эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалжээ.

2010-13 онд Монгол улсын их сургуулийн Эдийн засгийн сургуульд ахлах багш, Тэнхимийн эрхлэгч, дэд профессор, 2013 оноос Монгол улсын их сургуулийн захиргаанд Сургалтын албаны дарга, 2017-18 онд Засаг захиргаа, дотоод хамтын ажиллагаа хариуцсан дэд

захирал, 18-20 онд Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирлаар тус тус ажилласан. 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах Боловсролын багц хуулийг хэлэлцэж батлаад орхигдсон хэд хэдэн заалтууд байгаад сайжруулалт болон нэмэлт, өөрчлөлт оруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн төсөлд шинжлэх ухааны салбарыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хариуцуулахаар оруулж ирсэнд ямар саналтай байгаа талаар асуулт асуусан бол Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат насан туршийн боловсролын асуудлыг соёл, спортын салбартай уялдуулан системтэйгээр сайжруулах анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хот, хөдөөгийн ялгааг арилгах тал дээр болон хуулийн хэрэгжилтийн талаар анхаарч боловсролын салбарт ажиллаж байгаа багш нарын нийгмийн баталгааг хангах, цалин хөлс, цаг үеэ дагаж тогтмол нэмэгдэж байх системийг нэвтрүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр Боловсролын багц хуулийн хэрэгжилтэд анхаарч, орхигдсон заалтуудыг засварлах шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар Байнгын хороонд хамааралтай шинжлэх ухаан, соёл, спортын салбарт нийгэмд орхигдож хоцрогдсон байгааг цаашид анхаарч ажиллах хэрэгтэй талаар, О.Саранчулуун насан туршийн боловсролд ахмад настнуудыг идэвхтэй хамруулж, соёл, спортын үйл ажиллагаанд хамруулж байх талаар, Д.Бум-Очир боловсролын салбар болон тэр дундаа ерөнхий боловсролын сургуульд хүний нөөцийн асуудал дутмаг байгааг анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах технологийн коллежийг хөгжүүлэх мөн шинээр сургуульд барих асуудалд анхаарч ажиллах талаар үг хэлсэн бөгөөд

Байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамыг нэр дэвшүүлсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, “Байнгын хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Одоо Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урьж байна.

**А.Ариунзаяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг тус Байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн саналаар Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар нь 1981 онд төрсөн. Тэрээр

1999, 1998 онд Нийслэлийн ерөнхий боловсролын 48 дугаар дунд сургуулийг дүүргэж, 2003, 2021 онуудад Шихихутуг хууль зүйн дээд сургуулийг төгссөн. Хууль зүйн ухааны магистр зэрэгтэй. 2021 оноос Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуульд докторантаар суралцаж байна. Эрх зүйч мэргэжилтэй.

Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар нь 2005-2008 онд Улсын Их Хурлын даргын ажлын албанд, 2008-2011 онд Улсын Их Хурлын Монгол Ардын намын бүлэгт ахлах референт, 2011-12 онд Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн Хэрэг эрхлэх газарт Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, 2012-2020 онд Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн, Хэрэг эрхлэх газрын намын зохион байгуулалтын хэлтэст Улс төрийн ахлах ажилтан, газрын дарга, 2020 оноос Монгол Ардын намын Хяналтын ерөнхий хорооны дарга, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үеэр нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүн Очирбат төрийн албан хаагчийн эрхийг хэрхэн хамгаалах, Улсын Их Хурлын гишүүдэд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир Улсын Их Хурлын гишүүний ёс зүй манай Байнгын хороонд хамаарч байгаа тул бид бусад гишүүдээ ёс зүйн хувьд манлайлан ажиллаж, парламенттай үлгэр дуурайллыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал ажлаа хэмжиж эхлэх, Улсын Их Хурлын гишүүний ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг анхаарах хэрэгтэй байгааг илэрхийлж үг хэлсэн болно.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарыг нэр дэвшүүлснийг

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарыг нэр дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Одоо Инновац цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Арай бэлэн болоогүй байна уу? Нийгмийн бодлогын байнгын хорооны бэлэн байгаа юу танилцуулга материал? Бэлэн болсон байгаагаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даицэрэнгийн Энхтүвшин уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Энхтүвшин:** Монгол Улсын Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга

О.Цогтгэрэл нар нэр дэвшигчийн төрд ажилласан хугацаа туршилагыг нь харгалзан Эдийн засгийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэددоржийг сонгохоор нэр дэвшүүлж хэлэлцүүлээ.

Ренчинбямбын Сэددорж нь 1997 онд Өмнөговь аймгийн Даланзадгад хотын 10 жилийн дунд сургууль, 2002 онд Хан-Уул дээд сургуулийг Бизнесийн эдийн засагч, Хэрэглээний математикийн бакалавр мэргэжлээр, 2008 онд Монгол Улсын Засгийн газрын харьяа Удирдлагын академийг нийгмийн ухааны магистраар тус тус төгссөн байна.

Сэددорж нь 2002-2022, 2026 онд “Ажна” корпорацийн төслийн менежер, 2004-2007 онд Улсын Их Хурлын гишүүний туслах, би төлөөлөгч, 2009-2010 онд Тавантолгой ХК-д Санхүү, хангамж хариуцсан дэд захирал, 2020 оноос Өмнөговь аймгийн Засаг дарга, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үед нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл эх орны хөгжлийг түргэтгэх томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, Улаанбаатар хотод тулгамдаад байгаа асуудал дээр анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх болон хувийн хэвшлийг дэмжин ажиллах, хувийн эрх зүйн асуудлыг сайжруулах, хуулийн хэрэгжилтийг хангах, хангаж ажиллахад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар хууль зөрчсөн асуудлуудад хатуу байр суурьтай байх гэсэн саналуудыг хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Сэددоржийг Эдийн засгийн байнгын хорооны даргаар сонгохоор нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.



Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Одоо Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаа уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Х.Болормаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 7 сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга Пүрэвжавын Ганзориг нэр дэвшигчийн төрийн албаны ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Лутаа овогтой Энхнасанг нэр дэвшүүлж хэлэлцүүлээ.

Энхнасан нь 1972 онд Улаанбаатар хотод төрсөн. 52 настай 1 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр 1980-1990 онд Улаанбаатар хот дахь Зөвлөлтийн 3 дугаар дунд сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1994-1996 онд Япон улсын Сундай коллеж

Аялал жуулчлалын менежмент, 2005-2007 онд Австрали улсын Монашийн их сургууль Олон улсын аялал жуулчлал магистр, 2012 онд Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Бизнесийн удирдлагын магистр, бакалавр мэргэжлээр төгссөн.

Л.Энхнасан нь 1990-93 онд Японы “Иточичи” корпорацийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, нарийн бичгийн дарга, 2000-2005 онд Дэд бүтцийн яамны Зам, тээвэр, мэдээлэл холбоо, аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар Аялал жуулчлалын салбар хариуцсан мэргэжилтэн, 2007-2009 онд Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар Аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн яамны, уучлаарай Аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын орлогч дарга, 2010-2020, 2024 онд “Тахько” ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

Байнгын хорооны хуралдааны үед нэр дэвшигчээс Монгол Улсын Их Хурлын гишүүн Зулпхар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар хийж гүйцэтгэсэн ажлын туршилагын талаар болон цаашид ажиллах чиглэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат Нийгмийн олон талт түншлэлийн эрх тэгш оролцоог хэрхэн ханган ажиллах талаар тус тус асууж, хариулт авлаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Баатархүү даатгалын салбарын тухай хууль тогтоомжид реформ хийж, хувийн хэвшлийнхнийг идэвхтэй оролцуулах, Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийг анхааран ажиллаж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх, хүүхдийн хөгжил, бүтээмжийг анхааран инновацлаг бүтээн байгуулалтыг дэмжих талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат Хүний хөгжил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд тоонд биш чанарт анхааралд хандуулан ажиллах талаар, Улсын Их

Хурлын гишүүн Чинбүрэн эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэлийн онцлогийг онцгой харж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа халамжийг хавтгайруулах биш, нийгмийн зорилгод бүлгийн зайлиггүй халамж шаардлагатай иргэндээ хүрсэн халамжийн бодлого хэрэгжүүлэх болон хөдөлмөрийн зах зээлийг либералчлах асуудлыг анхааран ажиллах талаар тус тус саналаа илэрхийллээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Лутаагийн Энхнасанг дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 77.7 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргын сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Хуралдаан даргалагч Бейсен.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Энэ Байнгын хорооны юм бэлэн болж уу? Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Соронзонболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг Инновац,

цахим бодлогын байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, ХҮН намын Ерөнхий нарийн бичгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нар Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалыг нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ.

Жаргалсайханы Золжаргал нь 1979 онд Хөвсгөл аймагт төрсөн. Боловсрол 1994-2004 онд Санкт-Петербургийн Уул уурхайн дээд сургуулийг инженер, 2008-2010 онд Токиогийн Технологийн дээд сургуулийг инженерийн магистраар төгссөн. Орос, Англи хэлтэй. 2005 онд Хятадын Нефтийн их сургууль, 2009 онд Токио дахь НҮБ-ын их сургууль, 2011 онд Австралийн Бриспан хотын “Мега” төслийн менежментээр төгссөн байна.

2010-2016 онд Германы техник технологийн тусалцааны байгууллага буюу “Жи Ай Зэт”-ийн Улаанбаатар дахь Олборлох салбарын төслийн хэрэгжүүлэлт ба хөтөлбөрийг курс хөтөлбөрүүдийг тус тус төгссөн байна.

Ажлын туршилагын хувьд 2004-2017 оны хооронд “Монголын Алт” компанид инженер, Технологийн судалгааны төвийн захирал, төслийн менежерээр тус тус ажилласан байна.

2017-2018 онд Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагад шинжээч, зөвлөхөөр, 2018-2019 онд “И Би Ар Ди” Улаанбаатар хотын Ногоон хөгжлийн хөтөлбөрийн төслийн зөвлөхөөр, 2018-2019 онд Эрдэнэс Тавантолгой ХХК-д зөвлөхөөр, 2019 оноос Нүүрс ассоциацийн

гүйцэтгэх захирлаар тус тус ажилласан байна. Мөн түлш, эрчим хүчний семинарыг санаачлагч, зохион байгуулагч, 2016-2017 оноос хойш Үндэсний олон нийтийн телевизийн Монгол инженер нэвтрүүлгийн зөвлөх, хөтлөгчөөр. Мөн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд тээврийн салбарын хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг автоматжуулах цахим платформыг бас хөгжүүлсэн байна. Гэр хорооллын барилгын хүлэмжийн хийн ялгарлын тооцооллын цахим систем бүтээх ажлыг ахалж ажилласан туршилагатай. Инновац, технологийн мэдлэг түгээх чиглэлээр бас инженерийн шийдэл нэвтрүүлгийг хөтөлж байгаа мэргэжилтэн байна.

Жаргалсайханы Золжаргал нь Санкт Петербургийн Ууул уурхайн дээд сургуулийг, энд уншигчсан юм байна.

Улсын Их Хурлын гишүүн Заяабал төрийн үйл ажиллагааг ил тод, олон нийтэд ил тод болгоход Цахим бодлого, инновацын байнгын хороо онцгой манлайлан ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг энэ Байнгын хорооны чиг үүрэг авлигатай тэмцэхэд хамгийн чухал үүрэгтэй байх талаар тус тус саналаа хэлсэн байна.

Цаашилаад шүүхийн байгууллага, цахим архивын үйл ажиллагааг цахимжуулах шаардлагатай байгаа талаар саналуудаа хэлсэн байна.

Инновац цахим бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалыг нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 86.7 хувийн саналаар дэмжлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын

хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд 6 Байнгын хорооны дарга нэр дэвшлээ. Үлдсэн Байнгын хороодыг өнөөдөр анхдугаар чуулган завсарлахаас өмнө эцэслэн шийдвэрлэхээр байгаа. Тэгэхээр үлдсэн Байнгын хороодын хуралдаанд анхаарлаа хандуулах нь зөв байх. Ингээд нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Бум-Очир гишүүнээр тасаллаа. Эрдэнэболд гишүүн ороод ирлээ шүү. Эрдэнэболд гишүүнээр. Туршиж үзээд байгаа юм уу? Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. 1 гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

**С.Эрдэнэболд:** Персийн булан шиг юм юм нь ажиллахгүй булангийн хязгаараас ярьж байна. Цахим, бодлого гэдэг дээр манайхан ингээд технологи талаасаа илүү их бодоод байдаг. Дээрээс нь болохоор энийг илүү тийм залуучуудын энтертайнмент гэж бодоод байдаг. Манай Учрал сайд ч юм уу, Батиугар гишүүн яг энэ чиглэлээр ажиллаж байхдаа бол яг иргэдэд хүртээмж гэдэг талаас нь бололцооны ажилласан гэж харж байгаа. Тэгэхээр яг энэ Байнгын хорооны тал тал дээр бол энэ авлигыг бууруулах чиглэл рүү нь хэр зэрэг яаж ажиллах вэ? Энэ цахим гэдэг чинь бол субъектив хүний хүчин зүйлээс хамаарал багатай, цаашилаад улс сонгуулиа хүртэл бид нар ингээд цахимаар өгдөг байх, цаашилаад энэ ардчиллыг бэхжүүлэх авлигын индексийг бууруулах чиглэл дээр яг энэ боломжуудыг яаж ашиглах вэ гэдэг тал дээр Золжаргал Байнгын хорооны даргаас байр суурийг нь сонсмоор байна.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Улсын Их Хурлын гишүүн Золжаргалын микрофоныг өгье.

**Ж.Золжаргал:** Баярлалаа. Заяабал гишүүний хэлсэн коммент захиастай бас ойролцоо зүйлийг та хэллээ. Тэгээд төрийн үйлчилгээг цахимжуулах и-монголиа-г сайжруулах талаар түрүүчийн Засгийн газрын бүрэн эрхийн хугацааны төгсгөлд нэлээн их ажлууд хийгдсэн юм билээ. Байнгын хорооны хуралдаан дээр бас бид нар мэдээлэл солилцсон. Тэгэхээр тэр ажлуудыг үргэлжлүүлж явуулах, тэгээд манай эдийн засгийн хамгийн гол том салбар болсон энэ олборлох салбарын ил тод байдлын талаар, дээрээс нь олборлолт, тээвэрлэлт, хил гаалийн үйл ажиллагааг бүхлээр нь бүртгэх тээврийн салбарын цахим нэгдсэн систем нэвтрүүлэх гээд эдгээрийг хийж чадах юм бол тэрэнтэй холбоотой авлигын асуудлууд маш их тийм будилаантай зүйл болсныг бид нар мэдэж байгаа шүү дээ. Тэр дээр бол нэлээн их тийм томоохон цэгцрэлт хийгдэх болов уу гэсэн хүлээлттэй байна.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Одоо санал хураалт явуулъя. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар Сайнхүүгийн Ганбаатарыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Ил. Хурууны хээ орсонгүй ээ.

55.8 хувиар дэмжигдлээ.

Одоо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Буланы Бейсенийг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Минийх орохоо байчихлаа, миний энэ гагцхилаа. Минийх гацаад байна шүү тоног төхөөрөмж. Дэмжсэн санал өгсөн байгаа.

Ингээд 69 хувиар дэмжигдлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороон даргаар Чинбатын Ундрамыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

Минийх бүр гагцхиаад байна шүү. Санал дээр төхөөрөмж гацаад татгалзсан санал дээр гараад байгаа гишүүд бас протоколд нэрсээ өгөөд саналаа засуулж болно.

Ингээд 65.5 хувиар дэмжигдлээ.

Ёс зүй, дэгийн байнгын хороон даргаар Баярмагнай Баярбаатарыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

70.8 хувиар дэмжигдлээ.

Инновац, цахим бодлогын байнгын хороон даргаар Жаргалсайханы Золжаргалыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

69 хувиар дэмжигдлээ.

Энэ чинь Инновац, цахим бодлогыг хураагаагүй тээ? Сая хураасан тийм.

Энд одоо Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Лутаагийн Энхнасанг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна.

64.6 хувиар дэмжигдлээ.

Одоо Эдийн засгийн байнгын хорооны даргаар Ренчинбямбын Сэддоржийг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

63.7 хувиар дэмжигдлээ.



Ингээд Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцлоо.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Зарим байнгын хорооны дарга нарыг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэгт санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Улсын Их Хурлын зарим Байнгын хорооны даргаар дараах Их Хурлын гишүүдийг сонгосугай.

1.Аж үйлдвэржилтийн байнгын хорооны даргаар Сайнхүүгийн Ганбаатар.

2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Буланы Бейсен.

3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар Чинбатын Ундрам.

4.Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргаар Баярмагнайн Баярбаатар.

5.Инновац цахим бодлогын байнгын хорооны даргаар Жаргалсайханы Золжаргал.

6.Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Лутаагийн Энхнасан.

7.Эдийн засгийн байнгын хорооны даргаар Ренчинбямбын Сэддорж.

2.Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Тэгвэл эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

Байнгын хорооны дарга нартаа ажлын өндөр амжилтыг хүсье.

Зарим дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудал байгаа. Хуралдаж дуусаагүй байгаа учраас хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж дараачийн асуудал руу оръё.

15.59 цаг

**Дараачийн асуудал нь “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна.**

Тогтоолын төслийг хэлэлцэнэ. Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна. Индрийн микрофон өгье.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсгийг үндэслэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 7 сарын 9-ний өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын

төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд Тангараг өргөх журмыг Улсын Их Хурал батална гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журамд Засгийн газрын гишүүн тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүд давтан хэлэх, мөн нөхөн томилогдсон тохиолдолд тангаргийг ганцаар өргөж болохоор өөрчлөх зохицуулалтыг тусган тогтоолын төслийг боловсруулсан болно.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар асуулт асууж, байр сууриа илэрхийлсэн болно.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа.  
Ингээд Байнгын хорооны санал,

дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгөхийг хүсье.

Алга байна.

Ингэхээр “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ тогтоол нь 67.3 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.  
Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Журам батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тогтоолын үндэслэх хэсгийн болон тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 1 дэх заалтын 31 дүгээр гэснийг 27 дугаар гэж мөн журмын 10 дахь заалтын Засгийн газрын гишүүн тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу тангаргийг ээлжээр уншина гэснийг Засгийн газрын гишүүд тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлнэ.

Засгийн газрын гишүүн нөхөн томилогдсон тохиолдолд тангаргийг ганцаар өргөж болно гэж өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдах тул чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулъя.

Даргын дэргэдэх зөвлөл хуралдаж хууль, тогтоол хэлэлцэх үед асуулт асуух, санал хэлэх, журам батлах учиртай байгаа. Тийм учраас Даргын дэргэдэх зөвлөлийн хурал дуустал чуулган түр завсарлалаа.

16.03 цаг

Мягмар гараг, 09 Долоодугаар сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
18 цаг 45 минут.

**Д.Амарбаясгалан:** Олон сонгогдсон гишүүд танхимд.

**Х.Булгантуяа:** Урьдчилан сэргийлэх, Тэн дээр тэр.

**Д.Амарбаясгалан:** Гишүүдэд оройны мэндийг хүргэе. Ингээд ажлын цаг дууссан байгаа учраас Их Хурлын чуулгын хуралдааны цагийг сунгалаа. Дараагийн асуудалд оръё.

**Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн үр дүнгээр бид нар ард түмний санал бүхэнд хүндэтгэлтэй хандах агуулгаар, мөн бид нар Монгол Улсын хөгжилд тулгамдаж ирсэн хүндрэлтэй бэрхшээлүүдийг хамтын хүчээр хурдтай шийдвэрлэх, мөн хувь улс төрчийн тоглолтоос институцийн дүрэм рүү шилжих сонгодог парламентын засаглалыг Монгол Улсад төлөвшүүлэх хүрээнд парламентад хамгийн олон суудал авсан 3 нам хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурсан.

Мөн 30 хоногийн дотор бид нар мөрийн хөтөлбөрийг буюу Засгийн газрын нэгдсэн хөтөлбөрийг боловсруулах ийм ажлын хэсэг байгуулагдахаар тус хамтын ажиллагааны бичигт тусгагдсан.

Мөн бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг оруулж ирэхдээ хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хурдтай шийдвэрлэх ийм гэрээ байгуулна.

Гэрээг бид нар Герман, Шинэ Зеланд болон бусад улсын загвар дээр тулгуурлаж маш нарийвчилж байгуулна.

Бусад улсын баримт бичиг хамгийн багадаа 300-350 орчим хуудастай ийм том баримт бичгүүд байгаа. Тийм учраас үүн дээр Монгол Улсын парламент анх удаа алхах ийм алхмыг хийнэ.

Энэ гэрээг бид нар маш нарийвчилж хийж чадсан тохиолдолд олон жилийн хугацаанд хуримтлагдсан том төслүүд мөн Монгол Улсын хөгжлийн олон гацаанууд арилах, илүү

парламент дээр хамтдаа бүтээлч мэтгэлцээн өрнүүлэх ийм боломжийг бид нар нээж чадна гэж үзэж байгаа. Энэ бол өөрөө бас 126 парламентын гишүүнтэй болсон. Энэ бидний Үндсэн хуулийн концепц илүү амьдрал дээр хэрэгжих, ард иргэд бодит үр шимийг нь хүртэх ийм боломж бүрдэнэ гэж үзэж байгаа. Энэ агуулгаар бид нар Засгийн газрын энэхүү бүтцийг оруулж ирж байна гэдгийг та бүхэн бас ойлгож байгаа байх.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын хувьд бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай энэхүү хуулийн төслийг өргөн барьж байна.

Энэ хуулийн төслийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон Засгийн газрын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайлан асуудлыг хандуулах чиглэл дээр боловсруулсан гэдгийг хэлье.

Танилцуулга дэлгэрэнгүй тараагдсан байгаа учраас хэд хэдэн онцлогууд байгаа.

Нэгдүгээрт, эдийн засаг, хөгжлийн бодлоготой шинжлэх ухааны бодлогыг уялдуулах нэгдүгээр зорилго орсон байгаа. Нэг үгээр хэлбэл Эдийн засгийн хөгжлийн яаман дээр шинжлэх ухааны бодлогыг шууд татаж авснаараа шинжлэх ухаан бол салбарын бодлого биш, нэг яамны харьяа байгууллага биш. Бүх бүрэлдэхүүн тэр дундаа их, дээд сургуулиуд хамтдаа Монгол улсыг хөгжүүлэх бодлогын судалгааны “Тинк танк” хэлбэрээр ажиллах ийм эрх зүйн боломжийг бүрдүүлж байгаа гэж ойлгож болно.

Нэг үгээр хэлбэл салбар дамнасан асуудал бол шинжлэх ухаан юм гэж үзсэн

нэгдүгээр үндэслэл байгаа. Нэг үгээр хэлбэл зөвхөн хувь хүн төлөвлөх биш аливаа асуудлыг шинжлэх ухаанч, бүтээлч байдал дээр их өгөгдөлд тулгуурлаж өгөх. Энэ нь бүх салбар дээр тухайлсан шинжилгээг хийх энэ агуулгаараа шинжлэх ухааныг эрхэмлэсэн нэгдүгээр ийм бодлогын өөрчлөлт энэ бүтцэд орсон.

Хоёрдугаарт, Хууль зүй, дотоод хэргийн яаманд мөн парламент дээр яригдаж байсан сонгодог парламентын зарчимд байдаг шударга ёс буюу “жастис” /justice/ гэдэг үгийг яг өөрийнх нь үндсэн агуулгаар оруулж ирсэн. Сонгодог парламентын засаглалтай улс орнуудад хяналт, тэнцлийн дагуу Ерөнхий сайд аль намд гарна Хууль зүй, дотоод хэргийн яам буюу Шударга ёсны яам илүү хамтарч ажиллаж байгаа. Засаглал талдаа гардаг нь энэ Герман болон бусад сонгодог парламентын нийтлэг жишиг. Энэ агуулгаараа бид нар хүний эрхтэй холбоотой, мөн шударга ёсны зарчимтай холбоотой, авлигатай тэмцэх холбоотой энэхүү чиглэл дээр томоохон өөрчлөлтүүдийг бас яамны үндсэн чиглэл болон хөтөлбөрүүд дунд оруулж ирсэн байгаа. Энийг та бүхэн ажиглаж байгаа болов уу гэж бодож байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны бүтцийг гэр бүл гэдэг үндсэн концепц руу чиглүүлж байгаа. Яагаад гэхлээр нийгмийн хамгаалал, хөдөлмөр гээд ингээд салгачихаар хоорондоо тусдаа ийм хоёр асуудал юм шиг.

Хүүхдийн асуудал, залуучуудын асуудлыг 1 агентлагт өгчихөөр хүүхэд залуучуудын асуудал бол зарим газраа хүүхдийн байгууллага давамгайлсан боловсон хүчин нь илүү анхаарал хандуулаад, зарим талдаа залуучууд давамгайлсан бодлого нь явдаг. Бүхэлдээ энэ бол гэр бүл гэдэг ийм цогц ойлголтыг бүрдүүлж, нийгмийн хамгийн анхдагч нэгж өөрөө гэр бүлийн аз жаргалтай байдлаас гэр бүлийн хүмүүжлээс эхэлнэ



гэдэг үндсэн санааг хүний хөгжил гэдэг агуулгаар оруулж ирсэн.

Мөн бидний тулгамдаж байгаа гол асуудал бол бүсчилсэн хөгжил, мөн Нийслэл Улаанбаатар хот, мөн хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил, мөн бүсчилсэн тойргийн асуудал байгаа. Энэ агуулгаараа хот байгуулалт гэдэг энэ агуулгыг бид нар Барилга, хот байгуулалтын яамны үндсэн бүтцийг нэгдүгээрт гаргаж тавьж байгаа.

Яагаад гэвэл хот байгуулалт нь урдаа, хот байгуулалтын төлөвлөгөөний араас барилгажуулалт, мөн хотын төлөвлөлтүүд явдаг ийм олон улсын жишигтэй. Манайх бол зөвхөн барилгадаа анхаарсан учраас бид нар ногоон байгууламж, гүүрэн байгууламж, мөн амьдралын стандарт зэрэг олон асуудлуудыг газар олголтыг өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд алдаа гаргасан гэж үзэж байгаа учраас хот байгуулалт, мэргэжлийн хот төлөвлөлт гэдэг энэ агуулгыг гаргах нийслэл Улаанбаатар хотыг мөн 20 минутын стандартад шилжүүлэх энэ агуулга дээр өөрчлөлт хийгдсэн.

Залуучуудын асуудал мөн соёл, спорт, аялал жуулчлалын энэ салбарыг нэгтгэх нь зүйтэй гэж үзсэн. Яагаад гэвэл манайх соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлыг бид нар зөвхөн соёл урлагийн үйлчилгээ гэж хардаг энэ соёлоосоо татгалзаж, соёл бол өөрөө бүтээлч үйлдвэрлэл, соёл бол өөрөө аялал жуулчлал, соёл бол өөрөө тусгаар тогтнол, соёл бол өөрөө хүмүүсийн нийгмийн сэтгэлгээ, соёл бол өөрөө нүүдлийн ахуй. Энэ бүх зүйлийг цогцоор хийхийн тулд соёл бол өөрөө спорт юм, соёл бол өөрөө аялал жуулчлалтайгаа уялдах ёстой, мөн залуучуудтайгаа хамт байх ёстой гэдэг олон улсын нийтлэг жишиг буюу мөн Сингапур, Шинэ Зеланд зэрэг нийтлэг газруудад хийгдэж байгаа энэ бүтцийг авах нь зүйтэй гэж үзсэн.

Дэлхий нийтээрээ уур амьсгалын өөрчлөлтөд асуудлыг голлон анхаарал хандуулж байна. Манайд ч гэсэн энэ асуудал тулгамдаж байна. Энэ агуулгаараа нүүдлийн соёл иргэниил, энэ бүх асуудал дээр уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлууд тулгамдаж байна. Энэ агуулгаараа байгаль орчин бол илүү уур амьсгалын өөрчлөлт, мөн хөдөө орон нутаг цөлжилттэй холбоотой асуудал, мөн говийн бүс нутгийг усжуулах зэрэг олон асуудалтай холбоотой ийм асуудалд голлон чиг үүргээрээ анхаарах нь зүйтэй юм гэж үзсэн.

Уул уурхай гэдэг энэ ойлголтыг бид нар илүү байгаль орчинд ээлтэй, мөн дэвшилтэт технологид тулгуурласан энэ чиглэл рүү хийгдэх гэдэг агуулгаараа илүү технологи, ногоон хөгжил, байгаль орчинд ээлтэй байх бодлого руу хийх, мөн өртөг болон зардалтай холбоотой асуудал дээр бид нар дүн шинжилгээ хийж аж үйлдвэржилт рүү хандуулах гэдэг агуулгаараа Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам гэдэг агуулга руу явах нь зүйтэй юм. Нэг үгээр хэлбэл нүүрсийг бид дахин боловсруулах, нүүрснээс устөрөгч гаргах, зэсийг бас бид нар нэг шатаар боловсруулах, мөн алт боловсруулах зэрэг энэ агуулга руу аж үйлдвэртэйгээ эрдэс баялгийн салбар хамт байх нь зүйтэй юм гэж үзсэн.

Өмнө нь байсан 16 яамыг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсэн. Энэ бүтцэд Дэд сайдуудын асуудлыг бас оруулж ирээгүй байгаа. Яагаад гэвэл сонгодог парламентын нийтлэг жишигт Дэд сайд гэдэг албан тушаалаас илүү парламент дээр парламентын гишүүн Төрийн нарийн бичгийн дарга байдаг ийм нийтлэг жишигтэй. Нэг үгээр хэлбэл өөрийн захиран зарцуулах төсөвгүй. Гэхдээ тухайн салбарыг салбар дээр парламентад төлөөлж мэтгэлцээнд ордог ийм жишиг байдаг.

Тэгэхлээр энэ жишиг рүү бид нар 30 хоногийн хугацаанд хамтдаа Засгийн

газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа бас сонгодог парламентын засаглал биднээс 50-аад жилийн өмнө явж байгаа улс орнууд руу парламентын гишүүд маань өөрсдөө ажлын хэсэгт ороод ажиллаж үзээсэй гэж бас хүсэж байна. Тэгээд үүнийг олон нийтийн санал асуулгаар одоо байгаа Дэд сайдын бүтэц хадгалагдах нь зүйтэй гэж үзвэл энэ томилгоог Засгийн газрын бүтцэд оруулж ирээд хийчхэж болно. Сонгодог парламентын засаглал руу явж байгаа сонгодог энэ агуулгаа дагах нь зүйтэй гэж үзвэл энэ шийдэмгий шийдвэрийг Ерөнхий сайдын хувьд гаргахад бэлэн байгаагаа илэрхийлж энэ удаагийн бүтцэд дэд сайдуудын бүтцийг зориуд тусад нь оруулж ирж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье.

Ингээд Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхнийг Монгол Улсын Ерөнхий сайдын зүгээс өргөн барьж буй Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүдийг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Энэ гол агуулга бол бид нар нэгдүгээрт сонгодог парламент, сонгодог парламентын засаглал руу төлөвших эхний алхам.

Хоёрдугаарт, хувь улс төрч гэхээс илүүтэйгээр институцүүд хоорондоо харилцан хяналт тэнцэлтэй ажиллах олон улсын парламентын нийтлэг жишиг, мөн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хурдтай шийдвэрлэх гэсэн ийм 3 үндсэн зарчим дээр тулгуурлан өргөн барьж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Одоо төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урья.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр бүрдсэн Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр товлон зарлан хуралдуулсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулж, Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдыг томилсон билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасны дагуу шинээр томилогдсон Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлж, Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг боловсруулан 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийг баримтлан Төрийн байгуулалтын байнгын хороо уг хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг яаралтай хэлэлцүүлэх горимоор 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газар нь 16 яамтай ажиллах бөгөөд үүнээс 4 нь ерөнхий чиг үүргийн, 12 нь чиглэлийн байхаар, Засгийн газрын бүрэлдэхүүн нь Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн

засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд бөгөөд Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, 20 минутын хот Үндэсний хорооны дарга болон холбогдох бусад салбарын асуудал эрхэлсэн нийт 22 сайдаас бүртгэхээр хуулийн төсөлд тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин, Батбаатар, Зулхар, Ариунзаяа нар хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин, Пүрэвдорж, Доржханд, Батбаатар, Зулхар, Номинчимэг, Болормаа нар Засгийн газрын бүтцийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар бас саналаа илэрхийлсэн болно.

Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Засгийн газар дахь Хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг

орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 85 хувийн саналаар, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 80 хувийн саналаар, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 80 хувийн саналаар, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 80 хувийн саналаар, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 80 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд  
ээ,

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Бямбажавын Ганбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Дагдандоржийн Амгаланбаатар Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд ажлын албаны дарга, Пүрэвийн Зохихсүрэн Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Чулуунбаатарын Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Очиржавын Дөлгөөнтуул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын Засгийн газрын референт.

Гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууна. Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуух зөвшөөрлийг олгоно.

Ингээд намын бүлгүүдээс ирсэн нэрс бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирсэн хүсэлтийг аваад Улсын Их Хурлын чуулганы ирцэд бүртгүүлсэн дарааллаар дараалалд оруулсан байгаа. Ингээд асуулт асууж эхэлье.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан.

**Л.Мөнхбаясгалан:** Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам гэж орж ирсэн байна. Шударга ёс гэхээр их анхаарал татаж байна. Энэ дээр үг хэлэх, хэвлэн нийтлэх хэвлэлийн эрх чөлөөг яаж тусгаж оруулах вэ? Сүүлийн үед хэвлэл мэдээллийн эрх чөлөө

алдагдаж байгаа. Энэ дээр бол манай хэвлэл мэдээллийн салбар маш их гомдолтой байгаа.

Гэхдээ нөгөө талд нь бас хувь хүний нэр төр, алдар гавьяаг гутаан доромжилж байсан гэдэг асуудал дандаа явдаг. Манайхны бодож байгаагаар эсвэл дэлхийн Шведийн хэвлэлийн эрх чөлөөний хуулийн загвараар ерөөсөө л мэдээлэл авах эрхийг нь нээгээд өгөхөд хүнийг гүтгэх, алдар хүндэд халдах асуудал бол байхгүй болдог. Тэгэхээр үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөн дээр хэрхэн ажиллах вэ?

Нөгөөдөх нь төрийн албан хаагчид бас үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хумигдахыг нүдээрээ хараад ирсэн. Тийм учраас энэ тал дээр бас яаж ажиллах вэ гэж асууя.

Хоёрдугаар асуулт нь мэдээж хамтарсан ийм том Засгийн газар байгуулагдаж байгаа учраас олон жил ярьсан том төслүүдээ урагшлуулах байх гэдэгт итгэж байна.

Жишээ нь, Алтаниширээгийн аж үйлдвэрийн парк, тэгээд боловсруулах үйлдвэрүүд, баруун, зүүн төмөр зам гээд ингээд явах байх. Энэ дээр хамгийн гол нь говийн бүсийн усны асуудал, гадаргын ус татах асуудал байгаа. Энэ дээр Ардын намын болон Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт тусгасан усны төслүүдийг нэгтгэх үү, эсвэл Хэрлэн-Тооно, Орхон-Онги-оороо зөвхөн Ардын намын мөрийн хөтөлбөрт байгаа төслөөр явах юм уу? Ийм 2 асуулт байна.

Хариулт өгье. Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт, энэ агуулгаар энэ Засгийн газрын бүтцэд шударга ёс, Хууль зүй, дотоод хэргийн яамыг Ардчилсан



намд өгөх нь зүйтэй гэж Ерөнхий сайдын хувьд үзсэн.

Яагаад гэвэл шүүх, прокурор, Засгийн газрын мөрдөх байгууллагуудын ялгаатай байдлыг ер нь олон нийт төдийлөн сайн анзаарч хардаггүй. Тэгээд тэрийг нэг асуудал болонгуут тэр нь төр гэдэг ерөнхий ойлголт дунд оруулж ойлгоод байдаг.

Гэтэл прокурор тусдаа чиг үүрэгтэй, шүүх тусдаа чиг үүрэгтэй. Шүүхийн түвшинд болж байгаа бас ийм олон асуудлууд бий. Энэ асуудлуудыг илүү хяналт тэнцэлтэй байх гэдэг агуулгаар, мөн энэ асуудлыг хууль, эрх зүйн хувьд шинэчлэл хийх энэ боломжийг олгох гэдэг агуулгаараа Шударга ёс, хууль зүй, дотоод яам бол энэ бүтэц дээр Ардчилсан намд байх нь зүйтэй гэж үзсэн.

Тэгэхээр томилогдоод тэгээд л та хэд маань хамтарч ажиллах хэрэгтэй гэсэн үг. Ямар эрх зүйн хувьд давхцалууд байна. Үнэхээр харж байгаа шиг энэ олон хүний эрхтэй холбоотой асуудлууд, Засгийн газрын асуудал байсан уу, эсвэл шүүхийн асуудлууд байсан уу? Шүүх дотроо хэн гэдэг шүүгч хэдэн онд хэзээ томилогдсон асуудлууд ингээд энэ маш ойлгомжтой болно. Тэгэхээр үүнийг парламентын гишүүд хамтдаа бид нар нийгэмд эрх мэдлийн салангид байдал гэдэг энэ агуулгыг ойлгуулаад, шүүх ямар түвшинд мөрдөх байгууллагууд болон хяналтын байгууллагаасаа тусдаа ийм эрх мэдлүүд явдаг вэ гэдгийг ойлгуулах гэдэг агуулгаараа мөн эрх зүйн цогц бас реформыг хийх энэ боломжийг олгох гэдэг агуулгаараа мөн энэ хардалттай байгаа энэ асуудлуудад бид нар нэгдсэн үнэлэлт, дүгнэлт өгөх гэдэг агуулгаараа энэ асуудал ингээд шийдэгдэж болох байх.

Говийн бүсийн усжуулалттай холбоотой асуудал дээр ингээд Засгийн газар байгуулагдаад 30 хоногийн дотор Засгийн газрын үйл ажиллагааны

хөтөлбөрийг оруулж ирнэ. Тэр хөтөлбөр дээр хамтын ажиллагааг илүү хурдасгах ийм маш нарийвчилсан зохицуулалт бүхий гэрээ байгуулагдана. Тэр гэрээнд байгуулагдаад бүх бүлгүүд шийдвэр гаргана. Бүх төлөөллийн байгууллагууд улс төрийн намууд шийдвэр гаргана, мөн Засгийн газарт хамтарч ажиллахгүй байгаа ч гэсэн парламентад суудалтай бүх намын хөтөлбөрийг тусгана. Ингээд орон сууц гэхэд аль газрыг чөлөөлөх вэ ямар эрх зүйн орчин явах вэ, хэн хариуцах вэ, ямар ажлын хэсгүүд байх вэ гэдгээс авхуулаад маш нарийвчилсан гэрээ хийнэ. Энэ агуулгаараа энэ гэрээ бол олон улсад 300-350 орчим хуудастай болдог юм байна лээ гэж хэлээд байгаа нь тэр. Энэ гэрээн дээр бид нар үзэл санаагаа нэгтгэчихвэл хамтарсан ийм хөтөлбөр болно гэсэн үг.

Тэгэхээрээ яг түүнийхээ дагуу бид нар гэрээгээ л биелүүлэх энэ агуулга руу хамтдаа явах зүйлийг хийчихвэл хөгжлийн энэ их олон гацаа маш хурдтай гарна гэсэн үг. Тэгэхлээр гэрээн дээрээ л хэдүүлээ маш их нарийвчилж суух хэрэгтэй. Бүгдээрээ бид нар мөрийн хөтөлбөр дэвшүүлээд сонгогдсон хүмүүс. Энэ агуул.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл.

**О.Цогтгэрэл:** Улсын Их Хурлын сонгуулийн үр дүн гарсан. Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнг нэг хэсэг нь хамтрах ёстой. Яагаад гэвэл гээд их олон үндэслэл хэлж байгаа. Бас нэг хэсэг хүмүүс хамтрахгүй байх ёстой. Яагаад гэвэл гэж бас олон үндэслэл хэлж байгаа. Миний хувьд хувь хүний байр суурь байвал би хамтрахгүй байх ёстой гэдэг байр суурийн илэрхийлэл тийм бодолтой намын бодлого, шийдвэр гарсан учраас бас тэрийгээ биелүүлээд явна.

Ер нь яагаад хамтрахгүй ёстой вэ гэдэг дээр ганц хоёрхон маш олон зүйлээс бас ганц хоёрхон зүйлийг би бас хэлье. Ингээд хамтрал боллоо гэхэд 68 дээр 42,

дээр нь 8, 118 гишүүн нэг талдаа гарах нь. 126-аас 94 хувь, парламентын 94 хувь ялсан, ялагдсан нь нийлээд нэг талдаа гарах юм байна. Яг өнөөдрийн манай 126-тай парламент чинь энд ажил олгогчдын төлөөлөл танхимынхан нь орж ирээд бас суучихсан, эрх баригч болоод суучихсан, ажилтны төлөөлөл үйлдвэрчний эвлэл нь орж ирээд суучихсан. Тэгэхээр энэ нийгэмд чинь нөгөө ийм ялгаатай байр сууриуд, ард түмний сонголтууд энэ олон зүйлүүд нь хаачихсан юм бэ? Нөгөө иргэний нийгэм, төр засаг бүх юм байхгүй болоод нэг талдаа гарах чинь яг үнэндээ энэ ардчиллын зарчим бас мөн юм уу, биш юм уу гэдэгт би бас эргэлздэг. Олон олон зүйлүүдийг хэлж болно. Тэгээд Ерөнхий сайдаас би 2 асуулт байна.

Нэгдүгээрт нь хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр олон зүйлүүдэд тал талаас ярихад бүхий л хүмүүсийн амны унилага болсон. нэг үг байдаг. Том төслүүдийг хөдөлгөнө, бүтээн байгуулалт хийнэ гэдэг. Яг энэ үгэн дээр би бол их эсрэг байдаг. Ард түмэнд маш их гоё сонсогддог, бүтээн байгуулалт хийнэ, том төсөл хэрэгжүүлнэ гэдэг. Энийг төр энэ том төслүүдийг хэрэгжүүлнэ гээд л эхлэхээр энэний цаана дахиад том ТӨК л гарч ирнэ. Энэний цаана том төрийн оролцоо л гарч ирнэ гэж би боддог.

Харин энийг тэр хөрөнгө оруулалтын орчныг яаж сайжруулах юм? Гадна, дотнын хөрөнгө оруулагчдыг яаж энэ том төсөлд татаж оролцуулах юм? Энэ арга механизмуудыг бид нар ярихгүйгээр яг өмнө нь нефтийн үйлдвэр гээд хэд бараг 2 тэрбум доллар яригдах том төсөл одоо нэг гоё төсөл яриад нөгөөдөх маань юу болчихсон байгааг бараг бүгдээрээ гадарлаж байгаа байх. Тэгэхээр энэ том төсөл гэдэг гоё сайхан энэ хандлагуудыг та юу гэж аль өнцгөөсөө хараад байгаа вэ? Яг энэ бол, би бол энэ дээр би хэдийгээр бизнесийн салбараас гаралтай хүн ч гэсэн энэ дээр

би бол арай өөр байр суурьтай байдаг учраас бас энийг илэрхийлж байгаа юм.

Хоёрдугаарт нь засагт намууд хамтраад нийлээд салбарууд бодлого гаргаад ажиллана гэсэн тийм байр суурийг бусад хамтарч байгаа намууд хүлээгээд байх шиг байгаа юм. Салбарын бодлого гэдэг зүйл. Яг Үндсэн хуулийн үзэл санаагаар засгийн бодлогыг Ерөнхий сайд томъёолоод үндсэндээ салбарын сайдууд чинь миний бодлоор бол бараг гүйцэтгэгчид болоод хувирчихсан, гүйцэтгэгчид болоод хувирчихсан. Ерөнхий сайдын бодлого гэж.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** 4 минут болсон. Өнөөдөр Дэгийн тухай хуулиар дэгийн хуулийн 9.4-ийн заалтаар Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл тухайн хэлэлцэж байгаа хууль тогтоомжийг ямар хугацаанд хэлэлцэхийг батлаад, тэр батлагдсан хугацааг улс төрийн намын бүлэг болон бүлэгт харьяалагдахгүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилах замаар үг хэлүүлж байгаа.

Энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлд хэлэлцээд асуулт асуух хугацааг 60 минут, хариулт өгөх хугацааг 40 хүртэл минут гэж тогтсон байгаа. Энэ тогтсон хуваариар цаашидаа энэ бол тогтмол үйлчилж явна. Тухайн хэлэлцэж байгаа асуудлаас хамаарч.

Тухайн хуваарилалтын дагуу Монгол ардын намын бүлэгт 32 минут, Ардчилсан намын бүлэгт 20 минут, бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд 8 минут оногдож байгаа.

Тэгээд үүний дагуу Ардын Намаас 5 гишүүн тус бүр 6 минутаар үг хэлэх нэрс ирсэн. Ардчилсан намаас 5 гишүүн тус бүр 4 минутаар үг хэлэх нэрс ирсэн. Бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс 2 гишүүн тус бүр 4 минутаар үг, асуулт

асуухаар нэрс ирсэн байгаа гэдгийг танилцуулъя. Ингээд хариулт өгье. Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Би энийг л яриад байгаа юм л даа. Хувь хүний улс төрийн тоглолтоос институцийн соёлд шилжих нь Монгол Улсад чухал байна гээд. Уг нь миний ойлгож байгаагаар та бол Ардчилсан намын бүлгийн дарга хүн, бүлгийн дарга хүн бол намаа төлөөлж намынхаа л яг энэ чиглэл дээр нийт гишүүдийн хүсэл эрмэлзлийн нийлбэр байх учиртай. Танд хувь хүний хувьд даанч нам ингэчихлээ ч гэдэг юм уу ийм тоглолт бол уг нь сонгодог парламентын засаглалтай аль ч улсад ийм зүйл хэзээ ч байдаггүй л дээ. Манайх харамсалтай нь ингээж яваад ирсэн.

Миний бодлоор Ардчилсан нам төлөөллийн төв байгууллагаараа шийдвэр гаргасан л гэж би ойлгож байгаа. Монгол Ардын нам ч төлөөллийн төв байгууллагаараа, ХҮН нам ч төлөөллийн төв байгууллагаараа л шийдвэр гаргасан. Нэгдүгээрт би үүнийг хэлэх нь зүйтэй болов уу гэж.

Хоёрдугаарт, 76 нутаг дэвсгэрийн тойрогт түшиглэсэн энэ парламентыг бид нар 126 болгоод хувь тэнцүүлж байна гэдэг бол угаасаа л бид нар мөнхийн Засгийн газар эвсэх энэ тогтолцоо руу хамтдаа л бид нар орсон гэсэн үг. Тогтолцооны хувьд. Герман, Шинэ Зеланд бүгд л ийм байгаа.

Яагаад гэхлээр сонгогчдын саналыг гээгдэхгүй байх энэ хувь тэнцүүлэх зарчим өөрөө ийм хяналт, тэнцлийг барьдаг л ийм л тогтолцоо. Үүн дээр бид нар хамтдаа л орсон. Тэгээд бид нар шинэ Үндсэн хуулийнхаа дагуу шинэ соёлд дасан зохицох ийм л шаардлагатай байна гэж бодож байгаа юм.

Яах вэ том төслүүд, мега төслүүд гэж ярихгүй байж болно л доо. Гэхдээ юу гэж нэрлэх вэ тэгээд? Эдийн засгийн төслүүд хөгжих л ёстой. Ингээж

байж ДНБ тэлэх ёстой, ингээж байж л бид нар асуудлаа шийднэ. Тэрнээс том төсөл гэж нэрлэхгүй байя, энийг би арай өөрөөр ойлгодог гээд байвал тэгээд бид нар юу гэж нэрлэх вэ? Нэрийг өөрөөр нэрлэж болох байх л даа. Гэхдээ төслийн хувьд бид нар эрчим хүчээ шийдэх л ёстой, аж үйлдвэрээ шийдэх л ёстой, эдийн засгаа, хөдөө аж ахуй, аялал жуулчлалыг хөгжүүлэх л ёстой. Энэнээс өөрөөр нэрлээд мэдэхгүй би бас энэ дээр сайн хариулж чадахгүй л байна л даа. Том төслүүд гэдэг бол хамгийн л их Ардчилсан намаас гардаг л ийм үг. Тэгээд Ардчилсан намын бүлгийн дарга өөрөө том төслүүдийг хөтлөх нь буруу юм гэж, ялангуяа бас хувийн хэвшилээс төлөөлж гарч ирсэн таны хувьд ингээд ярьж байгаад бас ингээд ийм эргэлзээтэй л байна л даа.

Тийм учраас та намынхаа байр суурийг бас ингээд бариад яг бүлгийн даргын хувьд, цаашидаа хувь хүнээс илүү институц тал руугаа явах энэ зүйл дээр илүү хэдүүлээ хамтдаа алхах нь зүйтэй болов уу л гэж бодож байна. Би бол таныг хувь гишүүн яриад байна гэж ойлгох уу, эсвэл Ардчилсан намын бүлгийн дарга төлөөллийнхөө төв байгууллагын бодлогын эсрэг яриад байна гэж ойлгох уу? Тэгээд цаашидаа бас энэ гэрээ, хэлцлээс авхуулаад олон зүйлүүд дээр яаж явах вэ?

**Д.Амарбаясгалан:** Батбаярын Жаргалан гишүүн? Алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтын тухай ярьж байна. Би хоёр мэдээлэл өгье. Нэг муу мэдээ, нэг сайн мэдээ байна. Өнгөрсөн 30 жил Засгийн газар маш олон гоё гоё бүтэцтэй, зохион байгуулалттай орж ирдэг. Орлого, ажлын байр, үйлдвэрлэл дандаа биднүүс муу үр дүнтэй байгаа. Шалтгаан нь гэвэл сайд дарга нар гарч ирээд л тэнгэрийн умдаг атгачихлаа л гэж боддог. Маш том том төсөв тендер

ЖДҮ, сангуудыг мэдээд эхэллээ, ид шид олчихлоо л гэж боддог.

Тэгэхлээр эндээс сэргийлэх ямар арга зам байгаа вэ? Өөрөөр хэлбэл, энэ татвар, төсвийг бүрдүүлж байгаа бизнес эрхлэгчид төлөөллийн байгууллагуудтай зөвшилцож ойлгодог механизм энэ дээр ямар механизмыг яг энэ дээр суулгасан бэ? Мега төслүүд гэж түрүүн ярьж байна. Том том бизнес эрхлэгч энэ бизнесийн төлөөллийн байгууллагууд гомдол гаргахад шүүх дээр очно гээд л залхаагаад хаячихдаг. Зөвшилцож ойлгогддог, зөвлөдөг, санал авдаг механизмууд нь байгаа юу? Энийг яаж тусгасан бэ?

Гуравдугаарт, энэ Айн рэнд энэ хэлсэн үг байна л даа. Зөвшилцөл бол фашизм гээд хэлчихсэн. Яг үг нь бол ард иргэд болон нийгмийн төлөөллийн байгууллагуудтайгаа зөвшилцөхгүйгээр эрх баригчид хоорондоо зөвшилцөл фашизм гэж хэлсэн юм л даа. Тэгэхлээр энэ механизм ямар байдлаар энэ бүтэц зохион байгуулалт дээр орж ирсэн бэ? Маргаан таслах гомдлын механизм гэж би их олон жил ярьж байгаа. Эднүүс нь яам болон энэ төрийн байгууллагууд дээр яаж тусгагдсан бэ? Эцэст нь сайд дарга нар ханиуй шамлаад л би бүхнийг мэднэ, би чадна гээд л ханиуй шамлаад л дайраад байхын оронд энийг надаас илүү хэн чадах вэ, энийг надаас илүү ямар гаргалгаа гаргах вэ, энэ хувийн хэвшилтэйгээ би яаж түншилбэл энэ дээр үр дүн гаргах вэ гэдэг асуудлуудыг энэ бүтэц, зохион байгуулалтын асуудлууд дээр хэрхэн туссан бэ гэсэн ийм 4 асуултыг би асууж байна. Тэгээд цаг дуусаж байна уу үгүй юу? Цаг дуусаагүй бол 1 минут байгаа юу? Сайн мэдээгээ хэлчихье.

Муу мэдээ энэ бол 30 жил биднүүсийг зовоосон асуудал л даа. Сайн мэдээ нь өнгөрсөн 2021-ээс 25 онд Засгийн газрын үндсэн чиглэл батлах тухай 20 оны 8 дугаар сарын 28-нд 5.1.3 эдийн засаг бизнесийн бүхий л харилцаа

засаглалын бүх шатад олон талт түншилэлийг оновчтой үр дүнтэй нэвтрүүлнэ гэж заасан байгаа. Энэ бол хувийн хэвшлийг яг хүндэтгэсэн анхны заалт шүү. Би бол урьд нь ийм юм мэдэхгүй. Үйл ажиллагааны хөтөлбөр 4.2.10-д заасан байгаа. Нийгмийн түншилэлийн хүрээнд шийдвэр гаргах бүх шатад төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил зөвлөлдөх санал авах, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцоог хангана гэсэн. Энэ овоо үр дүнд хүрч явсан, заавал шинээр юм эхлэх албагүй шүү дээ. Энэ өнөөдрийн Засгийн газарт бас орж байгаа юу? Орвол яаж тусаж байгаа вэ? Ийм хоёр зүйлийг би асууж байна.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Үнэхээр чухал асуудал хөндөгдлөө. Одоо Скандинавын ч юм уу эсвэл бидний энэ саяхан энэ сонгодог парламент гэж яриад байгаа энэ зөвшилцлийн ардчилал илүү хөгжссөн улсуудад бол дандаа л институцүүд хоорондоо харилцаж байгаа. Жишээлбэл, гурван талт хэлэлцээр та мэднэ Худалдаа аж үйлдвэрийн танхим, үйлдвэрчин, Засгийн газар гурав. Тэгээд байр сууриудаа нэгтгээд институцүүд л хоорондоо асуудлуудаа ярьчихаж байгаа. Ажил олгогчдыг төлөөлөөд эрхээ үйлдвэрчин хамгаалж байгаа, нийт бизнес эрхлэгчдийн хүсэл эрмэлзлийг Худалдаа аж үйлдвэрийн танхим нэгтгэж байгаа. Энэ ч агуулгаар би энэ эрх зүйн орчныг өөрчлөөсэй л гэж бодож Худалдаа аж үйлдвэрийн танхим, үйлдвэрчин, Шинжлэх ухааны академи гуравыг урьсан юм. Энэ хүмүүсийг намжуулах гээд байгаа асуудал огт биш. Харин парламент илүү нийгэмжээсэй гэж бодсон. Парламент илүү төлөөллийн төв байгууллагын хувьд дуу хоолойнууд энд бүгдээрээ орж ирж зөвшилцөлд хүрээсэй.



Энэ нь өөрөө нийгмийн хөгжлийг хурдасгаасай л гэж бас бодсон.

Тийм учраас хувийн хэвшлийнхэн хамтдаа байр сууриа илэрхийлээд нэгдээд танхим дээрээ, үйлдвэрчин ч бас улс төрийн намууд ч зөвшилцөөд л бид нар дүрмээ тогтчих ёстой. Магадгүй бид нар энэ олон тендер, сонгон шалгаруулалттай холбоотой энэ бүх асуудлууд дээр бас том реформ хийх ёстой гэж үзсэн. Энэ агуулгаараа бас энэ өнөөдрийн бүтэц дээр ХҮН намд жишигээлбэл, төрийн худалдан авалтын бүх тендерийг өгч байгаа. Нэг үгээр хэлбэл илүү өөр өнцгөөс харах энэ эрх чөлөө байгаасай гэж бодож байгаа. Энийг цахимжуулах, илүү сонгодог хэлбэр рүү нь оруулах, илүү чанар руу оруулах энэ реформ хийгдээсэй энэ парламент дээр.

Дээрээс нь бид нар төсөв батлагдаад гэрээн дээр шаардлагатай бүх төсвийг заавал яамнууд өөрсдөө тендер зарлахгүйгээр бид нар танхимд өгчхөж болно. Энэ гол нь эрх зүйн орчныг л бид нар бүрдүүлэх хэрэгтэй. Танхим өөрөө аудиттайгаа, хувийн хэвшилтэй ямар төсөл дээр яаж хамтрах вэ гэдгийг бас хийж болно. Түүнийг өөрөө аудит аудитладаг бас байж болно.

Тэгэхлээр төр дээр бид нарын хувьд нэгэнтээ ингээд төсөв, эрх мэдэл төвлөрүүлээд түүндээ өөрсдөө бас бялуурч байгаа л ийм асуудал болдог. Таны хэлдэгтэй үнэхээр санал нэг байна. Төр бол нийтийн үйлчлэх ийм институц гэдгээ бас ойлгох ёстой. Албан тушаал гэдэг бол энэ сонгуулийн үр дүн дээр мөрийн хөтөлбөрөө биелүүлэхийн төлөө үйлчилж байгаа ийм л албан хаагч болохоос биш энэ эрх мэдэл, эрх ямба биш юм гэдгээ л бид нарын хувьд ойлгогчигвол энэ агуулга руу орно.

Тэгэхлээр сонгодог парламентын засаглал өөрөө бас төлөөлөл гэдэг энэ агуулгыг илүү нийгэмд ойлгуулж байгаагаараа их чухал. Парламент дарга

нарын цуглуулга биш парламент бол бидний төлөөллийн нийлбэр юм гэж харж байж бид нар хамтдаа явах, энэ зүйл рүү орж чадвал туйлын чухал.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар асуулт асууна.

**Б.Батбаатар:** Парламент бол төлөөллийн төв байгууллага, сонгодог парламент руу явж байна гээд ярьж байна. Харамсалтай нь энэ өмнөх парламентын хийсэн дэг бол төлөөллийн төв байгууллагын шинж чанарыг нь алдагдуулж байна л гэж харагдаад байгаа юм. Тэгээд яваандаа бүгдээрээ энийгээ өөрчлөх тал руугаа явах байлгүй дээ. Өнөө маргаашигүй бараг явах байлгүй. Иргэний Зориг ногоон нам 6 сарын 29-нд сонгуулийн маргааши өдөр Улс төрийн зөвлөлөөрөө хуралдаад Засгийн газарт Монгол Ардыг нам олонх болсон учраас Засгийн газарт Иргэний зориг ногоон нам оролцох тухай шийдвэр гаргах шаардлагагүй. Бид сөрөг хүчний үүргээ гүйцэтгээд явъя гэдэг ийм улс төрийн шийдвэр гаргасан. Тэгээд тэрийгээ хэвлэлийн хурлаар олон нийтэд хэлчихсэн. Ерөнхий сайдыг сонгодог парламент гэж ярьж байгаа учраас сонгодог парламентаа аль хүртэл нь төсөөлж яриад байгаа юм бэ? Ерөнхий сайд нь парламентаа тараадаг хүртэл тэр хэмжээнд нь аваачихыг зорьж байна уу? Хэрвээ тэрийг хүсэж байгаа бол парламент нь тарж өгөхгүй бол өөрөө огцордог. Тэрийг хүсэж байгаа бол манай Иргэний зориг ногоон нам Засгийн газраас ямар нэг сайдын бялуу авахгүйгээр тэр сонгодог парламентын төлөөх хуулийн өөрчлөлтийг чинь дэмжээд явчхаж чадна. Энийг асуумаар байна.

Хоёрт нь Засгийн газраа бүрдүүлэх энэ сайдуудаа тавих, байршуулах энэнээсээ өмнө энэ 3 нам гэрээгээ хийх үү? Нэг ёсондоо 118-ын бүлгээ байгуулах уу? ХҮН нам бол бүлэггүй яах вэ? Пүрэвдорж уурлаад л

байна лээ. Их Хурлын дэд даргаас л буух байх. Ардчилсан нам өнөөдөр байгаа бүлгээ татан буулгахаас өөр замгүй болох, манай Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль чинь тийм байгаа. Яагаад энэ өөрчлөлтийг хийсэн юм бэ.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Бид нар алхам алхмаар л мэдээж парламентынхаа.../үг тасрав./

**Д.Амарбаясгалан:** Микрофон унтарсан байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа. Бид нар алхам алхмаар л парламентын засаглалаа төгөлдөржүүлэх энэ зүйл рүү явж байгаа. 126 гишүүнтэй болж өнөөдөр бусад улс төрийн намууд энэ хувь тэнцүүлсэн тогтолцоогоор орж ирж та өнөөдөр үзэл бодлоо илэрхийлж байна гэдэг бол энэ бас л энэ Үндсэн хуулийн өөрчлөлт амилж байгаагийн бас нэг илэрхийлэл юм. Урьд нь 76 тойргийн гишүүнчлэлтэй байх үед бол 2 үндсэн том намаас өөр нам орж ирэх боломж хязгаарлагдмал байдаг байсан нь нууц биш. Тийм учраас энэ бас л одоо нэг алхаж байна гэсэн үг.

Нөгөө талаараа бид нар үзэл бодлын мэтгэлцээн рүү явж суралцах нь зүйтэй л гэж би үзэж байгаа. Монгол Ардын нам бол социал демократ үзэл баримтлалтай. Тэр агуулга дээрээ нэгдмэл байр суурьтай мэтгэлцэх учиртай. Ардчилсан нам, ХҮН нам 2 баруун төвийн үзэл баримтлалтай илүү либерал үзэл санаатай. Тэгэхгүй ингээд аль нь ямар ч намаас сонгогдсон гишүүн юм, аль нь аль ч үзэл санааг дэмждэг юм бүү мэд. Тэгээд л хоорондоо л ингээд л маргалдаад л байдаг маргалдаад л байдаг. Ийм байдал дунд нийгэм бас төөрөгдчихдөг.

Тийм учраас бид нарын хувьд илүү энэ сонгодог мэтгэлцээн рүү явж, миний одоо хүсэж байгаа зүйл бол онгоцны буудал дээр аль онгоцнууд хаашаа явж байгаа вэ гэдэг шиг парламентын мэтгэлцээнүүд урьдчилж зарлагдах ёстой. Бусад улсад тийм л байдаг. Ногоон хөгжлийн бодлогоор мэтгэлцээн урьдчилж зарлагдах ёстой. Түүндээ ногоон хөгжлийн чиглэлийнхэн хамтдаа бэлдэх ёстой, сонгогчдодоо хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Нийтдээ 30-аас 40 минутаар мэтгэлцдэг байх хэрэгтэй. Энэ зүйл дундаас олон нийт маань илүү мэдээллийг авч, төр, иргэн 2 хоорондоо ойртох учиртай. Тэгэхгүй хүн бүхэн дотроо бодож байгаа зүйлээ л намын ерөнхий үзэл баримтлал, зарчмаасаа өөр байдлаар социал демократууд нь хэт либерал юм яриад, либералууд нь бүүр хэт бараг зүүн төвийн юм яриад ингээд л явсан.

Тийм учраас энэ сонгодог мэтгэлцээн рүү орох энэ дэг рүү алхаж байгаа. Тэгээд мэдээж хэрхэн цаашидаа сайжруулах вэ гэдэг эрхэм парламентын гишүүд та бүхний л асуудал. Тухайн үед улс төрийн намууд яриад ингээд явсан.

Ногоон хөгжлийн бодлого дээр, бас бид нар, удахгүй бас улс төрийн бүх намуудтай бас бид нар ярилцана. Энэ дээр Иргэний зориг ногоон намын үзэл санаа ямар байх вэ гэдэг дээр бид нарын хувьд ярилцаад цаашидаа парламентын сонгодог мэтгэлцээний дагуу хамтдаа мэтгэлцэж, үзэл бодол дээрээ илүү тийм бодлого тулгууртай зүйл ярихад бэлэн байна гэдгээ илэрхийлье.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

**Б.Мөнхсоёл:** Сайн байцаана уу? Энэ оройн амгаланг айлтгая. Тэгээд бүгдийнх нь мэдэж байгаа гэх юм уу тийм энгийн нэг асуулт асуучихъя гэж бодлоо. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа Монгол Улсад итгэлцэл бараг шахуу

байхгүй болоод маш их удсан. Бүх талаараа бүх шатанд өөрөөр хэлэх юм бол улс төр, нийгэм, эдийн засаг гээд. Тэгээд одоо яг энэ давхар болж байгаа Монголын эдийн засгийн форум удаа дараалан итгэлцлийн тухай асуудал хөндөж маш их ийм хуралдсан. Янз бүрийн амлалтууд, зөвлөмжүүд гаргаж байсан. Одоо бүгдээрээ өнөөдөр ингээд хамтарсан зөвшилцлийн Засгийн газар байгуулчихсан. Мэдээж иргэд сонгогчдын итгэл улам буурах ийм хандлага магадлал өндөр. Өчигдөрхөн Монголын эдийн засгийн форум нээхэд бид нарын сайн мэдээж байгаа “Си Эн Эн”-ий алдартай сэтгүүлч Ричард Квэст гэж хэлсэн бэ гэхээр одоо та бүхэн ингээд хамтарч Засгийн газар байгуулж байгаа чинь нь юу нормал /new normal/ мөн үү Ерөнхий сайдын хэлсэнчлэн гэж асуугаад өөрөөр хэлэх юм бол шинэ жишиг гэж хэлэх үү Монголоор тогтоож байгаа гэсэн үг мөн үү гээд Ерөнхий сайд өөрөө магадгүй дэлхийд энэ жишигийг энэ загварыг бий болгож байгаа эхний 10 улс ч байж болох юм гэж хариулж байна лээ.

Тэгэхээр нийгмийн нөхцөл байдал ийм байна. Бид нарт ажлаа сайн явуулахын тулд энэ парламентад шинээр үүсэх тэр Засгийн газарт иргэдийн итгэл маш их хэрэгтэй. Итгэлцэл. Тэгж байж ажил урагшилна хурдтай явна. Тэгэхээр хамгийн түрүүнд итгэлийг бий болгох алхам үйл ажиллагаа гоц тэр ажил нь юу байх бол гэсэн ийм энгийн асуултыг асууя. Энэ бол бид бүгдэд хэрэгтэй ажил байх болно гэж харж байна. Баярлалааб

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье Ерөнхий сайдын микрофоныг.

**Л.Оюун-Эрдэнэ:** Эхний хувьд бол яг эдийн засгийн форум дээр би яг өөрийн чинь хэлж байгаа шиг тийм хариулт хэлээгүй. Бас та факт чек хийх ёстой шүү. Би юу гэж хариулсан бэ гэхлээр ер нь дэлхий дээр мажоритар буюу санал гээгддэг тогтолцоо улам бүр цахим ертөнц хөгжсөнөөр хүндэрч байгаа. Монгол энэхүү холимог тогтолцоо буюу

хувь тэнцүүлсэн тогтолцоо руу орсноороо бид нар илүү тэр улсуудаас урд явж байгаа ч байж магадгүй энийг цаг хугацаа харуулах байх гэдэг агуулгаар хэлсэн.

Ер нь мажоритар тогтолцоо буюу санал гээгддэг энэ тогтолцоо бол яг энэ орчин үеийн ертөнцөд бас их тийм хүндрэлтэй гэдэг дээр л бид нар тулгуурлаж дэлхийн 2 том хөршийн дунд байгаа парламентын ардчилалтай Монгол Улс илүү энэ олон төлөөллийг оруулж ирэх нь л өөрөө парламентын зөв жишиг байх юм гэдэг агуулгыг л би тайлбарласан.

Хоёрдугаарт, үнэн, итгэлцэл. Итгэлцэл эвдэгдсэн 30 жил байсан. Энийг нуугаад хэрэггүй. Ард түмэн энд парламент хол байсан. Би ч гэсэн нэг зүйлд маш их санаа зовж байгаа. Тэр нь юу вэ гэхлээр энэ 126-тай Монгол Улсын парламент ард түмний дунд байгаа энэ нурсан итгэлцлийн гүүр энэ 4 жилд эргэж сэргээсэй гэж би чин сэтгэлээсээ хүсэж байгаа.

Яагаад гэхлээр энэ бас Үндсэн хуулийг Ерөнхий сайд байх үедээ Засгийн газраас энэ 30 жилийн хугацаанд анх удаа Засгийн газраас өргөн барьсан ийм хуулийн төсөл Үндсэн хууль дээр, бусад үед дандаа парламентаас өргөн баригддаг байсан. Тийм учраас миний хамгийн их санаа зовж байгаа зүйл энэ итгэлцэл сэргээсэй, 126 энэ парламентын холимог тогтолцоонд орсноороо Монгол Улс хөгжин дэвжиж, институцийн ийм тоглолт, дүрэм бий болж, Монгол Улс хурдтай хөгжсөн юм гэдэг түүх үлдээсэй л гэж би чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Тэрнээс 126 болсноороо ямар ч чанарын өөрчлөлт гарсангүй. Энэ ер нь буруу байж. Ингээд олуулаа болоод бүүр учраа олохоо больчихдог юм байна. Ингээд ер нь парламентын засаглал үнэхээр хэцүү юм байна гэдэг ийм зүйл рүү битгий явчхаасай л гэж би чин сэтгэлээсээ бодож байгаа юм.

Тийм учраас энэ итгэлцлийг сэргээхийн төлөө хэдүүлээ илүү үнэн байх хэрэгтэй. Илүү хувь хүн гэдэг тоглолтоос илүүтэйгээр институц мөн сонгодог парламентын яг тэр эрх зүйт төрийн хэм хэмжээний дагуу хамтдаа сонгогчдодоо хүндэтгэлтэй хандаж, зөвхөн улс төрийн тоглолт гэхээс илүүтэйгээр яг бодитой нөхцөл байдлыг үнэнээр нь бодитой ярьж чадвал энэ өөрөө итгэлцлийг бий болгоно гэж л бодож байна. Тэгээд энэ итгэлцлийг бий болгохын тулд шаардлагатай бүх л зүйлийг хийхийн төлөө хамтдаа хичээцгээе.

Яагаад гэвэл энэ үнэхээр парламентын түүхэнд бол тодоор бичигдэн үлдэх ийм түүхэн өөрчлөлт мөн үү мөн. Харин энэ сайн өөрчлөлт байх уу, саар өөрчлөлт байсан байх уу гэдгийг цаг хугацаа харуулна. Магадгүй 20-30 жилийн дараа л дүгнэгдэх ийм зүйл. Тийм учраас бид нар тэр түүхэн дунд анхны 126-тай парламентын бас гишүүн болж байгаагаараа хамтдаа энэ итгэлцлийг сэргээхийн төлөө чадах бүх зүйлээ хийж хичээнгүйлэн ажиллая л гэж хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Болдын Уянга гишүүн асуулт асууна.

**Б.Уянга:** Эрхэм гишүүддээ оройн мэнд хүргэе. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нэрийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болгож өөрчилсөн юм байна. Тэгэхээр аж үйлдвэр эрдэс баялаг гээд яг хүнд үйлдвэр уул уурхайгаа илүү том агуулгаар нь оруулж өгч байгаад салбарын мэргэжилтэн хүний хувьд талархаж хүлээж авч байна.

Яг энэ хуулийн төсөлтэй холбоотой 4 асуулт байна. Тэгээд минутаа харж байгаад асууя. Тэгэхээр хамгийн эхлээд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг бид нар баталж чадсан. Өнгөрсөн Засгийн үед. Тэгэхээр

энэ хуулиа батлаад бид нар хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр Үндэсний баялгийн сан байж байж бид нар уул уурхайн салбарыг нийт ард иргэдээсээ дэмжлэг, салбарт дэмжлэг авах тэр механизм нь бүрдэж байгаа гэж манай салбарынхан үзэж байгаа. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүл. Энэ хуульд хуримтлагдах сангуудыг нь харьяалагдах яамнуудад нь гаргаж ирж, энэ хуулийн төсөлдөө хамрах хүрээ, эрхлэх ажил асуудал гэдэгт нь оруулж өгөх байсан уу? Энийг асуумаар байна. Яагаад вэ гэвэл Үндэсний баялгийн сангийн тухай санд хуримтлагдах тэр мөнгө, хөрөнгө нь манай уул уурхайн салбартай шууд холбоотой. Манай салбар цаашаагаа хариуцлагатайгаар эрчимтэй хөгжиж байж энэ сан маань арвижиж айл бүгдийн хаалгаар үр өгөөж нь өртөгдөх юм. Тэгэхээр яг энэ агуулгыг нь тодоор зурж оруулах байсан уу гэдэг асуулт эхлээд авъя. Асуулт эхлээд асууя.

Хоёр дахь нь болохоороо бид нар энд сууж байгаа танхимд сууж байгаа хүмүүсийн ихэнх нь л ер нь усны тухайн асуудлыг их ярьж байгаа. Усны асуудлыг ярихдаа олон төсөл, хөтөлбөрүүдийг огтлолцсон байдлаар нам болгоны мөрийн хөтөлбөрт суусан байгаа. Дахиад нэг зүйлийг хэлэхэд болохоор усны асуудал ингэж жаахан тийм нэгдсэн бодлогогүй явж байсан. Учир нь гадаргын усны асуудал Байгаль орчны яамны харьяа усны агентлаг дээр газрын доорх ус нь болохоороо Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Үндэсний геологийн албаны асуудал байдаг.

Ашигт малтмалын тухай хууль дээр яг гадаад нэршлээр нь газрын доорх усаа ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хариуцсан гээд, гадаргын усаа болохоороо Усны тухай хуулиараа Байгаль орчны яамдаа өгчихсөн байдаг юм. Тэгэхээр энэ агуулгаараа энэ 2 агентлаг маань хамтарч нэлээн мэдээллээ солилцох ч байж уу. Ямар



нэгэн байдлаар тийм зохион байгуулалтын хамтын ажиллагаанд орох шаардлагатай. Ингэж байж түрүүн Мөнхбаясгалан гишүүний хэлсэн тэр төсөл, хөтөлбөрүүдийг явуулахад тал талын мэргэжилтнүүд хамтарч ажиллах нөхцөл нь бүрдэх байх. Энэ дээр боломж олдож байгаа дээр Ерөнхий сайдад хэлж байгаа юм шүү. Тэгээд яг энэ хоёр яамдын хамтын ажиллагаа нэлээд чухал. Энэ дээр бас танд төлөвлөсөн зүйлүүд байгаа бол тайлбарлаад өгөөрэй.

Гуравдугаарх нь болохоороо яг энэ хуулийн төсөл дээр бүх яамны чиг үүрэг дээр агаарын бохирдлын асуудлыг тусгайлан бичиж өгсөн байна. Энэ дээр тайлбар авъя. Агаарын бохирдлын асуудал бол мэдээж чухал. Гэхдээ магадгүй Үндэсний баялгийн сангийн тухай хууль ч гэсэн чухал юм чинь холбогдох яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Хүний хөгжлийн яам, Сангийн яам, тэгээд бас манай яам, Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яамны бас асуудалд нь оруулж өгөх байсан уу?

Дөрөвдүгээр сүүлийн асуулт нь болохоороо Боловсролын яам болоод ингээд тусдаа гарч байна. Тэгэхээр Боловсролын яамны эрхлэх асуудлын хүрээнд энэ насан туршийн боловсрол гэдэг асуудлыг ер нь бид нар гаргаж тавих ёстой байх. Тэгээд манайхан 40 гараад ирэхээрээ л дахин бид нар боловсорно гэж байх вэ гэдэг агуулгаар тийм хойш суух үзэгдэл байдаг. Тэгэхээр энэ насан туршийн боловсролын асуудлыг Боловсролын яам жинхэнэ утгаар нь харгээд хамрах хүрээнд нь оруулж өгвөл ямар вэ? Ийм 4 асуултыг асууя.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Энэ парламент маань илүү тийм төлөөлөл томорсон ийм бас давуу талуудын нэг гарч байна гэж бас үзэж байгаа юм. Яагаад гэхлээр

үнэн. Яагаад гэхлээр та бол уурхайн салбарын бас Монгол Улсын цөөхөн мэргэжилтнүүдийн нэг. Байгаль орчны салбарын мэргэжилтнүүд бас орж ирсэн байна. Одоо яах вэ гэхлээр хувь хүн гэхээс илүүтэйгээр бүхэл бүтэн салбарын төлөөлөл тэгэхлээр уул уурхай, байгаль орчин хэрхэн хоорондоо уялдаатай байх вэ гэдэг энэ агуулгыг энэ парламент эрх зүйн хувьд тодорхойлно л гэсэн үг ер нь бол. Тэгэхээр урьд нь магадгүй уул уурхайн салбарын уул уурхайн сайд л дуугардаг. Парламентын гишүүдийн хувьд уул уурхайг хамгаалж дуугарна гэдэг бас л их тийм цөөхөн байдаг байсан.

Гэтэл бид нар уул уурхай дээр тогтдог. Бид нар эрдэс баялгаа ашиглах ёстой. Ялангуяа нүүрсийг бид нар маш хурдтай ашиглахгүй бол удахгүй нүүрс маань ингээд зарагдахаа болино. Харин яаж бид нар харилцан байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологид тулгуурлах вэ гэдэг агуулгаараа аж үйлдвэр болон эрдэс баялгийн энэ салбар хамтдаа байх нь зүйтэй гэж үзсэн.

Агаарын бохирдол болон бусад асуудлын хувьд энэ салбар дамнасан асуудал. Яагаад гэхлээр агаарын бохирдол, хот төлөвлөлтийн энэ асуудал бол зөвхөн өнөөдөр харагдаж байгаа асуудал энэ шинж тэмдэг. Тэгэхээр шинж тэмдэг өөрөө цогц асуудал учраас нэг зүйлээс болж ийм асуудал үүснэ гэж байхгүй. Тэгэхлээр агаарын бохирдлын хувьд энэ зөвхөн Байгаль орчны яамны ч юм уу эрхлэх асуудал биш. Энэ бол яам бүхний институц бүхний л хамтдаа хийж хийх ёстой зүйл. Тэгэхлээр шинж тэмдэгтэй зууралдаад байвал бид нар цаг алдаад л байна. Шинж тэмдэг болсон үндсэн асуудал руугаа салбар бүхэн очиж цогцоор харж чадвал аяндаа энэ шинж тэмдэг өөрөө алга болно.

Тийм учраас илүү салбар дамнасан асуудлуудыг бүх яамны эрхлэх асуудал дээр бичсэн байгаа гэдгийг бас хэлье. Тэгээд би сонгодог парламент гэж

байнга яриад байгаа нь төлөөллүүд маань бусад салбарынхаа итгэл үнэмшлийг бий болгосон ийм албан бус ийм бүлгүүдийг байгуулдаг. Тэгээд энэ бүлгүүд хоорондоо парламент дээр маш хурдтай зөвшилцөж чадсанаараа ишийдлээ олж чадахгүй байгаа асуудлуудыг маш хурдтай явуулж чаддагаараа энэ зөвшилцлийн ардчилал хамаагүй давуу талтай гэж үздэг. Тэгэхээрээ би үндэсний баялгийн сан, мөн хөрөнгө оруулалт, уул уурхай, хүнд үйлдвэр, байгаль орчны хамгаалал зэрэг олон ийм маргаантай асуудлууд энэ парламентын үед илүү тэнцвэрийн цэгээ олж, илүү зөвшилцөл, ийм хамтын, дундын ишийдэл рүү явж чадна гэдэгт бас итгэлтэй байна.

Усны асуудлыг би хөндөж байгааг ойлгож байгаа. Тэгээд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал ч гэсэн зөвхөн аймаг өөрийгөө хараад байх биш, илүү аймгууд хамтдаа асуудлуудаа ишийдвэрлэх энэ л боломжийг олгох гэж илүү бүсчилж байгаа. Тэгэхээр илүү бид нар энэ 4 жилийн хугацаанд томоохон суурь асуудлууд бол ишийдвэрлэгдэх байх. Суурь асуудлуудыг ишийдвэрлэж чадвал деталь асуудлууд дагаж ишийдвэрлэгдэнэ гэдэгт би итгэдэг. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууна.

**Г.Дамдинням:** Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр бид нар энэ шинэ яамнуудыг байгуулах тэгээд тухайн салбаруудын хариуцах сайд нарын хийх ажлуудын талаар л үүрэг хариуцлагыг нь хувааж байгаа. Тэгээд би энэ хамтарсан Засгийн газарт аль нам нь, хэн нь энэ яамнуудыг авахыг бол одоогоор бид нар мэдэхгүй.

Тэгэхдээ нэг ийм асуудал байгаа юм Монгол Ардын намын 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ёстой. Дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг

хэрэгжүүлэхэд боловсролын салбар дээр бол жишээ нь 2 сургуулийг топ мянгад оруулна, дэлхийн топ мянгад оруулна их сургуулийг оруулна. Боловсролын салбарт судалгаа, шинжилгээ, инновацыг нэвтрүүлнэ гэсэн ийм амлалтыг бид нар бол ард түмэнд өгсөн. Тэгээд энэ орж ирж байгаа хуулийн төсөл дээр Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд шинжлэх ухаан, инновацын асуудал ерөөсөө байхгүй болчхож. Тэгэхээр манай боловсролын салбарт хамгийн тулгамдаж байгаа асуудлын нэг нь юу вэ гэхээр зөвхөн сургалтыг дагнаад шинжлэх ухаан, инновацыг энэ салбар руугаа шингээх талаас нь асар том дутагдалтай байна гэдэг дүгнэлтийг өнгөрсөн 4 жил бид нар хийгээд энэнийхээ хүрээнд Боловсролын ерөнхий хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг хамтдаа баталсан.

Тэгэхээр энэ хуулиудын үзэл санаа бол ерөөсөө л үндсэндээ шинжлэх ухаантайгаа боловсролын салбараа холбож дан ганц оюутанд суурилсан эсвэл сургалтад суурилсан боловсролын тогтолцооноос инновац руу, шинжлэх ухаан руу чиглэсэн тэгээд үйлдвэрлэл рүү холбож чаддаг ийм боловсролын тогтолцоотой болно гэсэн ийм зорилготой яваад байгаа.

Тэгэхээр энэ шинээр болох Боловсролын сайд нөхрөөс бол бид нар жишээ нь яг энүүгээр батлаад гаргачихвал шинжлэх ухаан, технологи, инновацын талаар юу ч нэхэж чадахгүй болж таарах гээд байна. Тэгэхээр энийг анхаараад энэ Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд энэ инновац, шинжлэх ухааны асуудлыг оруулж өгвөл яасан юм бэ гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт, ингээд бид нар шинэ Засгийн газар байгуулаад шинэ нэртэй яамнууд байгуулна гэдэг бол үндсэндээ бүтцийн өөрчлөлт зохион байгуулалтын өөрчлөлтийг тэр чигт нь хийх эрх зүйн суурийг нь тавиад өгчхөж байгаа юм. Төрд ажиллаж байгаа бүх төрийн энэ

яамдад харьяалагдаж байгаа төрийн албан хаагчдын хувьд энэ ажилгүй болох нөхцөл байдал нь бэлэн болчихож байна л гэсэн үг. Одоо тэгээд л яригдаж байгаа байдлаас ингээд харах юм бол магадгүй босоо томилгоотой гэдэг юм уу улс орон даяар ингээд явагддаг томилгоотой байдаг яамнууд аль нэг яам руу очлоо гэж бодъё магадгүй түрүүн хамгийн тодорхой байгаа нь Хууль зүй, дотоод хэргийн яам манай Ардчилсан намд очих юм шиг байна. Тэгээд өнгөрсөн 4 жилийн турш бид нар чинь нүүрсний хулгай гээд л хөөрхий муу хуулийнхныг хаа сайгүй л шахсан, зөндөө юм гарсан, зөндөө хэлэлцүүлэг хийсэн. Тэгээд өшөө авах юм болоод хувирчих вий дээ хөөрхий төрийн албан хаагчдаас маань. Тэгэхээр энэ төрийн албан хаагчдыг хоморголон халахгүй байх, зүй бусаар шахах энэ юмнаас хамгаалах талаар бас Ерөнхий сайд та ямар арга хэмжээ авч байгаа вэ? Энэ дээр бас анхаарч бодохгүй бол бид нар чинь бас томоохон бодлого хэрэгжүүлээд зүтгэж байгаа улс төрийн хүчин байгаа. Тэгээд энэ дээр бас хариулт хэлчихвэл сайн байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Бид хуулиа л барина. Тэгээд бид нар үндсэн агуулга ругаа бас орох хэрэгтэй. Тэр нь юу вэ гэхлээр төрийн бүтцүүд дээр бид нар данхар байна гэж ярьдаг. Гэтэл яг данхар байна гэдэг бол парламентын гишүүд 76-г 126 болгох энэ тоо бол ер нь яг үндсэн агуулгаараа биш. 225 орчим мянган төрийн албан хаагчид байгаа. Яаж энэ бүтцүүдийг хооронд нь илүү чиг үүргийн хувьд давхцалгүй болгох вэ гэдэг асуудал. Зарим төрийн албан хаагчид маш их ачаалалтай байдаг, маш их ачаалалтай бараг тэд нар гэртээ ч харих завгүй. Зарим төрийн албан хаагчдын хувьд маш бага ачаалалтай байдаг.

Тэгэхээр бид нар үүн дээр бүтцийн ийм үнэлэлт шинжилгээг хийх ёстой. 4 удаагийн ийм том дүгнэлт

гарсан байдаг өнгөрсөн хугацаанд. Үүнийг Хэрэг эрхлэхийн сайд байсан бүх хүмүүс мэднэ. Улс төрийн намууд зөвшилцөж чадаагүй энэ бүтцийн реформыг хийх дээр. Тэгээд л яг ийм зүйлүүд ингээд л яригддаг.

Тэгэхлээр одоо ингээд би бас Дамдинням гишүүнээс уриалж байгаа зүйл яг парламентын гишүүн ингээд л яриад унахаар яг төрийн албан хаагчид тэгээд л ойлгочихно. Бид нарыг ингээд л намын харьяаллаар халах гэж байгаа юм байна. Ингээд л яах вэ гэхлээр урьд нь үйлдвэрчин босчихдог байсан. Манай Эрдэнэбат маань орж ирээд сууж байна. Ингээд л бас бусад улс төрийн намууд маань тэр нь зөв байна уу, буруу байна уу хамаагүй оноо авах гээд л улс төр хийгээд эхэлчихдэг. Тэгэнгүүт яришиг орон нутгийн сонгууль болох гэж байгаа юм чинь больчихъё гээд л ингээд больчихдог. Ингээд байж байтал шинэ он гараад хавар болдог. Хавар яришиг яришиг хүмүүс ууртай байгаа юм чинь больчихъё, наадмын өмнө бужигнуулаад яах вэ больчихъё, 9 сарын 1 болно хичээл эхлэх гээд байгаа юм чинь больчихъё гээд ингээд л 2, 3 удаа яваад л ингээд л реформ хийж чадаагүй байгаад л ингээд явчихсан.

Тийм учраас төрийн албан хаагчдыг бид нар энэ зөвшилцөл хийгдсэнээрээ ямар нэгэн байдлаар эрх ашгийг нь хөндөхгүй. Би энийг албан ёсоор хэлье. Харин давхардсан чиг үүргүүдийг нэгтгэх илүү төрийн албан хаагчид ачаалал нь тэнцвэртэй байх, цалин нэмэгдэх энэ зүйлийг л бид нар хийх учиртай. ТӨК-уд дээр ч гэсэн бид нар илүү Хулдалдаа аж үйлдвэрийн танхимтайгаа, үйлдвэрчинтэйгээ ярьж байгаад бид нар яаж үүний засаглалыг сайжруулах вэ гэдэг рүү л одоо бид нар хамтдаа алхчих ёстой.

Яагаад гэхлээр бид нар удаан хугацаанд үүнийг ярьсан. Тэгээд одоо яг ярьж байсан зүйлээ л бид нар хийчих учиртай. Тэгэхээрээ бид нарын хувьд

өмнө нь ярьж байсан аль аль намын мөрийн хөтөлбөрүүдэд төрийн энэ данхар бүтцийг багасгах тухай ийм асуудлууд байгаа Чиг үүргүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх тухай асуудлууд байгаа. Ашиггүй байгаа ТӨК-удыг нэгтгэх тухай асуудлууд байгаа.

Тэгэхээр одоо бид нар энэ хүнээ энэ дээр томилчихъя, төрийн өмчит үйлдвэрийн газар дээр орлогч буцаагаад гаргачихъя, эсвэл агентлагуудын орлогчийг нэмчихье тэгвэл бидэнд хэрэгтэй гээд л эхэлбэл буруу тийшээ явчихна гэсэн үг.

Харин бид нар 225 мянга байгаа энэ чиг үүргийн давхцалыг яаж илүү бүтээмжтэй болгох вэ гэдэг тал руу хамтдаа алхаж чадвал хүсээж байгаа том реформоо хийж чадах болно шүү.

Тийм учраас бас парламентын гишүүд та бүхнээс хэлэхэд энэ асуудал хуулийн дагуу мөн бүтээмжид тулгуурласан энэ л агуулгаар хийгдэнэ. Тэрнээс хэт намчирхдаг энэ асуудлыг бол бидний хувьд хийхгүйгээр маш бүтээмжтэй байх энэ агуулга дээр тулгуурласан үндсэн реформоо хийж чадвал энэ өөрөө бүтээмж болно.

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна.

**М.Мандхай:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Миний хувьд 2 асуудал байна. Нэг нь болохоороо энэ байгаль орчныг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулж байгаа энэ нэр томъёо маш сайшаалтай гэж би харж байна. Яагаад гэвэл олон улсын бүх байгууллага салбар өөрөө бүх шатдаа уур амьсгалын өөрчлөлтийг нэвтрүүлж эхэлж байгаа.

Тэгэхлээр бид ч гэсэн бас яг энэ уур амьсгалын өөрчлөлтийн дэлхийн энэ чиг хандлагатай бас хоцрохгүй уялдаж бодлого хууль тогтоомжоо бас хэрэгжүүлээд явах нь зүйтэй. Тэгээд надад нэг санал байна. Засгийн газрын

энэ хэрэгжүүлж байгаа томоохон аж үйлдвэржилтийн төсөл, хөтөлбөрүүд байн ирэх 4 жил хэрэгжүүлэх, мөн өдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ялангуяа энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам өөрөө онцгой ач холбогдолтой гэж харж байгаа.

Гэхдээ бас бусад яамнуудад харьяалалтай уур амьсгалын сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой бас хуулиуд хэрэгжээд явж байгаа. Тэгэхлээр энэ яамны хувьд бас бусад яамныхаа чиг үүрэг энэ уялдаа холбоогоо, огтлолцлыг бас маш сайн хангаж ажиллаж чадах юм бол бид нар энэ урт хугацааны энэ аж үйлдвэржилт, бүсийн хөгжил, “Алсын хараа-2050- гээд урт болон дунд хугацааны энэ төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд аяндаа бас энэ гаднын хөрөнгө оруулалт энэ санхүүжилтийн бас таатай орчин үүсэх боломжтой гэж харж байгаа. Тэгэхлээр энэ дээр бас ингээд уялдаа холбоогоо анхаараад яваасай гэж хүсээж байна.

Хоёр дахь асуудал дээр болохоор бас нэг ийм тодруулах болон бас тодруулга авах ийм хүсэлтэй байна. Тэр нь болохоор Гэр бүл, хүний хөгжил гээд бас яам нэр одоогийн байгаа яамыг бол бас нэр томъёог нь өөрчилж орж ирсэн байна. Тэгээд Гэр бүл, хүний хөгжил гэдэг нь өөрөө Засгийн газрын бас тэргүүн эгнээнд авч үзэх ёстой асуудал.

Гэхдээ бид энэ томоохон түрүүний хэлсэнчлэн аж үйлдвэржилт ялангуяа бидний хувьд энэ урт хугацааны бодлогын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ажлын байрыг нэмэгдүүлэх, энэ хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх гэдэг нь өөрөө бас томоохон анхаарах асуудал байгааад байгаа.

Тэгэхлээр энэ гэр бүл, хүний хөгжил дотор бас дээрээс нь нэмээд энэ хөдөлмөр эрхлэлтийг бас тусгаж өгч болоогүй юу, эсвэл энэ хүний хөгжил дотроо хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг



бас агуулсан гэж үзэж байгаа юу гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт бас бид нар энэ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заагдсан үндсэн эрх, эрх чөлөөгөө баталгаагаар хангагдсан энэ зорилтот бүлэгт шаардлагатай нийгмийн хамгааллын асуудлыг бас орхигдуулахгүй байвал яасан юм бэ? Тэгэхлээр ерөөсөө хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал гэсэн энэ 3 зэрэг хаягдахгүй зэрэг хөгжүүлж авч явах ёстой энэ 3 асуудлыг нэгтгээд ийм шинэчилсэн ийм нэр томъёогоор өөрчлөх боломж байгаа юу гэж асуумаар байна.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье Ерөнхий сайдын микрофоныг.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа. Нийгмийн гол асуудал бол гэр бүл, хүн гэдэг рүүгээ л чиглээсэй л гэж бодож л энэ агуулгыг гаргасан. Энэ гэхдээ одоо ч гарч байгаа биш л дээ урьд нь 4 ч удаа парламент дээр яригдаж байсан ийм асуудал. Тэгэхээр ингээд нийгмийн хамгаалал, хөдөлмөр, тэгээд хүн ам гэхчээр энэ их тийм хол болчихож байгаа юм. Хүн ам гэхлээр ингээд ийм ерөнхий л ийм асуудал. Тэгэхээр ерөнхийгөөс тодорхой явахгүй бол бид нар ингээд асуудлаа шийдэж чадахгүй ийм том бүтэцтэй л яваад байгаа юм л даа.

Тийм учраас л гэр бүл гэдэг энэ нэршлийг Азийн, ялангуяа бусад улс төрийн парламентын засаглалтай улс орнууд дийлэнхдээ л ашигладаг. Тэгэхээрээ төр өөрөө илүү иргэнд ойрхон байх, төр иргэн хоёр тусдаа биш байх, илүү хамтдаа зааг багатай байх, ойлголцоосой гэдэг энэ агуулгаар л энэ гэр бүл, гэр бүлийн л төлөө бид нар хамгаалж байгаа. Нийгмийн хамгаалалд байгаа гэр бүлийн л төлөө хөдөлмөр эрхлэлт байгаа, гэр бүлийн л төлөө хүний хөгжилд байгаа гэдэг энэ агуулга руугаа ороосой тэгэхгүй тийм хол л болчихоод байсан юм. ер нь бол нийгмийн хамгаалал гэхлээр их ерөнхий хөдөлмөр. Хөдөлмөр

бол бараг илүү боловсролтой уялдах, эдийн засагтайгаа илүү уялдах салбар шүү дээ.

Ер нь Боловсролын яамны бэлдэж байгаа хүний нөөц, хөдөлмөр эрхлэлт дээр илүү нийцэх ёстой. Тэгэхгүй хөдөлмөр эрхлэлт нь нэг өөр тийшээ яваад байдаг, боловсролынх нь систем нэг өөр тийшээ яваад байдаг байж болохгүй. Тэгэхээр энэ агуулгаараа бас Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам илүү бид нар нийгмийн хөдөлгөгч хүч болсон гэр бүл рүү хүн нэг бүр рүү чиглэдэг ийм төрийн үйлчилгээний байгууллага гэдэг агуулга дээрээ илүү төвлөрөх энэ яг зөвхөн нэр биш л дээ. Дотор талд нь ч гэсэн энэ асуудлууд байгаа.

Дээрээс нь хүүхэд залуучуудын асуудлыг ингээд нэг болгочихдог, би өөрөө хүүхдийн байгууллагад ажиллаж байсан. Хүүхдийн асуудал гэдэг бол маш тусдаа асуудал. Залуучуудын асуудал гэдэг бол өөрөө маш их тусдаа асуудал. Залуучууд илүү орон сууцжуулалт, мөн илүү нийгмийн амьдралд оролцох, төлөвших энэ агуулга руугаа илүү явах ёстой. Хүүхэд бол илүү эрүүл орчинд гэр бүлтэйгээ хамт өсөн торних гэдэг энэ агуулга руу.

Тэгэхлээр энэ хоёр ингээд холилдоод агентлаг болгоод нэг чиг үүрэгтэй ингээд яваад байхаар гэр бүл гэдэг үндсэн концепц үндсэндээ ингээд алдагдаад хүүхдийн ч байгууллага байхгүй залуучуудын ч байгууллага байхгүй ийм болчихоод байгаа юм. Тийм учраас би санал нэг байна. Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөр гэдэг энэ агуулгаараа явчхаж болно. Хүний хөгжил гэж оруулж ирсэн нь зүгээр салангид биш илүү цогц байдлаар нийгмийнхээ тусгалыг хараасай л гэж үзэж энэ нэршил рүү. Гэхдээ энэ юу шүү, Ариунзаяа сайд байж байна тээ? Нийгмийн хамгааллын яам, нийгмийн хамгааллын салбарынхан, олон улсын байгууллагуудын манай улсад сүүлийн

бараг 20 орчим жил зөвлөж ирсэн зөвлөгөө шүү.

Тэгэхээр бид нар ингээд энэ нэршлүүдийг ингээд оруулж ирээд байгаа зүйл биш дандаа л олон улсын байгууллагуудын парламентад дандаа л зөвлөж байсан зөвлөгөөнүүд дээр л үндэслэсэн гэдгийг та бүхэн маань бас ойлгоорой.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэбат:** Баярлалаа. Монгол Улсын Үндсэн хууль дээр засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэж үг байгаа. Тэгэхээр ер нь зарим парламентын гишүүдэд хэлэхэд ард парламент өөрөө зөвхөн намын мэдэлд байна гэсэн үг бол байхгүй. Тийм учраас нийгмийн бүлгийн төлөөлөл, жирийн иргэдийн төлөөллийг орж ирэх боломжийг нь гаргаж ирэхийн тулд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийж байж бас нэгэн төрийн өндөр босгыг жирийн ард иргэд бас өөрийнхөө дуу хоолойг тэр танхим дотроо сонсох гэдэг энэ утгаар нь оруулж ирсэн. Тэр ч утгаараа аль аль намууд бас энэ тал дээр анхаарсан болов уу гэж би харж байгаа юмб

Хоёрдугаарт, манай Монгол Улс маань хүн ам цөөтэй. 3 тэрбум хүн ам дэлхий дээр хөдөлмөр эрхэлж байгаагийн сая гарах нь л Монголд байгаа. Тэгэхээр бид нарын хувьд энэ хөдөлмөр эрхлэлтийн бодлого, макро эдийн засгийн хамгийн гол үзүүлэлтүүдийн нэг байдаг. Манайх харамсалтай нь 3 дахь, 4 дэх асуудал болгоод бас явж ирсэн. Сүүлийн жилүүдэд бас нэлээн энэ дээр анхаарсан. Нэгдсэн Үндэстний Байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын төрөлжсөн нэг л байгууллага байдаг. Гурван талт удирдлагатай, олон улсын хөдөлмөрийн байгууллага гэж. Тэгэхээр энэ дээр юу гэж бид нарт үүрэг даалгавар өгсөн бэ гэхээр зохист хөдөлмөр эрхлэлтийг 2030 он гэхэд оруулж ир, нийгмийн баялаг чинь

шударга бус байна, төр засаглалын хэлбэр чинь оролцоогүй байна гээд дэлхийн бүх орнуудад тавьсан. Тэгээд энэ тал дээр манай улс маань бас манлайлах ёстой. Бид нар бол анхаарлын төвд байдаг бас орнуудын нэг.

Тийм учраас би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэ нийгмийн түншлэлийн асуудал энэ шинэ Засгийн газрын бүтэц дотор нийгмийн түншлэл, хөдөлмөр, нийгмийн хамгаалал гээд тогтоож ирсэн нь уламжлал байдаг. Гэр бүл гэдэг өөрөө бас их чухал байгаа. Одоо бид нараас 4 жилийн дараа манай гэр бүлийн орлого яаж өссөн бэ, миний хүүхдийн боловсролын чанар яаж сайжирсан бэ гэдэг ийм зүйлийг асууна. Тийм учраас та бүгд маань сонгогчдынхоо тойргуудынхаа гэр бүлийн орлого одоо ямар байгаа, өөр юугаар сайжирсан бэ гэдэг зүйл дээрээ одоогоос авхуулж анхаарал хандуулах шаардлагатай учраас би бас Ерөнхий сайдын Засгийн газрын оруулж ирж байгаа энэ гэр бүлийн гэдэг нийгмийн хамгийн анхан шатны нэгжийг яамны түвшинд анхаарал хандуулж оруулж ирээсэй гэж. Ядуурал өөрөө гэр бүлийн залгамж чанартай байгаад байдаг гэдгийг олон улсын байгууллагууд бас анхааруулаад байгаа юм.

Тийм учраас ядаж 1 гэр бүлээс сайн ажлын байртай, тогтвортой ажлын байртай ийм бодлогыг байнга авч явахгүй бол бид нар 1 хүнд ноогдох дотоодын бүтээгдэхүүн өсөж байгаа боловчиг яг хэдэн гэр бүлд тэр нь өөрөө тэнцвэртэй хүрч байна вэ гэдэг асуудал өөрөө их чухал байгаа юм. Энэ асуудлыг би бол тодорхой хэлмээр байна.

Тийм учраас түрүүн бас Мандухай гишүүн хэлчихлээ. Энэ гэр бүл, хүн амын хөгжил, хөдөлмөрийн яам гэдэг энэ олон улсын нэршил, олон улсын бас чиг хандлага дийлэнх орнуудад энэ либер гэдэг үг байнга байдаг. Тийм учраас энэ зүйл дээр бол энэ хөдөлмөр гэдэг үгийг оруулж нийгмийн хамгаалал гээд л,

халамж гээд л бид нар бас их ярьдаг. Халамж дотор чинь хамгийн том эзэлж байгаа нь хүүхдийн мөнгө шүү дээ. Тэгээд сая би сонгуулийг харж байхад бүгдээрээ л би хүүхдийн мөнгийг олгоно, цааш нь явуулна энэ тэр гээд л. Ингээд л манайхан аягүй сайхан ярьцаасан. Тийм учраас энэ халамж хавтгайрлаа энэ тэр гэдэг зүйл дээрээ бид нар энэ зардлынх нь бүлгийн хувьд аваад үзэхэд хамгийн том бүлэг нь энэ. Ийм зүйл байгаа юм.

Тийм учраас Ерөнхий сайдаас хэлэхэд энэ түрүүний хэлдэг томъёоллыг та бас хэлчихлээ. Одоо би яг хэлэх гэж байсан юм. Ер нь ийм томъёолол байж болох юм гэж. Уламжлал шинэчлэл гэдэг дундуур Гэр бүл, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам гэдэг энэ зүйл дээр бас энэ бүтцээ тавьж өгвөл өргөн утгаараа маш олон зүйлийг багтаачих юм байна.

Дээрээс нь гэр бүлийн хөгжлийн асуудал. Энэ асуудал дээр илүү анхаарал хандуулаад явах болов уу гэдэг талаас нь хэлмээр байна. Тийм учраас энэ зүйл дээр бас та бүтцийнхээ хувьд бас анхаарч үзээч гэдэг зүйлийг хэлье. Энэ саналтай олон бас нийгмийн бүлгийн газруудаас санал

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ерөнхий сайдын микрофоныг өгье. Хариулт өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Баярлалаа. Үйлдвэрчний бас төлөөлөл, Үйлдвэрчний эвлэл санал гаргаж байгаад хүндэтгэлтэй хандаж байна. Энэ парламентын бас ингээд давуу тал бол өөрөө энэ байгаа юм л даа. Хэрвээ үйлдвэрчний төлөөлөл байгаагүй бол магадгүй гишүүд ингээд олонхоороо санал хураагаад шийдчихнэ. Шийдвэрлэсний дараа асуудал үүснэ. Тэгэхээр өнөөдөр ингээд үйлдвэрчний төлөөлөл өөрөө парламентад байгаа учраас нийт институцийг ингээд төлөөлж бас байр суурь илэрхийлж байна гэж ойлгож байна. Тийм учраас

миний хувьд хүндэтгэлтэй хандаж байна.

Тэгээд гэр бүл, нийгмийн хамгаалал мөн хөдөлмөр гэдэг энэ нэршил байх нь зүйтэй гэдэг дээр парламентад онцгой бүрэн эрх байгаа. Миний хувьд энэ өмнө нь бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр 2, 3 ч гишүүн ярьсан тийм ээ? Би тэгээд парламентын гишүүддээ хүндэтгэлтэй хандаж байна гэдгээ хэлье. Тэгээд л яг ийм агуулгаар хэдүүлээ мэтгэлцээд л хамгийн зөв гэдэг рүүгээ ярилцаад л ингээд явж чадвал илүү төлөөллийн төв байгууллагууд болох парламент илүү үүргээ гүйцэтгэж, төр, иргэн 2 илүү ойртож байна л гэсэн агуулга юм гэж бодож байна. Тэгэхээр Эрдэнэбат гишүүний хэлсэн саналыг хүлээж авч байна.

**Д.Амарбаясгалан:** Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууна.

**Х.Ганхуяг:** Надаа 3, 4 санал байна. Нэгдүгээрт бид нар энэ гэрээ мөрийн хөтөлбөрөө эцэслэснийх нь дараа уг нь энэ бүтцээ зурсан бол арай илүү оновчтой байх байсан юм болов уу гэдэг хувийн бодол байна. Бид нар хаана, хаашаа нисгэж байгаа юм, хаана буух гэж байгаагаа мэдэхгүйгээр ингээд том аварга онгоц угсарч байгаа юм шиг л ийм бүтэц зурагдаад байна л даа. Яагаад тэгж байна гэхээр бид нар яг хэний мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх юм, манайхаас юу орох юм, нөгөө талаас орох юм? Тэгэхээр тэн дээрээ тулгуурлаад уг нь энэ бүтцээ зурсан бол, одоо энэ байгаа сайд нараа ганц сар үргэлжлүүлээд үүрэг гүйцэтгэгчээр нь явуулж байгаад тэгээд энэ нөхдүүдтэйгээ гэрээ зурж эцэслэснийх нь дараа уг нь бүтцээ зураад явсан бол илүү оновчтой байх байсан юм болов уу гэж бодох юм.

Яагаад гэхээр бид нар үндсэндээ эхний 1 жил л том том төслүүдийг хөдөлгөх боломжууд гарна. Яг прагматик байдлаар харвал. Тэгээд яг



жилийн дотор яг юу юугаа хөдөлгөж чадах юм гэдгээ. Уг нь тэгээд тэрэнтэйгээ улбаатайгаар яг алин дээр нь, хэн дээр нь ямар ямар албан тушаал дээр ямар сайд байвал тохиромжтой юм гэдэг бол Ерөнхий сайд өөрөө шийдээд явчихвал зохимжтой байсан юм болов уу гэдэг бодол төрж байна.

Хоёрдугаарт энэ 20 минутын хот гэдгийг хотын сайд гэгчихсэн 1 албан тушаалтан байна л даа. Тэгээд энийг уг нь Нийслэлийн Засаг даргаа давхар энэ албан тушаалыг хацуулсан бол илүү оновчтой байх байсан юм болов уу? Яагаад гэхээр энэ 20 минутын хот гэдэг маань өөрөө эргээгээд л нөгөө сургууль, цэцэрлэг барих, гэр хорооллуудаа сургууль, төрийн, нийтийн үйлчилгээг ойртуулах ийм ажлыг хийх ёстой хүн байхгүй юу. Нөгөө зам харгуйгаа барих. Тэгээд энэ дээр чинь газар чөлөөлөлтийн асар их олон асуудал яригдана. Салбар хоорондын зохицуулалтын асуудлууд орж ирнэ. Боловсролын яамтайгаа хамтарч ажиллана, Эрүүл мэндийн яамтайгаа хамтарч ажиллана, нийгэм хамгааллын яамтай хамтарч ажиллана. Тэгээд тэр тэр яамнууд нь өөр мэдэхгүй энэ бусад намын хүмүүс очих нь яг хамтраад ажиллаж чадах уу үгүй. Тэгээд энэ чинь бас бид нарын манай мөрийн хөтөлбөрт орсон хамгийн том асуудлуудын нэг гэж би харж байгаа. Тэгээд энэ чинь нэлээн том координацын асуудал байгаа. Би бол энэ дээр бараг тэр Нийслэлийн Засаг даргыг нь шууд сайд болгоод явчихсан бол илүү оновчтой байх байсан юм болов уу? Эсвэл энэ хүн дээр эрх үүргийг нь, эсвэл бүрэн эрхийг нь нэмэгдүүлэх байдлаар асуудлыг нь шийдсэн бол зүгээр байсан юм болов уу гэж харагдаж байна.

Эдийн засгийн хөгжлийн яамыг энэ Хөрөнгө оруулалтын газрыг нь салгаад агентлаг нь салгаад нэг тийш нь явуулчхаж байгаа юм байна. Эдийн засгийн хөгжил гэдэг маань өөрөө хөрөнгө оруулалт, гадаад худалдаа, төсвийн бодлого, татварын бодлого байхгүй юу. Ингээд май гээд л 1

агентлагаа ийш нь шилжүүлчихдэг. Тэгээд хөрөнгө оруулалтын бодлого нь яах юм? Хөрөнгө оруулалтын хуулиа яах юм? Бид нар сая өнгөрсөн 4 жил Хөрөнгө оруулалтын хуулиа ч батлуулж чадаагүй. Тэгээд 2 шадар сайд нь хоорондоо ажлаа нааш нь цааш нь шидэлцээд л ажил нь явдаггүй байх байдлаар харагдаж байна. Манай мөрийн хөтөлбөрт орсон томоохон ажил бол Баялгийн сангийн хууль байгаа. Хуримтлалын сан Нийгмийн хамгааллын яам дээрээ. Ирээдүй хөгжлийн сан нь Хөгжлийн яам дээрээ. Ирээдүйн хөгжлийн сан нь болохоор Сангийн яам дээр гээд. Энэ дээр чинь ихэнх дээр нь журам нь ч гараагүй байгаа. Тэгээд энэ манай намын мөрийн хөтөлбөрийг энэ яамнууд дээр нь өөр намын хүмүүс оччихвол яг манай намын мөрийн хөтөлбөрт оруулсан тэр үг утгаар нь хэрэгжүүлэх үү, үгүй юу. Би Ерөнхий сайдыг тэр 300-350 хуудастай тэр гэрээ хийж байгаа дээр талархаж байна.

Гэхдээ хийчхээд энэ бүхнээ ярихгүй бол бүх юмаа тохирчхоод оруулахгүй бол ажил нь гацаагаад ийш тийшээ хараад тэгээд яг эхний 1 жил, энэ торгон 1 жилээ алдчих вий. Тэгээд энэ бас агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх гээд яг энэ дээр харах юм бол 7 сайд дээр энэ ажил үүргийн хуваарьт орчихсон байгаа юм. Хэнийх? Бүгдээрээ хоорондоо ингээд л шидэлцээд байна гэсэн үг шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ерөнхий сайдын микрофоныг өгье.

**Л.Оюун-Эрдэнэ:** Ерөнхий сайд томилогдсоноос хойш 14 хоногийн дотор Засгийн газрыг эмхлэн байгуулах ийм хуулийн заалттай. Тэгээд Засгийн газар байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор Үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хуралд оруулж ирж батлуулах хуулийн заалттай.

Тэгэхээр бид нар парламентын баталсан хуулийн дагуу л гүйцэтгэх засаглал ажиллах учиртай.

Цааидаа ер нь бол энэ парламентын ялангуяа энэ холимог тогтолцоотой улс орнууд үнэн. Эхлээд улс төрийн намууд гэрээгээ байгуулаад, түүний дагуу бүтцээ тодорхойлоод, тэгээд бүтцэтээ тохирсон хүний нөөцөө бүрдүүлээд, тэгээд төсвөө хийдэг. Тэгэхээр бид нар 76-аас шууд 126 руу ингээд орчхож байгаа учраас энэ удаагийн асуудал дээр бол илүү бас мэдээж шинэ тутам ийм асуудлууд хамтын ийм сорилтууд тулгарна. Соёлтой ч гэсэн бид нар ингээд бүтэн дасаагүй байгаад байна л даа. Яагаад гэхлээр 76-тай хуучин парламентаараа бодоод байгаа зүйлүүд байна. Яг холимог систем гэдэг маань ягвэ гэдэг энэ агуулга дээрээ ч бас ингээд олон нийтэд ч бай манай төрийн албан хаагч нарт ч бас эргэлзээ бас байна.

Тэгэхээрээ бид хамтдаа л одоо энэ тогтолцоо руу орсон шүү дээ. Тийм. ялангуяа би хуучин парламентын гишүүдийг хэлэхэд. Анх л энэ парламентыг бид нар холимог тогтолцоо руу оруулахдаа л хувь тэнцүүлнэ гэдэг маань өөрөө хамтарсан байдлаар явна л гэсэн үг гэдгийг бид нар бүгдээрээ л ярьж байсан. Одоо тэгээд яг ярьж байсан зүйл нь яг биелчихээр дасаж өгөхгүй л байгаад байгаа болохоос биш энэ чинь угаасаа л Герман ч бай, Шинэ Зеланд ч бай яг л ийм байгаа. Тэгэхээр яах вэ шинэ 30 жил гэдэг маань тэр. Одоо би бас үг хэлэхдээ яг 90 оны шинэ өглөө шиг байна гэдэг маань энэ маань өөрөө ингээд дасан зохицохын тулд бас хугацаа орно. Олон нийтэд, төрийн албан хаагчдад, парламентын гишүүдэд, магадгүй манай Их Хурлын Тамгын газрынханд, одоо ингээд багтахдаа больчихсон одоо ингээд Засгийн газар нүүнэ гэж байгаа. Энэ чинь ингээд дандаа байсан Хэрэг эрхлэх газрынхнаас авхуулаад энэ хүлээж авахгүй зүйл. Засгийн газрын ордон гээд нэрлэхсэн

ийм ордноос яахлаараа гүйцэтгэх засаглал гарах ёстой юм гэдгээс авхуулаад л олон зүйл болж байгааг би ингээд мэдэрч байгаа.

Гэхдээ бид ийм шинэ жишиг рүү л хамтдаа явж байгаа юм чинь хамтдаа л дор бүрнээ хичээгээд л энэ асуудлуудаа ингээд хийх нь зүйтэй. Тэгээд Ганхуяг гишүүнтэй санал нэг байна. Бид нар 1-2 жилийг алдаж болохгүй. Яагаад гэвэл бүрэн эрхийн хугацаа гэдэг 3 удаа л төсөв батлах ийм эрх байдаг. Улс орны хувьд 3 жилийн хугацаа гэдэг бол техник, эдийн засгийн үнэлгээ дээр бараг бүтэн ажиллаж чадахгүй л ийм хугацаа болдог.

Гэхдээ бүрэн эрх хэрэгжээд дуусах үед ард түмэн биднээс нэг л зүйл асуудаг. Яг юу шийдэгдэв? Тэгэхээрээ бид нар.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 36.10-ын дагуу хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг дэмжсэн, мөн эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, бүлгийн нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаагаар үг хэлнэ гэж хуульчилсан байгаа.

Тэгэхээр бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирсэн саналын дагуу 6 гишүүн үг хэлэхээр 4 хүртэл минутаар үг хэлэхээр нэрс ирсэн байна.

Үг хэлэхдээ хуулийн зохицуулалтаар үг хэлэх гишүүд индрээс үг хэлэхээр хуульчлагдсан байгаа. Тийм учраас 1 дүгээр индэр тэнд байна. 2 дугаар индэр тэнд байгаа. Нэрсийн дарааллын дагуу үгээ хэлэхийг хүсье. Дарааллын дагуу Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн үг хэлэх нь байна. 1 дүгээр микрофоноос.

**Х.Баасанжаргал:** Хамгийн анхны дэгийн дагуу үг хэлэх боломж олдлоо. Тэгээд хэд хэдэн санал байгаа. Үндсэндээ бол бүхэлдээ дэмжиж байгаа. Энэ удаагийн Засгийн газрын яамдуудыг томъёолсон томъёолол бол маш их анхаарал татаж байгаа. Маш үр дүн рүү чиглэсэн ийм томъёолол байна гэж харж байгаа учраас үндсэндээ бүхэлдээ дэмжиж байгаа.

Гэхдээ бас зайлиггүй хэлэхгүй бол болохгүй хэд хэдэн санал байна. Бас энэ үүнийг бас тусгаад авбал тун сайшаалтай байна гээд.

Нэгдүгээрт, Хуулийн төслийн 3.1.1-ээс эхлээд 3.22 хүртэл бүх яамд бүх сайдуудын чиг үүрэг дээр агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал гэж орсон байгаа. Тэгэхээр үүнийг агаарын бохирдол гэхийн оронд орчны бохирдол гэж өргөн хүрээнд томъёолж оруулаач гэдэг ийм саналтай байна.

Ялангуяа 3.6 дээр Монгол Улсын Засгийн газрын гишүүн буюу Монгол Улсын сайд 20 минутын хот Үндэсний хорооны даргын эрхлэх чиг үүрэг дээр энэ орчны бохирдлын асуудлыг зайлиггүй орчны бохирдол гэж өргөн хүрээгээр томъёолох шаардлагатай. Учир нь гэвэл Монгол Улс нийтдээ 180 орноос 155-д бол орчны бохирдлоороо жагсдаг гэсэн ийм харамсалтай дүр зураг дэлхийн эдийн засгийн форумас 2 жил тутамд хийдэг үнэлгээгээр бол гарсан байна.

Тийм учраас үүнийг орчны бохирдол гэж томъёолох шаардлагатай. Мөн энэ асуудлын хүрээнд бол и үүний нэг онцлог нь бол энэ нь өөрөө ирээдүй хойч үе эрх гэж томъёологддог. Ирээдүй хойч үе эрхийн асуудал гэж томъёологддог. Тийм учраас үүн дээр бид нар анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна гэсэн үг.

Хоёрдугаарт, 11 дүгээр зүйл дээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд иргэдийн оролцоог хангах механизмыг энэ уурхайд оруулж ирэх ийм чиг үүргийг нэмж өгөөч гэсэн ийм саналтай байна. Ер нь бол практик дээр одоогийн байдлаар бол иргэд, аж ахуйн нэгж хоёрыг хооронд нь тулах төр тэнд нь ямар нэгэн оролцоо байхгүйгээр хоорондоо учраа ол гэдэг байдлаар явж ирсэн ийм тогтолцоо байгаа. Тэгэхлээр үүнийг бол зайлиггүй өөрчлөх шаардлагатай байгаа. Тэгэхээр иргэдийн оролцоог хангах энэ механизмыг энэ сайд бол хариуцах энэ механизмыг бий болгох гэдэг ийм чиг үүргийг оруулъя гэсэн.

12 дугаарт, Батлан хамгаалахын сайдын чиг үүрэг дээр батлан хамгаалах цэргийн дэглэлт буюу дүрмийн бус харилцааны асуудал бол маш түүнд хүний эрхийн зөрчлийг үүсгэж байгаа нь бол маш тодорхой байгаа. Харамсалтай нь үүнтэй холбоотой тоо баримт баттай олддоггүй. Бүгд дандаа улсын нууц, эсвэл байгууллагын нууц гэдэгт хамаардаг. Тэгэхлээр энэ Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүний эрхийн зөрчил буюу дүрмийн бус энэ харилцааг үндсэнд нь халах гэдэг ийм чиг үүргийг зайлиггүй оруулж ирээч гэсэн ийм саналтай.

13 дугаарт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд дээр усны нэгдсэн бодлого усны нөөц гэдэг ийм 2 томъёоллоор орсон байгаа. Үүн дээр нарийвчлаад ундны усны асуудлыг зайлиггүй оруулж ирэх хэрэгтэй байна. Учир нь гэвэл хөдөөгийн иргэдийн 56 хувь нь баталгаатай ундны усаар хангагдсан, хотын иргэдийн 94 хувь нь баталгаатай ундны усаар хангагдсан гэж гэдэг судалгаа байдаг. Тэгэхээр үндсэндээ бид нар хөдөө орон нутгийн иргэд, малчдынхаа ундны усны асуудлыг зайлиггүй энэ чиг үүрэг дээр чухалчилж оруулж ирэхгүй бол энэ бол нийгмийн эрүүл мэндийн маш том асуудлыг үүсгэнэ гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

14, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээнд боловсролын байгууллагын засаглалын асуудлыг чухал чиг үүрэгт нь болж оруулж ирэх саналтай. Учир нь гэвэл өнгөрсөн 4 жилд Боловсролын багц хуулийг батлаад маш ахиц дэвшилтэй ийм шинэлэг ийм удирдлагын механизмыг оруулж ирсэн. Тэгэхээр үүнийг бол бид нар цааши бол үргэлжлүүлэх шаардлагатай. Тэр дундаа боловсролын байгууллагын засаглал гэдэг энэ томьёоллоор оруулж ирэх ийм саналтай байнагэсэн үг.

Спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд гээд манай залуучуудын асуудал үндсэндээ соёл, спорт, аялал жуулчлал дээр нэмээд залуучуудын асуудал маань орж ирж байна. Гэхдээ үүн дээр залуучуудын хөгжлийг дэмжих бодлого гэж оруулж ирсэнд.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн 2 дугаар индрээс үг хэлье.

**Б.Батбаатар:** Эхэлж байгаа юу? Хэдэн минут байгаа вэ? Ер нь ингээд эрхээ аваад ажлаа эхэлж байгаа хүнд тэр бүрэн эрх тэр боломж нөөцийг нь өгөөд, дэмжээд, кноп дардаг бол дараад явуулчихсан нь зөв гэж хувьдаа боддог юм. Тийм учраас манай Их Хурлын гишүүд ч бас тэгж бодож байгаа байх. Ажлаа эхэлж байгаа хүнд ямар нэг саад тотгор болж өгвөл болохгүйг хичээх хэрэгтэй. Тодорхой хугацаанд ажил явсны дараа л Их Хурал чинь 3 жил, 2 жил, 4 жил юу хийв гэж асуудаг. Тэрэн дээрээ л очно.

Тэгэхээр миний хүсээд байгаа юм вэ гэхлээр бидэнд мэдээллийн маш их зөрүү байна Засгийн газарт ажиллаж байсан, хуучин парламентад ажиллаж байсан, өмнө нь улс төрд байсан, байгаагүй, одоо орж ирсэн, өнөөдөр энэ Улсын Их Хурал Засгийн газар дээр явж байгаа ямар ажил хаана нь яаж явж

байгаа юм гээд. Энд бол энэ 126 Их Хурлын гишүүд мэдээллийг маш том зөрүүтэй байгаа. Зарим нь сэтгэлээ тэжээгээд бид нар Засагт орчих юм чинь гээд үг дуугарч чадахгүй байх. Юмыг яаж мэдэх вэ Засгаас хасагдчих вий гээд тийм асуудлууд, айдастай байгаа хүмүүс бол асуудал шийдэхэд ихэнхдээ дуугай өнгөрдөг, өөр аргагүй байдаг.

Тэгэхээр тэр мэдээллийн зөрүүг маш сайн арилгаж, мэдээллээр Их Хурлын гишүүдийг сайн хангаж энэ парламент Монголын парламент өөрөө иргэд сонгогчдын төлөөлөл болж байх олонх юм уу, цөөнх гэдэг ойлголт биш. Үндсэндээ 118 гишүүнтэйгээ түрүүн хэн нь ярьчихав? Тийм олонхыг бүрдүүлж Засгийн газрыг дэмжиж, нэг ёсондоо Засгийн газрынхаа бүх бүрэлдэхүүнийг томилж ажиллаж байна л гэсэн үг.

Ерөнхий сайдад бол мэдээж зовлон байгаа. 64-өөс дээш байж байж ирц хүрнэ. Гуравхан хүний, дөрөвхөн хүний илүү гэдэг үндсэндээ ирцээ өргөж, асуудлаа шийдүүлж чадахгүй шүү дээ. 32, 33-ын бүлэг гээд л саяхандаа байлдаж л байсан. Их Хурлын гишүүд нь кноп, саналын эрхээ ашиг сонирхол, засаглалын сайдын суудлаар зараад л наашаа цаашаа хөдөлж байсан түүх өнгөрсөн 20 жилийн түүх шүү дээ. 20 жилийн өмнө намайг Их Хуралд сууж байхад тийм л байсан. Тэрнээс хойш хэр болсон юм. Тийм болохоор институци оронд хандана гэдэг нь зөв байх. Тэгж байж Их Хурлын гишүүдийг кнопоо зардаггүй тийм байдалд оруулах нь зүйтэй.

Тийм учраас миний хэлээд байгаа санал та 118 нийлээд бүлгээ байгуулчхаач гэж хэлээд байгаа юм. Ингээд энэ удаа амжилт хүсье. Та бүхэнд бас ажлын амжилт хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Жудгийн Баярмаа гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэр



дээр очъё. Гишүүдийг индэр дээр очсоны дараа минутыг явуулж эхлүүлээрэй.

**Ж.Баярмаа:** Энэ байж болох уу тээ?

**Д.Амарбаясгалан:** Энэ техникийн шийдлүүд бас байх шиг байна. Баярмаа гишүүн.

**Ж.Баярмаа:** Юуны өмнө бас энэ засагтаа хамтрах урилга хүргүүлсэнд бас талархах хэрэгтэй байх. Засгийн газрын буюу Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын зүгээс Ардчилсан нам болон ХҮН намыг урьсан байгаа, урьсан санаачилгыг гаргасан байгаа гэдгийг бас тодотгож хэлмээр байна. Арга байхгүй 31 хувийн төлөөлөл пропорциональ тогтолцоогоор бол Ардчилсан нам 31 хувийн төлөөлөл авсан, Ардын нам бол 35 хувь. Тэгэхээр энэ пропорцоо бодсон ч гэсэн ингэж урьсан байх гэж бодож байна.

Гэхдээ парламентад болон бусад бүх түвшинд бол гишүүд өөрсдийнхөө үзэл бодлыг уралдуулах ёстой, уралдуулна чиг байх гэж бодож байгаа. Мэдээж Засгийн газарт санал болгох шийдэл бол бас тусдаа гэж бодож байна. Жишээлбэл, Аргентинтай харьцуулах юм бол Хайпер инфляцтай улс байсан. Манайхаас даруй 13 дахин их хүн амтай мөртөө, бид бүгд маш сайн мэдэж байгаа 9 яамтай болж ажиллаж байгаа. Тэгээд эдийн засгийн үзүүлэлт энэ тэр нь бүгд сайжраад явж байгаа юм. Яг энэ хүн амтай нь харьцуулах юм бол манайх бол бараг 6-7 яамтай байх боломжтой юм байна лээ.

Гэхдээ ямар ч байсан нэмээгүйд бас талархаж байна. 16 яамтай 16 хэвээрээ байна. Дээрээс нь хүнд зориулсан яам мэт ийм яамнуудыг бас болиулсан яам эсвэл сайдуудыг ийм чиг үүргийг болиулсанд баярлаж байна. Олимпизмын сайд гэх мэт. Дээрээс нь Соёлын яамыг бас татан буулгаж бусад салбаруудтай нэгтгэсэнд баярлаж байна.

Яагаад гэвэл Соёлын яам ер нь бол бидний гар утсанд байдаг болчихсон шүү дээ. Бараг л яах вэ өв уламжлал гэдэг утгаараа бол өөр, дээрээс нь төрийн бус байгууллагууд хийдэг ажил. Энэ бүхэл бүтэн яам байх ямар ч хэрэггүй байсан юм. Энийг хараад бас баярлалаа. Тэгээд мэдээж өөрт чинь уг нь бол 8 жил засагласан учраас бэрхиээл бага байсан байх ёстой. Гэхдээ мэдээж тодорхой хэмжээнд бэрхиээл тулгардаг учраас энэ засагт бусад бусад яамнуудыг урьсан байх. Тэгэхээр зайлиггүй хийх шаардлагатай зүйлсүүд байна л даа.

Яагаад гэвэл дангаараа засаглаж байхад магадгүй сонгуулиа бодоод энэ хавтгай халамжаас салж чадахгүй байгаа. Яах вэ хавтгайрсан халамжийг бол түрүүн энэ Эрдэнэбат гишүүн ярьж байх шиг байна. Хүүхдийн мөнгөтэй холбож үздэг. Үгүй. Энэ бол 72 төрлийн 551 халамж байдаг бөгөөд хүн амын 76 хувь байна уу орчим нь авдаг бөгөөд жил болгон маш олон дахин нэмэгдэж байдаг халамж авагчдын тоо. Тэгэхээр энэ халамжийн энэ хавтгай системийг бол бид нар гол төлөв сонгуультай холбож үздэг. Ялт ч байхгүй сонгуульд санал авахад чиглэгдсэн ийм бодлого байна гэж үздэг учраас нэгэнт одоо ингээд хамтарч байгаа бол энэ халамжийнхаа хавтгайрсан бодлогоос зоригтойгоор салаарай гэж хүсмээр байна. Харин эсрэгээрээ яг зорилтот бүлэгтээ чиглэсэн тэр үзүүлдэг тусламж дэмжлэгээ зоригтой нэмээрэй гэдэг ийм санал.

Дээрээс нь хөдөлмөрийн зах зээлийн либералчлал. Энийг бас айгаад хийдэггүй байх боломжтой. Тэгэхээр нэгэнт хамтарч байгаа юм чинь энэ реформын шинжтэй сонгуулиас болж айгаад байдаг эдгээр зүйлийг заавал ч үгүй хийгээрэй гэж хүсэж байна. Тэгээд олон юмыг бодож Засагт урьсан. Юмыг яаж мэдэх вэ их муу амламааргүй байна. Гэхдээ хэзээ нэгэн цагт энэ механизм ажиллахаа байгаад таны бодсон санасан

хэрэгжихгүй болоод таны санаачилга гаргаж энэ Засагт урьсан энэ бүтэц механизм ажиллахаа болих юм бол та уг нь би асуух ас асуулт байсан юм. Та бол бас хариуцлага хүлээж нэгэнт өөрөө.../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн 1 дүгээр индрээс үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Бүгдэд нь бас оройн мэнд хүргэе. Тэгээд Ерөнхий сайдын бас оруулж ирж байгаа энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Мэдээж Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхий сайдын онцгой бүрэн эрх байгаа. Хэнтэй ч уулзахгүй өөрөө эдлэх. Тэгээд үүнийг нь бол хүндэтгэж бас шийдвэрээ бид нар гаргаж өгөх ёстой. Тэгэхдээ энэ 2, 3 зүйлийг бас анхаармаар юм болов уу гэж бодож байгаа юм.

Жишээ нь, Хууль зүй, дотоод хэргийн яамыг өөрчилж бас Шударга ёс гэдэг үгийг урьд нь нэмж байгаа юм. Уг нь “жастис” /justice/ гэдэг үг маань шударга ёсноосоо гадна эрх, хууль зүйн тогтолцоо, систем гээд бүгдийг агуулж байгаа үг байдаг. Яг үүгээрээ яваад уг нь хэвшчихсэн. Англи дээр министри оф жастис /ministry of justice/ гэх юм мөж /МОЈ/, министри оф жастис энд хоум эффирс /ministry of justice and home affairs/ гээд л мөж-гаа гээд л явчихдаг.

Тэгэхээр бид хэд энэ товчлолын юу гэдэг ч гэсэн их эвдээд байх шаардлагагүйгээр эсвэл шударга ёс, дотоод хэргийн яам ч гэдэг юм уу аль нэг талдаа гараад ингээд цэгцлээд явчих нь зөв байх. Түүнээс биш жастис /justice/ тэгээд легал энд хоум эффирс /Legal and home affairs/ ч гэдэг юм уу ийм сунжирсан нэрүүд үүсэж болохоор байгаа.

Тийм учраас бас энэ нэршлээ бодоод бас анхны хэлэлцүүлэг дээр бас бодолцоод явчих юм болов уу? Ер нь

цаашидаа бас шүүхийн прокурор байх уу, Засгийн газрын прокурор байх уу, мөрдөх албыг бие дааж байгуулах уу, үгүй юү гэдэг асуудал ч гэсэн үүний цаана бас яригдаж байгаа юм. Тэгэхээр магадгүй энэ Хууль зүй, дотоод хэргийн яам алсдаа 2 хуваагдах юм бол эдгээр тогтолцооны асуудал бас Үндсэн хуулийн хүрээнд бас яригдах ёстой.

Түүрүүн бас Ерөнхий сайд үгэндээ хэлчихсэн учраас би бас талархаж байна. Энэ нь Ардчилсан намд өгөх яамнуудын бас нэршилүүд өөрчилж байгаатай холбоотойгоор бүтцийн өөрчлөлтүүд явах. Төрийн албан хаагчид үндсэндээ битүүхэндээ болгоомжлол, айдастай байна. Ерөнхийдөө ийм нөхцөл байдал руу орох юм биш биз дээ гэдэг. Тэгэхээр Ерөнхий сайд бас энэ дээр ямар нэгэн юу гэдэг юм хууль зөрчсөн шийдвэр гаргуулахгүй гэж хэлж байгаад бас талархаж байна.

Хоёрдугаарт, энэ Засгийн газрын энэ бүтэц бүрэлдэхүүний хуулийг дагаад Улсын Их Хурлын тогтоол орж ирж байгаа. Бид нар энэ тохируулагч хэрэгжүүлэгч агентлаг гэдэг зүйлийг ойлгохгүй ерөнхийдөө хэрэглээд байгаа. Ерөнхий сайд буюу шууд яамны доор очдоггүй агентлагуудыг уг нь тохируулагч гэдэг. Яамтайгаа уялдаж ажилладаг агентлагийг хэрэгжүүлэгч гэдэг.

Тэгэхээр өнөөдөр бас Хууль зүй, дотоод хэргийн сайдын доор тохируулагч, Зам, тээврийн сайдын доор тохируулагч гээд байгаа. Уг нь хэрэгжүүлэгчээр нь тавиад, тохируулагч агентлаг нь хагас бас бодлогын институт байдаг. Өөрөөр хэлэх юм бол, дээрээ яам байхгүй шууд Ерөнхий сайд юм уу, эсвэл Шадар сайдад харьяалагдаад явдаг ийм агентлагууд байдаг. Тэгэхээр энийгээ бас бодолцож бас энийг нэгмөсөн зөв болгооч. Тохируулагч агентлагийн дарга бол үндсэндээ бас дэд сайдын ренктэй бусад орнуудад байдаг. Тэгэхээр энэ рүүгээ явж

байж тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн бас ялгаа гарч байгаа юм.

Дээрээс нь ер нь цаашидаа тохируулагч агентлаг байх ёстой газар Улсын бүртгэлийн ерөнхий газар байгаа. Тийм учраас бас энэ Улсын бүртгэлийн ерөнхий газрыг бас Ерөнхий сайдын дэргэд эсвэл Хэрэг эрхлэх газрын дэргэд авчирч байж энэ төрийн үйлчилгээ орон нутагтайгаа харьцах энэ үйл ажиллагааг бас уялдуулж авч явах нь зүйтэй юм болов уу гэж бодож байгаа.

Хоёрдугаарт бас түрүүн Баасанжаргал гишүүн бас хэлж байгаатай яг адилхан төрийн ил тод байдлын чиг үүргийг бүх сайдуудад нэмж өгөөч гэдэг зүйлийг би бас Ерөнхий сайдаас хүсэж байна. Энэ бол авлигатай тэмцэх, иргэддээ ойртох, олон нийтэд бас мэдээллээ мэдэх эрхийг нь хангах. Бүх асуудал энэ бүх сайдуудын чиг үүрэг байх ёстой. Энийг яг орчны бохирдол, агаарын бохирдол гэж байгаатай ялгаагүй. Яг энэ төрийн ил тод байдлыг хангах гэдэг энэ чиг үүргийг бүх сайдуудад бас оруулж өгөөч гэдэг зүйлийг бас.

Хоёрдугаарт, хамгийн бас нэг хэлж байгаа санал бол энэ Оюуны өмчийн газрыг Тэргүүн шадар сайдад харьяалуулж байгаа. Оюуны өмчийн асуудал үндсэндээ эрхийн бүртгэл шүү дээ. Зохиогчийн эрх буюу сайн дурын бүртгэл патент буюу заавал бүртгэл. Энэ Эдийн засгийн сайдтай ямар ч холбоогүй. Тэгээд энэ асуудлыг уг нь ингэж тарамдуулж бас дахин дахин хөдөлгөх шаардлага байгаа юу, үгүй юү? Энэ уг нь бас цаашидаа уг нь эв хаваа олоод явж байгаа ийм агентлаг байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг бас анхаарч бас одоо бас хуулийн анхны .../минут дуусав./

**Д.Амарбаясгалан:** Баатаржавын Мөнхсоёл гишүүн 2 дугаар индрээс үг хэлье.

**Б.Мөнхсоёл:** Эрхэм гишүүдийн оройн амгаланг дахин айлтгая. Тэгээд

түрүүн би итгэлцлийн тухай асуудал хөндсөн. Энэ нь өөрөө энэ нийгэмд бид нар энэ том ажлыг нугалахад маш зайлиггүй суур, үндэс учраас энэ асуудлыг бас асуусан юм.

Хоёрдугаарт, мэдээж бид нар бүгдээрээ мэдээж байгаа мега төслүүдийг жишээлбэл явуулахад бид нар маш их эсэргүүцэлтэй тулгардаг. Тэгэхээр энэ эдийн засгийн бөгөөд бусад нийгмийн сайн үр дагавартай томоохон төслүүдээ явуулахын тулд энэ намууд бас хамтраад ажиллах нь зүйтэй гэдэг дээр ХҮН намынхаа хурлаар хэлэлцээд ингээд засагт орохыг шийдвэр гаргасан байгаа.

Тэгэхээр бид нар аливаа популист янз бүрийн улс төрийн шинжтэй тэр аливаа саад бэрхшээл асуудлаас хол байж, хамтдаа нэг эх орныхоо төлөө зүтгэх ёстой гэдэг үүднээс энэ хамтын Засгийн газарт бас амжилт хүсмээр байгаа юм.

Хоёрдугаарт нь ХҮН нам бол иргэд ч мэдээж байгаа, энэ гишүүд ч бас мэдээж байгаа байх туршилагатай салбар салбарын экспертүүд арвинтай, өндөр боловсролтой ийм боловсон хүчин ихтэй ийм улс төрийн хүчин. Тэр утгаараа ч гэсэн энэ асуудалд бас хамтарч орсон гэдгийг бас дахин дурдах нь зүйтэй юм болов уу гэж бодлоо. Тэгээд бүгдэд амжилт хүсье.

#### **Д.Амарбаясгалан:**

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн 2 дугаар индрээс үг хэлье.

**Х.Тэмүүжин:** Бүгдэд оройн мэнд хүргэе. Өнөөдрийн хэлэлцүүлэг өмнөх хэлэлцүүлэг дээр Ерөнхий сайдын амнаас хэд хэдэн удаа ийм үг гарлаа. Тэгээд орж ирээд энэ ажлыг хий л дээ гэдэг ийм үг. Улс төрийн соёлын хувьд кабинет Ерөнхий сайд кабинетдаа урьж ажиллуулах бол үнэхээр том итгэл найдвар байна. Хууль зүйн хувьд бол нэг зүйлийг тодорхой хэлэх хэрэгтэй. Улсын



Их Хурлын өмнө, Засгийн газрыг удирдаад ажлаа хариуцдаг ганцхан л хүн байгаа. Энэ бол Ерөнхий сайд өөрөө. Улсын Их Хурал Ерөнхий сайдаас өөр хэнийг нь ч юу гэдэг юм бидний өмнө ажлаа хариуц гэж дуудаж, өөрчилж огт чадахгүй. Ерөнхий сайд өөрийнхөө кабинетыг яаж зохион байгуулах бол Үндсэн хуулиараа олгогдсон эрх нь 3 намын төлөөлөл болгож хамтарсан Засаг байгуулах гэж оролдож байх шиг байна.

Тийм учраас өөрийнхөө эрхийг бусад руу шилжүүлээд та нар ингэ дээ гэхээс илүүтэйгээр би ийм юм хийх гэж байгаа, ийм юм хийх гэж байгаа учраас энэ дээр хамтрах ажлыг энд хариуцуулмаар байгаа гэж яривал илүү байх, зохистой байх гэж бодож байна. Үнэхээр 118 гишүүнээс бүрдсэн Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн Засгийн газрын дэмжлэг бий болох гэж байна. Энэ 118 гэдэг их том тоо. Би энэ том тооны ард Ерөнхий сайдын нэг бодлого явж байгаа байх гэж найдаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр нэр өөрчилж бодлого зурах гэж оролдож байх шиг байна. Үнэхээр *министри оф жайстас /ministry of justice/* гэдэг рүү нь явуулах гэж байгаа. Хууль зүйн сайд Ерөнхий прокурор байдаг энэ хуулийн засаглал бүхий хүний эрхийг хамгаалдаг ардчилсан улсын зарчим руу шилжих тийм том зорилго тавьж байна гэж би итгэж байна. Энэ зорилгодоо хүрэхийн тулд ийм олонхыг Засгийн газрынхаа ард дэмжлэгийн баг болгож бүрдүүлэх гэж байна гэж бодож байна. Үнэхээр 30 жил салхи ороогүй, өөрчлөлт ороогүй, прокурорын байгууллага дээр ийм хэмжээний дэмжлэгтэй байж өөрчлөлт хийнэ гэж зориг гаргаж байгаа бол бахадмаар байна. Зүгээр нэр өөрчлөөд нэг улс төрийн нам руу шидээд байгаагаар нь өнхрүүлнэ гэж бодвол энэ их харамсалтай болно.

Хоёрт нь үнэхээр энэ Хууль зүйн яаман дээр томоохон Германы жишгийг аваад өөрчлөлт хийх гэж байгаа бол

бусад яаман дээр байдаг зохион байгуулалтыг битгий шаардаарай. Өмнө нь тийм алдаанууд маш их гарсан. Нөгөө Хууль зүйн яамнууд чинь суурь нийгмийн харилцаа зохицуулж байгаа эрүү, иргэн, захиргааныхаа хуулиар салбар дотроо хуваагддаг бүтэцтэй байдаг юм шүү. Хэр ямар бодлого байх вэ, энэ бодлогоо яаж хянах вэ гэдэг дээрээ шүүгч, прокуророо татан оролцуулж байгаад ажилладаг юм шүү. Тэгснээс биш бодлогын газар хэрэгжилтийг хангах газар гэх мэтчилэн захиргааны байгууллага шиг байдаггүй яам шүү. Тэрийг нь бас нэг бодолцоорой.

Гуравт нь нэг чухал зүйл сая Соёлын яамыг татан буулгалаа. Анх Соёлын яамыг байгуулж байхад нь хэлж байсан үг. Соёл гэдэг зөвхөн дуулж бүжиглэхийг хэлдэггүй юм. Ардчиллын, хүний эрхийн, хуулийн засаглалын соёлыг энэ Засгийн газар чинь өөрөө үйлдвэрлэж байх ёстой, түгээж байх ёстой. Энэ соёлын элементийг хийдэг газар нь Хууль зүйн яам байдаг шүү. Дээр нь авлигыг тэвчдэггүй соёлыг үйлдвэрлэхийн тулд дахиад Хууль зүйн яам байдаг. Хууль зүйн яамны боловсролын салбарт, соёлын салбарт оролцдог нэг л хөтөлбөр байгаа. Энэ иргэний боловсрол гэдэг агуулга. Яаж илүү эрхээ мэдэрдэг, хамгаалж чаддаг, эрх чөлөөний мэдрэмжтэй иргэдтэй болохгүй вэ гэдэг бол Засгийн газрын бодлого. Энэ бол зүгээр их сургуулиудын, эс үгүй ерөнхий боловсролын сургуулийн бодлого ерөөсөө биш. Тэр дундаа хувийн сургуулиудын бодлого ерөөсөө биш.

Тийм учраас энэ чиглэлийн бодлого чинь гарч ирэхгүй бол энэ улс чинь хүчирхэг болохгүй шүү, ардчилал чинь бэхжихгүй шүү, хуулийн засаглал чинь тогтож, энэ даргын засаглалыг чинь халахгүй шүү. Тэгээд энэ чиглэлээр бас дорвитой хүчтэй бодлого явуулах байх.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

*Байнгын хорооны саналаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн*

*1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*2.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай*

*3.Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай*

*4.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*5.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*6.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*7.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*8.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*9.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохион байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

*10.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*11.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*12.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*13.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*14.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай*

*15.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*16.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*17.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай*

*18.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*19.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

*20.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураана.*

*Гишүүд танхимд цугласан байна. Санал хураалтыг эхлүүлье.*

*Олон гишүүдийн төхөөрөмж гацсан. Төхөөрөмж гацаад татгалзсан саналд орсон гишүүд Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргад бүртгүүлээд протоколд засуулах нь зүйтэй. Ингээд олонхын саналаар дэмжигдсэн байна.*

*Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд илжжүүлж байна.*

*Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж эхэлье. Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдах*

хооронд бид бас дараачийнхаа асуудлыг хэлэлцээд явж байх нь зүйтэй байх гэсэн байдалтай байна. Ингээд хэлэлцэх асуудлын дарааллаар Ёс зүй, дэгийн хорооноос, 12-т билүү?

20.34 цаг

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай асуудал анхдугаар чуулганаар хэлэлцэх ёстой.**

Өнөөдөр Ёс зүй, дэгийн байнгын хороо хуралдсан байгаа.

Тэгэхээр төслийн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт Ёс зүй, дэгийн байнгын хороо хуралдааны дэгийг шинэчлэн батлах эсэх асуудлыг анхдугаар чуулганы хугацаанд хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна. Хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох асуудлаар Ерөнхий нарийн бичгийн дарга саналаа гаргаж, Ёс зүй, дэгийн байнгын хороонд хүргүүлж болно гэж заасны дагуу Ёс зүй, дэгийн байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн батлах эсэх асуудлаар 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан дэгээр бүлэг байгуулах тоо 10 байгаа нь цөөнхийн эрх

ашигийг хөндөж байгааг, мөн түүнчлэн дэг цөөнхийн үг хэлэх эрхийг хязгаарлаж байгааг анхаарах зэрэг асуудлаар үг хэлсэн. Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа бөгөөд Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэсэн саналыг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгөхийг хүсьеэ байна. Нэрсээ өгье.

Баттөмөрийн Энхбаяр, Хассуурийн Ганхуяг гишүүн хоёр. Хассуурийн Ганхуяг гишүүнээр тасаллаа.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

**Б.Энхбаяр:** 126-тай парламентын хувьд дэг буюу тоглоомын дүрэм анхнаасаа их тодорхой ойлгомжтой байхаас гадна энэ дэг өөрөө энэ парламентын олонхоор хүлээн зөвшөөрөгдсөн байж байж легитим байдлаа хадгална. Сая бол төлөөлөөд бүлгүүдээс 4, 4 гишүүн индэр дээр гарч үг хэлнэ гэдэг тооны хязгаар болон минутын хязгаар Улсын Их Хурлын даргын зөвлөлөөс батлагдсан журмаар зохицуулагдсан байна.

Өөрөөр хэлбэл, 126 гишүүний олонхоор хууль болж батлагдаагүй, 10 даргын олонх буюу 6 хүнээр, олонхоор батлагдсан ийм журмаар, хуулиар биш журмаар ард түмний төлөөллийн мандатын эрхийг хязгаарлаж болохгүй. Энэ бол өөрөө л хүлээн зөвшөөрөгдөхгүй. Тэгж ярих юм бол Улсын Их Хурлын гишүүн журамд захирагдахгүй, хуульд захирагдана. Улсын Их Хурлын даргын зөвлөлийн баталсан, 6 даргын баталсан журамд 90 хэд нь захирагдана гэдэг ийм тоглоомын дүрэм байж болохгүй.

Тийм учраас дэгд Улсын Их Хурлын чуулганы танхимд бүлэг бүлгээс тэр 4 гишүүн үг хэлэх, тэр нь ямар хугацаатай байх нь дэгийн хуульдаа өөрчлөлт орж парламентын олонхоороо батлагдаж байж энэ цаашаа парламентын бусад легитим байдал хадгалагдана гэсэн ийм саналтай байна.

**Д.Амарбаясгалан:** Хассуурийн Ганхуяг гишүүн.

**Х.Ганхуяг:** Асуулт байна л даа. Энэ хүлээн зөвшөөрсөнд тооцохгүй бол яах юм хуучин дэгээрээ явах юм уу, эсвэл яаж явах юм? Асуулт.

Хоёрдугаарт, энэ дэгтэй холбоотойгоор жосоохон өөрчлөлт хийхгүй бол бид нар энэ 126 гишүүнтэй болгоод, нийгмийн төлөөллийг нь оруулж ирээд тэгээд тэрийг нь хэн үг хэлэхийг нь ингээд хэн нэгэн зааварладаг болоод байвал энэ чинь ерөөсөө мэтгэлцээний

зарчим гэдэг юм чинь алдагдана шүү дээ. Одоо яах юм даргад таалагддаггүй хүн байвал тэр нь үгээ хэлэхгүй тэгээд яах юм? Ингээд байвал энэ чинь яаж мэтгэлцээний зарчим гэдэг юм байх юм бэ л гэдэг асуулт асуух гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Манай Хассуурийн Ганхуяг гишүүн өөрөө 76 гишүүний нэг байж байж энэ дэгийг баталсан. Өнөөдөр дэг дөнгөж хэрэгжиж анхныхаа үүргийг гүйцэтгэж эхэлж байхад 1 удаа үг хэлээгүйн төлөө энэ парламентын тогтолцоонд хийсэн том өөрчлөлтийг үгүйсгэх байдлаар үг хэлэх нь зохимжгүй юм гэж ингэж үзэж байгаа.

Түүрүүн Энхбаяр гишүүн бас хэллээ 4 гишүүн гэж ярьж байна. Та бүхэн яах вэ мэдээлэл дутуу байгаа байх гэж бодож байна. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 9.2 дахь заалтын дагуу тухайн хууль тогтоомжийг хэлэлцэхдээ ямар хугацаанд хэлэлцэх асуудлыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр шийдвэрлэхээр заагдсан байгаа. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл өнөөдөр хуралдаж журам баталсан. Журам батлахдаа 7 төрлийн хугацаатайгаар хууль тогтоомжийг хэлэлцэхээр заасан байгаа.

Нэгдүгээрт, хамгийн урт буюу гишүүдийн асуулт асуух хугацааг 240 минутаар байна. Хариулт өгөх хугацааг 160 минутаар буюу тухайн хуулийг 400 минутаар хэлэлцүүлэх хугацаа байна. Ингээд 50, 50 минутын өөрчлөлтөөр яваад хамгийн богино хугацаа буюу гишүүд 60 минут асуулт асууж, хариултыг 40 минутад өгөх буюу 100 минутаар өнөөдрийн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулийг хэлэлцье гэдэг шийдвэрийг гаргасан байгаа юм. Тэгэхээр хуулиас нь, хуулийн том багаас хамаараад хууль тогтоомжийн том багаас нь хамаараад энэ хэлэлцэх хугацааг даргын дэргэдэх зөвлөл дээр хэлэлцэж шийдвэрлэнэ.



Дэгийн тухай хуулиар Улсын Их Хуралд бүлэгтэй улс төрийн намууд бүлэг дээрээ тухайн асуудлаар хэлэлцээд, тухайн бүлгийг төлөөлж үг хэлэх хүмүүсийн нэрсийг гаргана. Хугацаанаас хамаарч Ардын намын бүлэг гишүүдийн тоо 22-оос 5, Ардчилсан намын гишүүдийн тоо, энэ чинь хэдээс алдсан байна? 27-гоос 2 гэсэн ийм тоогоор гишүүд бол интервалд орж, төлөөлж үг хэлж, асуулт асуухаар байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье.

Мэдээж даргын дэргэдэх зөвлөл дээр гишүүдийн саналыг харгалзан үзэж дэгт өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ярилцсан. Тэгээд дөнгөж эхэлж байгаа Анхдугаар чуулган дээрээ дэгийн асуудлыг хөндөхөөсөө илүүтэйгээр энэ дэгийг тодорхой хугацаанд туршиж үзэх нь зүйтэй. Асуудал юундаа байна вэ гэдгийг тодорхой болгосны үндсэн дээр ажлын хэсэг байгуулаад өөрчлөлт оруулах бүүр бүх боломж байгаа гэдгийг бас бид ярилцсан гэдгийг та бүхэндээ хэлье.

Асуулт, өөрөө санал хэлэх шиг болсон шүү дээ тээ? Алив Байнгын хорооны дарга хариул даа. Өөрийнхөө баталсан дэгийг мэдэхгүйгээр энэ чуулган дээр орж ирж асуулт асууж байгаа бас их сонин байна. Ажилдаа хариуцлагатай хандана шүү. Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл гэж асуусан Энхбаяр аа. Баярбаатар хариул.

**Б.Баярбаатар:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл өнөөдөр өнгөрсөн парламентын баталсан дэгийн хүрээнд л намын бүлгүүд болон бүлэггүй Улсын Их Хурлын гишүүдийн минут, санал хэлэх хүний тоог л хуваарилж л баталсан юм л даа. Тэрнээс тэр өнгөрсөн парламентын баталсан дэгээс давчихсан, тэр хуулийг давчихсан тийм журам батлаад байгаа зүйл энд байхгүй.

Өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бас ярьсан л даа.

Энэ өнгөрсөн парламент баталсан өнөөдрийн бидний мөрдөж байгаа энэ дэг олон улсын судалгаанд суурилоод ингээд ингээд явсан гээд. Ямар ч байсан нэг хэсэг хугацаандаа энэ дэгээрээ яваад үзье, боломжийг нь харъя. Тэгээд өнөөдөр ингээд энийг шууд бүрмөсөн хаачхаж байгаа юм биш л дээ. Сая дүгнэлтийн төгсгөл дээр хэлсэн Улсын Их Хурлын гишүүд саналаа гаргаад энэ дэгт өөрчлөлт оруулах, дахиад шинэчлэн батлах ч эрх нь байж байгаа. Тэгэхээр энэ ямар нэгэн хууль, дүрэм зөрчөөд өнөөдөр буруу, зөрүү ойлголцоод байгаа юм бол байхгүй байх гэж харж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Тодруулна  
Б.Энхбаяр.

**Б.Энхбаяр:** Миний асуултын агуулга нь ийм байгаад байгаа юм. Дэгийг хуулиар л тогтоох ёстой. Энэ бол Үндсэн хуульд байгаа. Улсын Их Хурал дэгээ өөрөө тогтооно. Тэгэхдээ хуулиар гэж байгаа шүү, журмаар гэж байхгүй. Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс баталсан журмаар гэж Үндсэн хуульд байхгүй шүү. Бид эхний өдрөөсөө Үндсэн хуульдаа нийцүүлж парламент ажиллах ёстой. Тийм учраас би энийг нь асуугаад байгаа байхгүй юу. Бид нар одоо даргын дэргэдэх зөвлөлөөс баталсан журмаар парламентынхаа хууль тогтоох процессоо эхлүүлэх гээд байна шүү дээ. Би энэ асуудлаа Дэгийн хуулиараа бид зохицуулж байж цаашаа явъя гэж хэлээд байна шүү дээ. Энэ дээрээ л хариулт авмаар байна.

**Д.Амарбаясгалан:** Баярбаатар дарга тэр Дэгийн тухай хуулийн 21.22, 21.23-ыг уншаад өгчих.

**Б.Баярбаатар:** Их Хурлын дарга түрүүн тодорхой хариулчихсан даа. Тэр дэгт чинь Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл л тогтооно гээд хуульчилчихсан байгаа шүү дээ. Тэгээд тэр зөвлөл нь тэгээд л өнөөдөр тогтоолоо. Дараа дараадаа ч тогтоох л байлгүй.

**Д.Амарбаясгалан:** Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэ яв техникийн алдаа гарав уу? Энэ гишүүд маань буруу ойлгоод байх шиг байна. Одоо өөрчилье гэнгүүтээ шүүд өөрчилчих гээд байгаа зүйл энд юу байхгүй шүү дээ. Өнөөдөр энэ асуудлыг ярилцана. Дэгт өөрчлөлт оруулах асуудал чинь угаасаа ажлын хэсэг байгуулагдана, намрын чуулган руу орно. Өнөөдөр дараад өөрчилчихнө гэж бүгд бодож байгаа тийм зүйл байхгүй.

Энд одоо, тэгье гишүүд тэгвэл горимын санал гаргачих. Гаргачих гаргачих. Улсын Их Хурлын гишүүн Аубакир горимын санал гаргаж байна.

**Т.Аубакир:** Би сая дэмжиж санал өгсөн боловч энэ төхөөрөмж ажилласангүй. Саяын хураасан саналыг хүчингүй болгоод, дахиад санал хурааж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Аубакирын гаргасан горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгуулахаар санал хураалт явуулъя. Яах юм гишүүд? Тэгээд эс үгүй бол энэ дүнгээр нь явах юм уу? Энэ ажлын хэсэг байгуулагдаад л үлдэхээс өөр ямар ч үүрэггүй зүйл шүү дээ. Дэгийн хуульд өөрчлөлт оруулах асуудал хэзээ оруулах бүх эрх, боломж нь нээлттэй байж байгаа асуудал. Тийм тийм, айн? Тийм, тэгвэл сая гаргасан горимын санал үндсэндээ дэмжигдсэнгүй гэж үзээд, тэгвэл та горимын санал гаргачих. Чойжилсүрэн сайд, Улсын Их Хурлын гишүүн Чойжилсүрэн горимын санал гаргачихъя.

**Б.Чойжилсүрэн:** Амарбаясгалан даргаа энэ сая хүчингүй болгох саналыг нь хураалт хийсэн шүү дээ. Тэгэхэд чинь ямар ч дуу гараагүй байхгүй юу. Гишүүд буруу ойлгоцсон. Хүчингүй болгож, дахиж санал хураалгаж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Тэгье. Энэ олон гишүүд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралд орчихсон байгаа учраас энд бас эсрэг санал гараад байх шиг байна. Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дуусаад орж ирэхээр санал хураалтаа хийгээд үргэлжлүүлье. Тэгээд түр завсарлалаа.

20.52 цаг

Лхагва гараг, 10 Долоодугаар сар  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
01 цаг 33 минут.

**Д.Амарбаясгалан:** Шөнийн мэнд хүргэе гишүүдэд.

Манай хэлэлцэх асуудал үргэлжилж байгаа. Ёс зүй, дэгийн байнгын хорооноос оруулж ирсэн тогтоол дээр санал хураалт явж байгаад горимын санал гараад зогссон байгаа. Тэгэхээр горимын саналаа хураагаад үргэлжлүүлээд явъя гэж ингэж бодож байна.

Горимын санал сүүлд Чойжилсүрэн гишүүн санал гаргасан тийм ээ? Тийм Аубакир гишүүний гаргасан горимын санал техник гацсан учраас дээрээс нь Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа гээд гишүүд цөөхөн байсан, эсрэг санал гарсан. Тэгэхээр горимын санал гаргаж дахиж санал хураалт явуулж хүчингүй болгоё гэсэн байгаа.

Тэгэхээр Чойжилсүрэн гишүүний гаргасан саналын дагуу хураасан Аубакир гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн горимын саналыг хураая. Дэмжье гэсэн томъёоллоор.

Эхлээд туршилтын 1 санал хураалт явуулагдахъя. Дэмжье гэсэн томъёоллоор.

Одоо Чойжилсүрэн гишүүний гаргасан горимын саналаар дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

54.9 хувиар дэмжигдсэн байна.

Тэгэхээр Ёс зүй, дэгийн байнгын хорооноос оруулж ирсэн тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор дахин санал хураалт явуулахаар болж байна. Тийм ээ зөв үү?

Ёс зүй, дэгийн байнгын хорооноос оруулж ирсэн тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

55.8 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны оруулж ирсэн санал, дүгнэлттэй холбоотой санал хураалт явагдлаа.

Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Улсын Их Хурлын тогтоол “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.10 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2, 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2024 оны Улсын Их Хурлын чуулганы Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын

хуралдааны дэг гэж хүлээн зөвшөөрсөнд тооцсугай.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1-д заасны дагуу шийдвэрлэсүгэй.

Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн. Хугацаа болно тээ 10-ны? 7 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолыг танилцууллаа.

Эцсийн найруулга дээр саналтай Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хэлэлцэх асуудал дараачийн асуудалд оръё.

01.38 цаг

Лхагва гараг, 10 Долоодугаар сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
03 цаг 53 минут.

**Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн анхны хэлэлцүүлэг.**

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,



Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний талаар Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын Ерөнхий сайд 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2024 оны 7 сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Баасанжаргал, Баярбаатар, Болормаа, Доржханд, Зулхар, Лувсанжамц, Номинчимэг, Пүрэвдорж, Сандаг-Очир, Сайнзориг, Саранчулуун, Ундрэм, Хэрлэн, Дамдины Цогтбаатар, Энхтүвшин, Энхцэцэг, Эрдэнэбат нар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр шинэчлэн тогтоож буй Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний зарим нэрийг, мөн Засгийн газрын зарим гишүүдийн эрхлэх асуудлын хүрэн дэх чиг үүргийг өөрчлөх болон Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэр, томъёо жигдлэх, мөн түүнчлэн хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчдад буцаах зэрэг зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн

байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийн гишүүд түрүүнийхтэй адилхан байгаа.

9-ний өдөр дууссан тул 10-ны өдөрт өдөрт үргэлжлүүлэн хуралдъя.

Гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуухаар байгаа. Нэрсийг гаргая.

Танай бүлгээс ирүүлсэн саналын дагуу л асуулт асуух нэрсийг өгч байгаа шүү дээ? Бид нар дэгийн, журмынхаа дагуу Дэгийн хуулийн дагуу, журмынхаа дагуу тэгж явж байгаа.

3 гишүүний нэрсийг ирүүлсэн байна. Цогтгэрэл гишүүн, С.Ганбаатар гишүүн, О.Амгаланбаатар гишүүн гэсэн 3 хүн байна. Асуулт асуух нэрс.

Амгаланбаатар гишүүний микрофоныг өгье.

Ажлын хэсгийн гишүүд бол байгаа шүү дээ. Бямбажавын Ганбат Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Дондогдоржийн Амгаланбаатар Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Зохихсүрэн Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Дондогмаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Дөлгөөнтуул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын референт гээд ажлын хэсгийн гишүүд байна.

Одоо Засгийн газрын шинэ бүрэлдэхүүнийг батлах гэж байгаа шүү дээ. Тэгэхээр бүрэлдэхүүний тухай хуулийн төсөл шүү дээ. Засгийн газрын бүтэц, Засгийн газрын бүрэлдэхүүний

тухай. Тэгвэл Амгаланбаатар гишүүний Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбоотой асууна шүү дээ. Тэгэхээр Байнгын хорооны дарга хариулна шүү дээ. Эхний хэлэлцүүлэг дээр бол Ерөнхий сайд хуулийн төслөө танилцуулаад, асуултад хариулсан. Одоо бол Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбоотой Байнгын хорооны дарга асуултад хариулаад явна.

Амгаланбаатар гишүүний микрофоныг өгье.

**О.Амгаланбаатар:** Одоо тэгээд хариулах хүн нь байхгүй юм чинь юу хариулах вэ дээ. Түрүүний Ганхуяг гишүүний тэр санал их зөв зүйтэй санал шүү дээ. Эхлээд гэрээгээ хийгээд, зарчмаа тохироод, бүх юмаа жин тан болгочоод дараа нь энэ хүнийхээ асуудлыг, Засгийн газрынхаа бүтцийн асуудлыг ярьсан нь зөв гэж ингэж санал хэлж байна лээ. Уг нь энэ бол уг нь зөв юм байгаа юм шүү дээ. Хүний асуудлаа ярьчихаад, дараа нь зарчмаа ярьдаг ийм юм гэж байх вэ дээ. Тэгэхээр энэ дээр бас хариулт авах байсан юм.

Дараагийнх нь асуудал гэх дээр түрүүн бас ингээд бүтцийн асуудал ороод ирэхэд ялангуяа энэ олонхын зүгээс Монгол Ардын намын дарга нь, Ерөнхий сайд нь бүтцээ оруулаад ирж байхад маш олон энэ олонхын гишүүд босоод санал хэлээд энэ бүтцийнхээ асуудал дээр саналууд хэлж байна лээ. Дахиад энэ Байнгын хороон дээрээ ч гэсэн бараг л бүгдээрээ санал хэлээд ороод ирсэн байх юм. Тэгээд яах вэ та хэдэд нөхөрсгөөр зөвлөх нь гэх юм уу хэлэхэд сумын иргэдийн хурал хүртэл ийм байдаггүй шүү дээ. Эхлээд нам нь шийдвэрээ гаргаад, дараа нь бүлэг нь шийдвэрээ гаргаад ингээд шахсан бяслаг шиг юм орж ирээд жин тан явдаг юм шүү дээ. Харин тэр олонхынх нь гишүүд хэлбэл Ерөнхий сайдаа гэдэг юм уу, тэр сумын даргаа ч байдаг юм уу, аймгийн даргаа дэмжиж үг хэлээд л ингээд явдаг юм шүү дээ. Үгүй ээ жсоохон тийм юутай байвал

энэ бас энэ түрүүн Цогтгэрэл үг хэлсэн чинь Ерөнхий сайд хэлж байна лээ. Энэ чинь институц хоорондын асуудал та хувийнхаа байр суурийг илэрхийлж болохгүй гэсэн утгатай юм ярьж байна лээ. Тэгэхээр ийм зүйлээ бас энэ та хэд маань бас энэ олонх болоод энэ Монголын төрийг энэ олон жил барьсан ийм улс төрийн хүчин гэж өөрсдийгөө ярьдаг бол жоохон зарчимтай, юмаа бас жоохон ойлгож явбал бас зүгээр юм уу гэж нөхөрсгөөр та хэдэд бас зөвлөе гэдгийг хэлье.

Тэгээд Ерөнхий сайдаас би ийм асуулт асуух гэж байсан юм. Ер нь том ажил дээр гэхээсээ илүүтэй энэ 30 жилийнхээ алдаа оноог засах гэж хамтарч байна гэж ингэж найдаж харж байна. 30 жилийн хугацаанд бид нарын хувьд маш олон зүйлийг зөвхөн сонгуулиас сонгуулийн хооронд зориулж шийдвэр гаргаж, эсвэл зөвхөн хүнд зориулсан шийдвэрээс болоод өнөөдөр Монголын энэ 30 жилийн алдаа гарчихсан юм.

Тийм учраас энэ Ардчилсан намыг болон ХҮН намыг энэ засагт урьдаг нь 30 жилийнхээ энэ алдааг засъя, 30 жилийнхээ болохгүй байгаа зүйлийг буюу өнөөдрийн энэ Ерөнхий сайд нэг үг хэлж байсан юм “их өвдөлт мэдрэх болно” гэж хэлж байсан. Тэгвэл тэр өвдөлтийг одоо л мэдрүүлэх ёстой юм шиг байна. Бид нар ядахад 10, 20, 30 жилээ харж байж шийдвэр гаргахгүй бол сонгуулиас сонгуульд ялахын тулд юм уу, эсвэл яг түрүүний тэр хүндээ зориулсан асуудлуудыг яваад байх юм бол энэ Монгол Улсын хөгжил чинь улам хойшоо орж, доошоо ширгээд дууслаа.

Тийм учраас би Ерөнхий сайдаас асуух асуулт бол та энэ өвдөлт мэдрэсэн тийм шийдвэрүүдийг хамтдаа цуг гаргаж чадах уу гэж л асуух гэсэн юм. Тэгээд харамсалтай нь ингээд орж ирсэнгүй.

**Х.Булгантуяа:** Байнгын хорооны дарга хариулах уу өмнөөс нь? Одоо бол

Байнгын хорооны дарга хариулаад л явна л даа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбоотой асуулт асууж байгаа шүү дээ бид нар. Сандаг-Очир гишүүн байгаа шүү дээ. Хуралдаан даргалагч. Цогтгэрэл даргын микрофоныг өгье.

**О.Цогтгэрэл:** Харин хурал даргалагч энэ чинь харин жинхэнээсээ гурилдсан юм болоод байна уу, үгүй юү? Бүүр хурлын дарга ч, хариулагч ч байхгүй, Байнгын хорооны дарга ч байхгүй. Та тэгээд хурлыг ингээд удирдаад байдаг. Би зүгээр асуулт, ажил хэргийн асуулт байгаад Ерөнхий сайдыг орж ирэхээр хариулуулж өгөхийг хүсье.

Энэ нь ингээд салбарын яамд гээд, салбарын яамдын бодлого гэдэг зүйл нэгдүгээрт нь яригдаад байгаа юм. Салбарын яамд бол үндсэндээ энд танхимын Ерөнхий сайдын эрх, үүргийн хүрээнд Ерөнхий сайдын өмнө ажлаа тайлагнадаг сайд нарын хувьд салбарын бодлого гэдэг зүйл ягүндээ байна уу, байхгүй юү? Байна гээд бодъё. Яг өнөөдөр яамнуудаар болж байна вэ гэвэл яамд бодлого гаргах юм байна, яамд энийгээ хэрэгжүүлэх юм байна. Одоо Мэргэжлийн хяналт татан буугдчихсан яамд хяналтаа хийж байгаа, хяналтаа хийж байгаа. Мэргэжлийн хяналт байхгүй.

Тэгэхээр энд чинь нөгөө засаглалын хямрал чинь яамнууд дээр яг энэ бүтцийн чинь дагуу гарчхаад байгаа юм биш. Бодлого гаргана, өөрөө гаргана, өөрөө хэрэгжүүлнэ, өөрөө хянана. Өөрөө өөрийгөө хянана. Энэ чинь яг л наад захын засаглалын хямрал шүү дээ. Энийг яаж засах юм? Одоо мэргэжлийн хяналтыг хяналт шалгалт буурч байгаа нь сайн.

Гэтэл бизнесийн байгууллагуудаар одоо 1 сард 5 яамнаас 5 шалгалт очдог болчихсон. Эргээд нөгөө хяналт, шалгалт буурах биш 5 яамнаас хуучин бол Мэргэжлийн хяналт шалгалт

төлөвлөгөөт нэг шалгалт очдог байж, нөгөө бизнесүүд чинь эсрэгээрээ болчихсон одоо. Эсрэгээрээ. Тэгээд бодлогоо гаргадаг I байгууллага өөрийгөө хэрэгжүүлдэг, тэгээд өөрийгөө хянадаг. Энэ чинь зүгээр л бүтэц дээр энийгээ яаж харсан юм бэ энэ зохион байгуулалт дээр? Энэ хямралт асуудлыг яаж харж байгаа юм бэ? Энэ чинь яг энэ чигээрээ явбал үнэхээр тийм бодлогын алдаатай байдал руу орчихсон байгаа шүү гэдгийг л би энэ дээрээс ямар ишийдэл, гарц, тулгамдсан асуудал юу мэдэгдсэн юм? Үүнийг л тодруулж асуух гэсэн юм л даа. Тэгээд энийг өөр хэн нэгнээр хариулуулж хэрэггүй.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Ганбат дарга хариулах уу? Үгүй асуулт асуусан юм чинь ажлын хэсгийн гишүүдээс хариулах ёстой шүү дээ. Нэр өгсөн гэж өгсөн гишүүд дотор бол байхгүй байна. Дондогмаа дарга байна уу Хэрэг эрхлэхийн ажлын хэсгийн гишүүдээс? Дондогмаа дарга Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Дондогмаа дарга Цогтгэрэл даргын асуултад хариулъя. 18 тоот микрофон.

**Ч.Дондогмаа:** Гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Мэргэжлийн хяналтын хяналт шалгалтыг бууруулах, илүү оновчтой, тэгээд давхардсан шалгалтыг багасгах зорилгоор Мэргэжлийн хяналтын газрын чиг үүргийг салбарын яамдад хариуцуулсан байгаа. Тэгээд Засгийн газраас тухайн жилийн хяналт шалгалтын төлөвлөгөөг нэгдсэн маягаар баталдаг болсон байгаа Засгийн газрын тогтоолоор. Үүний дагуу яг I аж ахуйн нэгж дээр давхардаж очдог хяналт шалгалтыг бууруулсан байгаа.

**Х.Булгантуяа:** Хяналт шалгалтын ажлыг оновчтой болгох хэрэгтэй байна гээд Цогтгэрэл даргын

санал хэлсэн байна. Тэгээд Дондогмаа дарга жосоохон тогдорхой хариулах хэрэгтэй байгаад байна. Олон яамд дээр очлоо гээд буурахгүй байна гэдэг тийм саналыг хэлээд байна. 18 номерын микрофоныг өгье.

**Ч.Дондогмаа:** Төрийн хяналт шалгалтынхаа хуулиар тухайн жил болгон төлөвлөгөө батлахаар хуульчилсан байгаа. Энэ хуулийнхаа дагуу давхардуулахгүй байдлаар төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж байгаа.

**Х.Булгантуяа:** С.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

**С.Ганбаатар:** Би хоёр зүйл асууя. Ер нь манай Засгийн газар олон жил мега төслүүд хөдлөхгүй байна, гол үр дүн гарахгүй байна л гэж байгаа. Бид бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтын тухай ярьж байгаа шүү дээ. Би хоёр зүйл хэлье.

Нэгдүгээрт, маш олон хөрөнгө оруулалтууд, маш олон мега төслүүд, спекуляц явж байгаа. Манайд бол маш олон луйврууд явдаг. Энэ яагаад явж байна вэ гэвэл техник, эдийн засгийн үндэслэл буюу техникийн асуудлуудаа ил тод болгохгүйгээр дандаа бүлэглэлүүдийн хоорондын зодоон болдог. Тэгээд миний өдөр асуусан асуулт бол яг энэ асуудлаа бүтэц, зохион байгуулалт дээрээ яаж оруулж байгаа вэ гэдгийг л асуусан. Маш энгийн тодорхой ярья гэвэл бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээ тойрч Засгийн газар дээр ярьдаг бүтэц, зохион байгуулалт байна уу. Удаа дараа ярьж байгаа шүү дээ. Энэ парламентад шинжлэх ухааны эрдэмтэн, шинжээчдийн дүгнэлтийг оруулж ирэхээр том том төлөөллүүд орж ирсэн л гэж байнга яриад байгаа. Энэ маань Засгийн газрын бүтэц дотроо хаана байна вэ л гэж би өдөр асуусан. Ганбат дарга энэ дээр надад хариулах боломж байвал хариулаасай. Нэгдүгээр асуулт.



Хоёрдугаар зүйл гэвэл үгүй жишээ нь та нар бодоод үз дээ. Оюутолгой гээд л фантаздаа хөтлөгдөөд л Монгол орон даяараа аз жаргалтай болох гээд байна л гэж яриад байсан. Яг гэрээний зүйл, заалт дээр цөм луйвардуулаад хулхидуулчихсан, бие даасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргаач л гэж 20 жил ориллоо шүү дээ. Дүгнэлт байхгүй зүгээр л фантази. Ийм тэнэглэл өнөөдрийн энэ бүтэц, зохион байгуулалт дотор дахиж гарахгүй гэсэн баталгаа байгаа юу л гэж асууж байгаа юм. Хаана байна вэ?

Хоёр дахь зүйл. Одоо хувийн хэвилийнхэн үргэлж гомддог, маргадаг. Тэгэхлээр энэ маргаан таслах резилушн л гэж яриад байх шиг байгаа юм. Маргаан тасалдаг тэр механизм нь өнөөдөр энэ бүтэц, зохион байгуулалт дотроо байгаа юу? Ийм 2 механизм байхгүй болохлоор бүлэглэлүүдийн талцал зодооны талбар нь энэ Засгийн газрын үйл ажиллагааг дахиад 4 жил, дахиад 8 жил зогсооно шүү дээ. Энэ механизм энэ бүтэц, зохион байгуулалтад орсон уу л гэж асууж байгаа. Маш энгийн, тодорхой зүйл асууж байгаа шүү дээ. Нөөгөө мега төсөл гээд л яриад байдаг би бол маш олон жил яг гэрээний зүйл, заалт, техник эдийн засгийн үндэслэлүүдийг л асуудаг. Сайд нар нь хариулахдаа маш их тийм өргөн ямар ч тийм асуудал руугаа орохгүй хариулдаг. Энэ байдлыг хариулах хүн байгаа бол энэ асуудал орох уу?

Хоёрдугаарт, тэр өнгөрсөн жилийн 21-ээс 25 оны хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай дотор байгаа 5.1.3, 5.1.4, 8.3.15 энэ 4 жилийн энэ Засгийн газрын үндсэн чиглэлд бас дахиж хэрэгжих үү гэж би тодорхой асуулт асууя.

**Х.Булгантуяа:** Засгийн газрын Хэрэг эрхлэхийн Хууль, эрх зүйн газрын дарга Дондогмаа дарга хариулъя. 18 номерын микрофон.

**Ч.Дондогмаа:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Яг энэ хөгжлийн бодлого төлөвлөлттэй нийцсэн асуудлуудаа нэг дор хариуцах үүднээс 2002 оноос эхлээд Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулаад ажиллаж байгаа. Энэ яаман дээр Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцсэн төслүүдийг хэрхэн цааш нь хөгжүүлэх вэ, бусад хууль тогтоомж хэрэгжилттэйгээ хэрхэн уялдуулж авч явах вэ гэдэг бодлого Эдийн засаг, хөгжлийн яамны дээр зангидагдаж байгаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хувьд Ерөнхий сайд Засгийн газрын гишүүд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрөө оруулж, Улсын Их Хуралд оруулж ирж батлуулах ёстой. Энэ хуулийнхаа зохицуулалтын дагуу мөрийн хөтөлбөр батлагдах байх.

**Х.Булгантуяа:** Ганбаатар гишүүн минут нь яачихсан байх даа тээ тодруулах гэхээр? Дэгээрээ тодруулж болно тээ? Ганбаатар гишүүн тодруулах уу? Тэгье.

**С.Ганбаатар:** Маш богинохон асуучихъя. Энэ бүтэц, зохион байгуулалт дотор энэ мега төсөл байна уу? Урагшаа явах гээд байгаа энэ үйлдвэрлэлийн төслүүд, аж үйлдвэрлэлийн төслүүд гацаад маргаан үүсээд байгаа тохиолдолд энэ маргааныг тасалдаг механизм нь энэ бүтэц, зохион байгуулалт дотроо орсон уу? Аливаа асуудал шийдвэр гаргахдаа улс төрчдийн тийм маргаан мэтгэлцээний талбар болохгүйгээр техник эдийн засгийн, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтээ тойрч ярьдаг бүтэц, зохион байгуулалтын механизм орсон уу л гэж 2 юм асууж байгаа юм. Олон улсад байдаг л ердөө зүйл. Энэ байхгүй гэвэл байхгүй, байгаа бол байгаа.

Яагаад гэвэл энийг би өдөр асуусан. Асуултдаа би дутуу хариулт авсан.

**Х.Булгантуяа:** Дондогмаа дарга 18 номерын микрофон. Мааш тодорхой асуулт асууж байна. Тодорхой хариулмаар байна.

**Ч.Дондогмаа:** Ганбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ чиг үүрэг бол Эдийн засаг, хөгжлийн яаман дээр зангидагдана. Энэ маргаантай асуудал гарсан тохиолдолд Засгийн газар кабинетын зарчмаар ажилладаг учраас энэ асуудал Засгийн газар дээрээ шийдвэрлэгдээд явна.

**Х.Булгантуяа:** Ардчилсан намын бүлгээс энэхүү асуулт асуухаар 3 хүний нэрс, үг хэлэхээр 3 хүний нэрс ирүүлсэн байгаа. Ардын намын бүлгээс Цогтбаатар гишүүний нэрийг ирүүлсэн байна. Үг хэлэх гишүүнээр. Тийм ээ Мөнхбаатар дарга? Тэгвэл үг хэлэхээр, асуулт асуух гишүүдийн нэрс ингээд дуусаж байгаа юм байна.

Үг хэлэхээр тэгвэл С.Ганбаатар гишүүнээс эхэлье.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Нийтдээ Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол зарчмын зөрүүтэй 24 санал байна. Намын бүлгүүдээс ирүүлсэн болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх зөвшөөрлийг олгохоор байгаа. Тэгэхээр Ардчилсан намын бүлгээс Ганбаатар гишүүн, Ардын намын бүлгээс Цогтбаатар гишүүн нар үг хэлэхээр нэрийг нь ирүүлсэн байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1-д. Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийн талаарх санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн "4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам" гэснийг "4/Хууль зүй, дотоод хэргийн яам" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг, Дамдины Цогтбаатар гэсэн байна. Санал хураалт.

Баярбаатар дарга горимын санал гаргая гэсэн байна.

**Б.Баярбаатар:** Энэ санал хураалтын техник чинь бүрэн бүтэн ажиллахгүй байна шүү дээ. Тэгээд улайгаад ингээд яачихаар чинь яах юм болж байна. Тэгээд энэ Амарсайхан сайдынх улаан л байна. Энд хэд хэдэн хүнийх л улаан байна шүү дээ. Тэгээд дэмжсэн санал өгөөд байдаг эсрэг ороод байж, энэ чинь дараа нь архив протоколдоо үлдэж байгаа. Санал хураалтыг хүчингүй болгоод дахиж явуулах горимын санал гаргаж байна.

**Х.Булгантуяа:** Их Хурлын тамгын газар энэ шинэ тоног төхөөрөмж бүрэн бүтэн байдал нь болж байгаа юм уу? Аягүй их ийм алдаа гараад байх юм. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэдэг горимын саналаар санал хураалт явуулъя.

52.6 хувиар дэмжигдсэн байна.

Саналын томъёоллын дахиж уншъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн "4/Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам" гэснийг "4/Хууль зүй, дотоод хэргийн яам" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг, Дамдины Цогтбаатар гэсэн байна. Санал хураалт.

53.5 хувиар дэмжигдсэн байна.



2.Төслийн 1 дүгээр зүйлийн “9/Гэр бүл, хүний хөгжлийн яам” гэснийг “9/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Зулхар, Лувсанжамц, Эрдэнэбат, Энхцэцэг, Энхтүвшин, Хэрлэн, Саранчулуун гэсэн байна. Санал хураалт.

Энэ дандаа Байнгын хорооны дэмжсэн саналууд байгаа шүү. Төрийн байгуулалтын байнгын хорооноос.

57 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн “10/Зам, тээврийн хөгжлийн яам” гэснийг “10/Зам, тээврийн яам” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гэсэн байна. Санал хураалт.

56.1 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Бейсен гишүүний төхөөрөмжийг үзээдхээрэй. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайд;” гэснийг “11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд;” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг. Санал хураалт.

52.6 хувиар дэмжигдсэн байна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд;” гэснийг “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Зулхар, Лувсанжамц, Эрдэнэбат, Мөнхцэцэг,

Д.Энхтүвшин, Б.Хэрлэн, О.Саранчулуун гэсэн байна. Санал хураалт.

Номин сайд, Номин сайдын микрофоныг өгье. Энэ бүүр төхөөрөмж нь гацаад микрофон нь ч орохоо байчихлаа.

**Ч.Номин:** Сайн байцаана уу? Оройн мэнд. Энэ төхөөрөмж маань гацаад дэмжсэн гэж санал өгсөн байхад дэмжсэн дээрээ ч гараагүй, татгалзсан дээрээ ч гараагүй байна. Горимын зөрүүтэй санал өгөөд, дахиад санал хураалгая гэж бодож байна.

**Х.Булгантуяа:** Номин гишүүн саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгөөч гэсэн байна. Горимын санал. Эхлээд Номин гишүүний гаргасан саналаар санал хураалтыг эхлээд явуулах ёстой байгаа. Номингийн саналаар эхлээд тийм нэг нэгээрээ санал хураалт явуулна шүү дээ.

Номин гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү гэсэн горимын саналаар санал хураалт.

50.9 хувиар дэмжигдлээ.

Миний саналууд бүгдээрээ эсрэг гараад байгаа энэ тоног төхөөрөмж нь энд байж болохгүй юм байна санал өгч. Тэгэхээр Тамгын газрынхан минийхийг дандаа дэмжсэнээр аваад яваад байгаарай протокол дээр. Үгүй харин тэгж болохгүй гэнэ. Заавал тоног төхөөрөмж дээрээ л санал өгөх ёстой тийм тохируулга хийчихсэн гэнэ. Харин тийм.

Дараагийн санал хураалтаа явуулчихъя. Тамгын газрынхан хэрвээ тэгээд тийм Эрдэнэболд гишүүн тэндээс горимын санал гаргая гэсэн. Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье. Цаанаасаа өгнө шүү. Эрдэнэболд гишүүний микрофон.

**С.Эрдэнэболд:** Баярлалаа. Энэ ийм байгаа юм. Ингээд сая жишээлбэл тэр Номин сайдын юу чинь технологийн хувьд алдаатай болчихлоо гэнгүүт бид нарын өмнөх бүх юм алдаатай болчихож байгаа байхгүй юу. Өмнө нь санал хураасан бүх санал хураалтууд алдаатай. Тэгэхлээр юу гэдэг юм олонхын бүлгийн гаргаж байгаа санал нь давахаараа алдаагүй, давахгүй болохоороо алдаатай гэсэн логик харагдаж байгаа учраас миний горимын санал бол энэ Их Хурлын Тамгын газрынхан энэ тоног төхөөрөмжийнхөө асуудлыг нэг мөр янзалж цэгцэлдэг юм уу болгоод ямар ч гомдолгүйгээр, эхнээс нь, эхнээс нь шүү бүгдийг нь, бүгдийг нь санал хураах саналтай байна. Тэгж байж энэ чинь яг маргаангүй болох байхгүй юу. Маргаангүй болно.

Тэгэхгүй болохоор бид нар Монгол Улсад энэ хууль тогтоох байгууллагад Улсын Их Хурлын гишүүний санал болгон үнэ цэнтэй байх ёстой. Бид нар ард түмнийг төлөөлсөн элч гэж тангараг өргөсөн хүмүүс байхгүй юу. Технологийн алдаатай байдлаас болоод эргэлзээтэй ишийдвэр гаргаж болохгүй. Тийм учраас миний горимын санал бол саяын алдаатай гэж 2 талын үзэж байгаа тооллогын энэ системээр явж байгаа зүйлийг бүгдийг нь эхнээс нь явъя. Тийм нэгээс нь эхлээд явъя. Нэгээс нь эхлээд явъя. Энэ горимын саналыг дэмжиж өгөөч. Тэгвэл дараа нь гомдолгүй байхгүй юу. Яг хэний санал яаж тоологдож байгаагаа бид нар ойлгохгүй байна шүү дээ одоо.

**Х.Булгантуяа:** Гишүүдийн хувьд өөрснөө өөр өөрийнхөө өгч байгаа саналуудыг та бүхэн маань харж байгаа байх. Дэлгэц дээр бүгдээрээ гарч байгаа. Таны урд талын жижиг дэлгэц дээр бас гарч байгаа. Таны саналын томъёолол ингэж гарч байгаа гээд. Зарим хүмүүсийн хувьд өөрснөө дэмжиж санал өгөөд байхад тоног төхөөрөмж нь гацаад бүүр дэмжсэн ч, дэмжээгүй ч байдлаар

гарахгүй, эс үгүй бол бүүр гацаад ажиллахгүй байгаа тийм тохиолдолд миний саналд тооцогдсонгүй. Тийм учраас саяын санал хураалт бол хүчингүйд тооцож өгөөч гэдэг ийм саналын горимын санал гаргасан юм байгаа юм. Тэрнээс биш өмнөх юун дээр бид нар ийм асуудал үүсэхэд санал хураалтыг дахин явуулдаг. Тухайн аль ч намын бүлгийн гишүүн байхад хэрвээ өөрийнх нь саналд тооцогдоогүй, алдаа гарсан байх юм бол санал хураалт дээр тоног төхөөрөмжөөс үүдээд бид нар 21 дүгээр зуунд энэ Тамгын газар тэгэхдээ энэ бэлтгэл ажлуудаа бас сайн хангамаар байна. Одоо санал хураалтыг ямар бүгдээрээ дандаа гараар явуулна гэлтэй нь биш.

Эрдэнэболд гишүүний саналын томъёоллоор тэгвэл горимын саналын санал хураалтыг явуулъя. Номин сайдынхыг түрүүн явуулчихсан. Тэгээд таны араас дахиж явуулна гэсэн үг түрүүний санал хураалтыг. Эхлээд үндсэн саналаа хураачихъя тэгэх үү? Түрүүн хураагдаад дэмжигдчихсэн тийм. Тэгээд Эрдэнэболд гишүүний саяын горимын саналаар тэгвэл санал хураалт гэсэн үг. Үгүй харин тийм. Тэгэхээр энэ олон гишүүдийн саналаа өгөөд, өөрсдийнхөө саналыг хараад, дэлгэц дээр хараад, өөрөө өөрийнхөө саналдаа болж байна гээд ингээд сууж байхад одоо тэр бүгдийг хүчингүй болгоё гэдэг та санал хураалт явуулъя гээд байгаа юм байна шүү дээ. Их Хурлын Тамгын газраас тийм санал хураалт явуулж болох юм уу? Тийм шүү дээ. Номингийнх ч яах вэ сая дэмжигдчихсэн.

Тэгэхээр та төдийгөөс өдий болтол чуулганд суугаад саналаа өгсөн бүх хүмүүсийн саналыг хүчингүй болгоё гэдэг тийм санал хураалт явуулах гээд байна шүү дээ? Тийм, тэгвэл энэ олон хүмүүсийн өдөржингөө хуралдаж өөрөө өөрийнхөө саналыг бүгдээрээ дэлгэц дээрээ хараад сууж байгаа. Үгүй ээ, Эрдэнэболд гишүүн ээ та өөрөө өөрийнхөө өгсөн саналыг өөрийнхөө

дэлгэц дээр яг хараад сууж байгаа шүү дээ. Энэ дээр бүх бүх дэмжсэн, дэмжээгүй гишүүдийн саналууд бүгдээрээ урсаад явж байгаа. Бид нар заримууд нь дэмжигдсэнгүй гээд хүмүүс татгалзсан хүмүүс байна гээд тэр бүгдийг хүчингүй болгоно гэж зүйл байхгүй шүү дээ. Та бусдынхаа саналыг, цагийг бас хүндэтгэх ёстой шүү дээ.

*Сая Номин гишүүний горимын санал дэмжигдсэн. Санал хураалтыг тэгвэл дахин явуулъя. Тэгье саяын үндсэн санал хураалтыг явуулъя.*

*Ариунзаяа гишүүн горимын санал гаргая гэж байна.*

**А.Ариунзаяа:** Гишүүд ээ горимын санал гаргая. Энэ төхөөрөмж ердөөсөө бэлэн байдал хангагдахгүй байна. Цаг орой болсон байна. Хэдүүлээ бас эртхэн шиг асуудлуудаа дуусгая. Миний горимын санал гар тооллого явуулъя. Тэгээд наадмын дараагаар энэ төхөөрөмжүүдээ сайн засаж, бэлэн байдлаа хангаж байгаад төхөөрөмжөөрөө санал хураая. Одоо бол бүх нийтээрээ бухимдах юм байна. Зүгээр гараараа гараа өргөөд саналаа хураачихъя.

**Х.Булгантуяа:** Тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр санал байна уу гэдэг горимын санал байна уу гэдэг л ийм саналын томъёоллоор санал хураалт явж байгаа шүү дээ гишүүд ээ. Тэгээд нэг нэгээр нь уншаад танилцуулаад явж байгаа. Энэ тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг.

**Д.Амарбаясгалан:** Тэгэхээр төхөөрөмж мэдээж шинэ учраас олон удаа санал хураалт хийхээр хоорондын хугацаатай зохицуулалт хийх шаардлагатай юм бас байх шиг байгаа юм. Ойрхон ойрхон санал хураалт хийхээр гацаад байх шиг байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяагийн гаргасан саналаар, илээр санал хураалт явуулъя гэдгээр гар өргөж.

Тэгэхдээ горимын санал гарчихсан учраас санал хураана шүү дээ заавал. Горимын санал гарчихсан учраас. Харин тийм тэгэхээр горимын санал гарчихсан юм чинь гар өргөөд санал хураагаад явчих нь зүйтэй цагаа хэмнээд. Үгүй тэгээд л энэ төхөөрөмжөөрөө л үзнэ шүү дээ. Өөр аргагүй юм чинь. Үгүй үгүй ингээ төхөөрөмжөөрөө санал хураалтаа явуулаад, дэмжиж санал өгсөн хүмүүс татгалзсанаар гарах юм бол протоколдоо тэмдэглүүлээд явчих нь зүйтэй тэгэх үү?

*Ингэе хуулиараа бас яг энэ асуудал дээр зөвлөх үүрэгтэй Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хуулийн заалтаа тайлбараа хийг. Тэгээд тэрнээс цаашаа явъя хэдүүлээ. Баасандорж даргад.*

**Б.Баасандорж:** Баасандорж, эрхэм гишүүдээсээ юуны өмнө цахим дээр жоохон асуудал үүсэж байгаа Тамгын газрынхаа нэрийн өмнөөс хүлцэл өчье. Тэгээд энэ алдааг бид нар маш хурдан шуурхай засах болно.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.2 дээр ил санал хураалтыг гишүүд цахимаар, эс үгүй бол гар өргөж явуулж болно. Нууц санал хураалтыг цахимаар, эс үгүй бол санал хураах хуудсаар явуулна. Одоо танхимд ил санал хураалт болж байгаа. Цахим системд асуудал үүсэж байгаа учраас одоо үргэлжлүүлээд ил гар өргөөд явуулах нь бүрэн боломжтой Дэгийн хуулийн 10.2-оор. Тийм, Тамгын газраас тоолоход бэлэн байгаа ил санал хураалтыг гар өргөөд.

**Д.Амарбаясгалан:** Тэгэхээр энэ Дэгийн тухай хуулийн 10.2 дахь заалт тийм ээ? Тийм. Эхлээд ямар ч байсан гар өргөж санал хураалт явуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая гараа өргөж. Саналд гараа өргөж оролцоно.

Танхимд байгаа гишүүд 100 хувь дэмжлээ.

Ингээд илээр санал хураалт. Татгалзсан гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд илээр санал. 2 гишүүн байна. Ингээд 2 гишүүн татгалзаж бусад гишүүд дэмжсэн байна. Хувийг 83 гишүүн дэмжсэнээр илээр гар өргөж санал хураалт явахаар боллоо. Ингээд хэлэлцэж байгаа асуудал руугаа орёе. Сүүлийнх чинь энэ 2 тээ?

2.Төслийн 1 дүгээр зүйлийн "16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд;" гэснийг "16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;" гэж өөрчлөх. Санал гаргасан. Гишүүд Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Зулпхар, Лувсанжамц, Энхтүвшин, Хэрлэн, Саранчулуун гэсэн гишүүдийн гаргасан санал байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Татгалзаж байгаа гишүүд гараа өргөө.

2 гишүүн татгалзсан байна. Хаана байна? 3 гишүүн татгалзсан байна 87 гишүүний. Дэмжсэн байна. Тэгэхээр дахиж санал хураалт явчихсан.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн "17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайд" гэснийг "17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд" гэж өөрчлөх. Санал гаргасан гишүүн Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөөрэй.

Баярлалаа татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 100 хувийн саналаар дэмжигдлээ. Танхимд байгаа гишүүдийн 85 гишүүн дэмжсэн байна.

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалтын "Шударга ёс," гэснийг, "Зам тээврийн" гэсний дараах "хөгжлийн" гэснийг тус тус хасах; "Гэр бүл," гэсний дараах "хүний хөгжлийн" гэснийг "хөдөлмөр, нийгмийн хамгааллын" гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Зулпхар, Лувсанжамц, Эрдэнэбат, Энхцэцэг, Энхтүвшин, Хэрлэн, Саранчулуун, Номинчимэг, Цогтбаатар, Пүрэвдорж гэсэн байна.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа татгалзаж байгаа гишүүн байна уу?

1 гишүүн байна. Эрдэнэболд гишүүн татгалзаж байна. Дараачийн асуудал.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд "лабораторийн үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт," гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь



хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлт” гэснийг “чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Д.Цогтбаатар гишүүн татгалзаж байна.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “З/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд” гэсний дараа “/бүсчилсэн хөгжлийн асуудал эрхэлсэн/” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир,

Пүрэвдорж гишүүн асуулт асууя. Пүрэвдорж гишүүний микрофон.

**Б.Пүрэвдорж:** Яг энэ заалт чинь аль Шадар сайдад хамаарч байгаа зүйл юм бэ? Амарсайхан сайд уу айн? Үгүй энэ чинь Эдийн засаг, хөгжлийн сайд гээд Шадар сайдын харьяанд бүүр яам байгаа шүү дээ. Тэгээд энэ хөгжил энэ тэрээ эдийн засаг энэ тэрээ тэндээ ярихгүй тэгээд тэндээс талыг нь аваад явчих юм байна л даа.

Би нэг зүйлийг хэлээд байгаа шүү. Монгол Улсын Үндсэн хуулийн 39.2 дугаар заалт дээр Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтцийг Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулснаар оруулж ирж шийдвэрлэх ийм онцгой эрхтэй. Дээрээс нь сайд нарыг танилцуулж өөрөө томилох онцгой эрхтэй. Энэ 2 онцгой эрх рүү та бүхэн ингээд дураараа дайраад ингээд ороод. Яах вэ зарим нэгэн асуудал дээр бас редакцын болон бусад асуудал дээр юм ярихгүй байгаа. Тэгээд энэ чинь

энэ чинь тэгээд нэг Шадар сайд өгчхөөд тэгээд тэрнийх нь нэг хэсгийг нь ингээд аваад явчхаж болохгүй шүү дээ. Амарсайхан сайд дээр хангалттай олон ажлууд байгаа.

Дээрээс нь сая горимын санал гаргаад бас хэд хэдэн ажил авсан байгаа. Тэгэхээр одоо энэ чинь арай хэтэрч байна. Бид нар чинь энэ хамтарсан Засаг гээд, тэгээд энэ эдийн засаг хөгжлийн асуудлаар бид нар бас тодорхой хэмжээний энэ яамтай болоод энэ тодорхой асуудлуудыг яриад явах ёстой. Тэндээс чинь бүсчилсэн хөгжил гээд салгаад авчих юм уу? Ингэж болохгүй шүү дээ. Ерөнхий сайдын бүрэн эрх рүү өөрөөр хэлбэл тэр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний асуудал руу шууд ингэж халдаж орж болохгүй.

Тийм учраас энэ энэ саналыг та бүхэн битгий дэмжиж өгөөрэй. Энэ чинь бид нар тийм консенсус бий болгоод бас хамтраад ингээд явж байгаа. Тэн дээрээ ингээд хөндлөн гишгээд явчих юм уу? Болохгүй шүү дээ.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулах уу? Хэн хариулах уу Байнгын хороо? Санал хэлсэн юм байна.

Тэгэхээр орж ирсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тоолоорой.

33 хүн дэмжсэн байна. Санал уналаа.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Гэр бүл, хүний хөгжлийн сайдын эрхлэх ажлын хүрээний “хөдөлмөрийн нөхцөл,” гэсний дараа “хөдөлмөрийн аюулгүй байдал,” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулхар. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа, татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 81 гишүүн дэмжсэн байна.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Боловсролын сайдын эрхлэх ажлын хүрээнд “-зэргийн болон мэргэжлийн боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах;” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Зулхар. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Дэмжье гэж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүд байна уу?

Санал хураалтад 81 гишүүн орж, 81 гишүүн дэмжлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээний ‘иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;” гэснийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ишлжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

Энэ дээр Сайнзориг, Эрдэнэболд. Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Та бүгдэд оройн мэнд хүргэе. Тэгээд энэ 7 дугаар саналыг би татаж авч байна. Ерөнхийдөө цаашидаа бас Газрын хуулийнхаа багц хуультайгаа уялдуулж бас энэ эд хөрөнгийн бүртгэлийн асуудлыг нэг мөр шийдье гэдэг байдлаар өнөөдрийн энэ саналыг татаж авч байна. Хойно унасан санал бас дэмжих шаардлагагүй бас тэрийг татаад авчихъя. Түрүүлээд протоколд үлдээчихье. Айн? 7 дахь саналыг татаж авч байна. Мөн Хойд

тал дээр хураалгах “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх унасан саналаа бас татаж авч байна. Ингээд энэ 2 саналыг хураалгах шаардлагагүй гэж бодож байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ингээд 7 дугаар санал, санал гаргасан гишүүн саналаа татаж авч байна.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний “биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого” гэсний өмнөх “нийтийн” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм.

Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Тоолъё. Дэмжиж байгаа гишүүд гараа гараа өргөө.

Татгалзаж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Татгалзаж байгаа гишүүн алга байна. 81 гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ гишүүн татгалзсан байна.

84 гишүүн санал хураалтад оролцож, 83 гишүүн дэмжлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажлын хүрээний “гадаадын хөрөнгө оруулалтын” гэснийг “гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржханд. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.



Баярлалаа, татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 84 гишүүн санал хураалтад оролцож, 2 гишүүн татгалзсан байна.

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайд болон Засгийн газрын гишүүн бүрийн эрхлэх ажлын хүрээнд “-төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал.” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг. Гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа татгалзаж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Алга байна. 84 гишүүн санал хураалтад оролцож, 100 хувь дэмжсэн байна.

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого” гэсний дараа “,төлөвлөлт” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Л.Энх-Амгалан. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Санал хураалтад 85 гишүүн оролцож, 85 гишүүн дэмжлээ.

12.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажлын хүрээний “залуучуудын хөгжлийг дэмжих бодлого” гэснийг

“залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Баасанжаргал гишүүний микрофоныг өгье, үг өгье. Баасанжаргал гишүүний микрофон.

**Х.Баасанжаргал:** Энэ Шадар сайдын эрхлэх ажлын хүрээнд биш 17 Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд гэдэг дээр байгаа. Редакцын санал.

**Д.Амарбаясгалан:** 11-ийг гүйцээн боловсруулах чиглэлийг өгөөд Байнгын хороонд буцааж байна.

4.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “бүсчилсэн хөгжлийн” гэж, мөн зүйлийн 7.6 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 13.1 дэх хэсгийн “Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн” гэснийг “Бүсчилсэн хөгжлийн” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.8 дахь заалтын “бүс нутгийн хөгжлийн” гэснийг “эдийн засаг, хөгжлийн” гэж тус тус өөрчилсүгэй.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Санал дэмжигдсэн.

5.Хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн талаар

1.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаах санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Зуллхар, Лувсанжамц, Эрдэнэбат, Энхцэцэг, Энхтүвшин, Хэрлэн, Саранчулуун.

Энэ найруулгын саналыг яах юм? Ингээд санал хураалтыг дэмжье гэсэн томъёоллоор явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. Санал хураалтад 85 гишүүн оролцож дэмжлээ.

Найруулгын санал.

1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-

Очир. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 85 гишүүн санал хураалтад оролцож, 85 дэмжлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал

1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажлын хүрээний "хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал" гэснийг Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд шилжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин.

Тэмүүжин гишүүнд үг өгье.

**Х.Тэмүүжин:** Төрийн байгуулалтын байнгын хороон дээр 2 дахь удаагаа ярьсан хуулийн Хууль зүй болон дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд манайд хамгийн их тулгамдаж байгаа нэг асуудал бол энэ хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой асуудал байгаа. Бид өнгөрсөн бараг 20 жил шахам байх шударга бус өрсөлдөөн болон хэрэглэгчийн эрх ашгийг хоёуланг нь нэг бүтцэд өгөөд хэрэгжүүлэх гэж оролдсон. Тэгээд сая Засгийн газар дээр шударга бус өрсөлдөөнийг нь монополийн эсрэг гээд тусад нь өөр чиглэл, чиг үүрэгтэй гаргачхаж байгаа юм байна лээ. Одоо бол нөхцөл байдал дээр иргэдэд хамгийн их эрх, эрх чөлөө нь хохирч байгаа гомдол, санал гарч байгаа энэ хэрэглэгчдийн эрх дээр байгаад байгаа юм.

Тэгээд энэ хэрэглэгчийн эрхтэй холбоотой асуудлыг энэ Шадар сайдын хүрээнд байх юм уу, эс үгүй бол нөөцтэй угаасаа энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Хууль зүйн яам руу шилжүүлэх юм уу гэдэг асуудлаар ярьж байгаа. Засгийн газар Германы Засгийн газрын туршилагыг жишиг болгож цааш үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа юм байна лээ. Герман бол хэрэглэгчийн эрх ашигийг хамгаалах Хууль зүйн яам гэж нэг хэсэг яамаа нэрлэж байгаад одоо Хууль зүйн яамных нь хамгийн том чиг үүргийнх нь нэг хэсэг нь энэ хэрэглэгчийн эрх ашиг байгаа юм. Энэ нь бол зүгээр Засгийн газрын бүтэц дээр өөрсдөө яаж шийдэх вэ гэдэг нэг тусдаа асуудал байх. Дахиад энэ дээр санал болгоход Хууль зүйн байнгын хороо энэ хэрэглэгчийн эрх ашигтай холбоотой асуудлыг хянахгүй бол энэ чиглэлийн эрх, эрх чөлөөний зөрчил чинь ерөөсөө парламентын хяналтад байхгүй байгаа шүү.

Тийм, тийм учраас Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудал дээр Улсын Их Хурлын бүтэц ярих үедээ бас дахиад энийгээ авахгүй бол хамгийн их зөрчигддөг мөртөө хангагддаггүй, асуудлыг нь цааш нь боловсруулдаггүй, сайжруулах гэж бодлого гаргаж ирдэггүй тийм хоосон орон зай энэ дээр үүсчхээд байгаа гэдгийг хэлээд ,тэгээд 2, 3 намын тохиролцоо дээр энэ өөрөө ХҮН намын Шадар сайдын хэсэгт орчихсон юм байна лээ. Тийм учраас цаашид энэ дээрээ анхаар гээд би энэ саналаа татаад авчхаж байна.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Тийм тийм 1 зарчим 2 үйлчилж болохгүй учраас бас тийм түрүүчийн Шадар сайдын асуудал дээр яригдаж байсан адилхан. Тэгэхээр энэ санал татагдлаа.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд “иргэний боловсролын албан болон албан бус хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх;”

гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин.

Байнгын хорооны, үг хэлэх гээд байна уу, үгүй юү? Тэмүүжин гишүүн үг хэлье.

**Х.Тэмүүжин:** Энэ уг нь манай шинээр бүрдэж байгаа Засгийн газрын нэн даруй хийх ёстой л ажлуудын нэг яах аргагүй. Монгол Улсын хувьд иргэнийхээ эрх зүйн чадавхыг сайжруулахтай холбоотой энэ чиглэлийн хөтөлбөрүүдийг бид тэр болгон хэрэгжүүлж чадаагүй байгаа. Боловсролын яаман дээр иргэний боловсрол гэдэг агуулгаар ерөнхий боловсролын түвшинд асуудал хөндөж байгаа боловч харамсалтай нь тэнд хууль зүйн боловсрол нь байхгүй. Ихэнхдээ ёс, заншил, шашин гэх мэтчилэн өөр юм.

Ер нь улс орнуудын Хууль зүйн яамны нэг хамгийн чухал зүйл бол иргэдийнхээ Үндсэн хуулийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр бүр тусдаа хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. Энийгээ албан болон албан бус боловсролын системд нэлээн шахаж өгч байдаг. Тэгээд Хууль зүйн яаман дээр энэ чиг үүргийг хэрэгжүүлсэн нь бол нэмж бичих бол зохион байгуулалтын хувьд ч хэрэгжүүлэх арга замын хувьд ч хамгийн зөв байна гэж харагдаад байгаа юм.

Дээр нь ер нь иргэдээ жоохон чадавхтай, мэдлэгтэй байлгаж байж энэ ардчилал, эрх чөлөөтэй холбоотой, хуулийн засаглалтай холбоотой үзэл санаа чинь бодит хөрсөн дээрээ бууна. Тийм учраас та бүгдийг зөвхөн энэ хөтөлбөрийг албан болон албан бус боловсролын тогтолцоо дээр Хууль зүйн яамны зүгээс дэмжиж, Боловсролын яамтай хамтран ажиллах боломжтой болох зорилготойгоор энийг нэмээд өгөөч гэж хүсэж байна. Дэмжээд өгөөч гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье

гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор. Дэмжинэ гэсэн үг. Дэмжээгүйг дэмжинэ. Тэгэхээр дэмжихгүй гэсэн үг. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Татгалзаж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Татгалзсан гишүүд цөөнх байна тоолчхоорой. Ирц биш танхимд байгаа гишүүдээс авч байгаа. Дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт дүнгээ сонсьё.

Байз, энэ тоон дээр будилаан гарсан байна. Дахин санал хураалт гар өргөхгүй бол тоолж болоогүй байна.

Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн. Гишүүд гараа өргөхийг хүсье. Гараа өргөөд тоолоход та бүхэн маань тооллогод оръё. Ундрал гишүүн өндөр өргөө. Өргөөд байж байгаарай.

Татгалзсан гишүүд гараа өргөхийг хүсье. Татгалзсан гишүүд гараа өргөхийг хүсье. Түрүүн бүх санал дээр танхимд байгаа гишүүдийн тоогоор явсан.

85 гишүүн санал хураалтад оролцсон. Эхлээд татгалзаж байгаа гишүүд тоолуулчих. Татгалзсан гишүүдээ тоолчихъё.

Санал унасан байна. Унасан байна. Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал унасан байна.

2. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх санал хураалт гишүүд ээ. Сайнзориг гишүүн энэ саналаа татсан тээ? Сайнзориг гишүүн татсан байгаа.

Түрүүн 1 санал орхигдсон байна. Горимын санал гараад горимын саналаа өгч, алдаатай саналыг хүчингүй болгох горимын саналыг хүчингүй болгохгоод тухайн саналыг санал хураалгүй явчихсан байна. Тийм тэгэхээр.

2. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийн талаарх санал

2. Төслийн 1 дүгээр зүйлийн “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хүний хөгжлийн сайд;” гэснийг “16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;” гэж өөрчлөх. Санал гаргасан, хураагаагүй, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа, Зулхар, Лувсанжамц, Эрдэнэбат, Энхцэцэг, Энхтүвшин, Хэрлэн, Саранчулуун гэсэн гишүүдийн гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хурааа. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. Ингээд санал хураалт дууслаа.

Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ. Түр завсарлалаа. Төрийн байгуулалтын байнгын хороо Жанжин Сүхбаатарын танхимд.

02.52 цаг

Лхагва гараг, 10 Долоодугаар сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
03 цаг 53 минут.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн танай намынхан орж ирэх гэж байна уу?



Хэдүүлээ хэлэлцээж байгаа асуудлаа үргэлжлүүлье. Манай Тамгын газраас Ардчилсан намын бүлэг рүү утасдаад чуулганаа үргэлжлүүлье гээд мэдэгдье. Тэгье тэгье.

**Ингээд Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд эцсийн хэлэлцүүлгийг эхлүүлье.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг баримтлан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний талаар Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Монгол Улсын Ерөнхий сайд 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын

тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулла.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан I зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд зарчмын зөрүүтэй санал болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Номинчимэг гишүүнд. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байгаа юу? Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулъя.

Ингээд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрс намын

бүлгүүдээс ирээгүй байна. Тэгэхээр асуулт асууж, үг хэлэх гишүүн байхгүй.

Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураахаар байгаа. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы танхимд цугларахыг урья. Гишүүдийн ирцийг хүргэхээр санал хураалт эхлүүлэе. Тамгын газраас Улсын Их Хурлын гишүүд рүү зар хүргэе.

Гишүүдийг чуулганы танхимд урьж байна. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

1.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх ажлын хүрээний “залуучуудын хөгжлийг дэмжих бодлого” гэснийг “залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлого” гэж өөрчлөх. Зарчмын зөрүүтэй санал гарсан байна. Тэгэхээр дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Дэмжиж байгаа гишүүн, гар өргөж санал хураалт явагдана. Тоольё.

Зарчмын зөрүүтэй саналыг санал хураалтад оролцсон гишүүд 100 хувийн саналаар дэмжиж байна.

Гишүүдийнхээ тоог гаргая. 59 хүн мөн үү Үнэнбат?

59 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууссан. Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар

Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

Төрийн байгуулалтын байнгын хороо зарлагдаад хуулийн төслүүдийг эцэслэн батлахаар бүх бичиг баримт бэлэн болсон байна. Төсвийн байнгын хороо зарлагдаагүй. Дараагийн асуудалд оръё.

04.08 цаг

**Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д долоо хоногийн Баасан гаргийн 10 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно гэж заасны дагуу Байнгын хороод хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах хувилбарыг бэлтгэж, эцэслэн батлуулахад бэлэн болсон байна. Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Улсын Их Хурлын гишүүд илээр санал, гар өргөж санал хурааж байгаа. Санал хураалт эхэлэе. Санал хураалтаа эхлүүлэе

Засгийн газрын бүтцийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн



саналын томъёо томъёоллоор санал хураалтыг явуулна.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд татгалзаж байна.

Нийт хэдэн гишүүн санал хураалтад 68-аас 66 гишүүн дэмжиж, нийт гишүүдийн олонх боллоо.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд татгалзаж байна. 69 гишүүнээс 68 гишүүн дэмжсэн байна. Дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Санал хураалтад оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдлээ. 71 гишүүн санал хураалтад оролцсон байна.

Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчингүй болсонд

тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжиж байгаа гишүүдээ гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 71 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна.

72 гишүүн санал хураалтад оролцож дэмжигдлээ

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье.

74 гишүүн санал хураалтад оролцож дэмжигдлээ.

Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна.

73 гишүүн санал хураалтад оролцож дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 73 гишүүн санал хураалтад оролцож дэмжигдлээ

Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 75 гишүүн санал хураалтад оролцож санал дэмжигдлээ

Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 76 гишүүн санал хураалтад оролцож санал дэмжигдлээ

“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 76 гишүүн санал хураалтад оролцож, 76-гаар дэмжигдлээ.

12.Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтэц, аан тийм.

04.17 цаг

**Ингээд баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсьё.**

1.Засгийн газрын бүтцийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа байна уу?

Эрдэнэболд гишүүн үү? Эрдэнэболд гишүүн.

**С.Эрдэнэболд:** Баярлалаа. Би зориуд юм болгоныг эсэргүүцээд байгаа биш. Тэгэхдээ энд протоколд тэмдэглэх зорилгоор юм хэлэх гэсэн юм. Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ өөрийн Засгийн газраа байгуулахдаа улс төрийн манлайлал гаргаж тухайн Засгийн газрыг хэрхэн байгуулах, ямар зорилго, зорилтууд, стратегийн хөгжүүлэлтийн санаанууд гаргаж байгаагаа өдөр тайлбарлаж ярьсан юм. Тэгээд өнөөдрийн болсон үйл явдлын процесс яасан гэхлээр Ерөнхий

сайддын гаргаж байгаа санаачилгыг олонхын бүлгээс нь хамгаалах ийм сонин сонирхолтой үйл явдал болчхож байгаа юм.

Яагаад гэхлээр Монгол Улсын Ерөнхий сайд хэлэхдээ бол энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг батлахдаа, гаргахдаа бол энэ шударга ёсны зарчим гээд энэ Шударга ёс, хууль зүй, дотоод хэргийн яам гэж оруулж ирсэн юм. Тэгээд энийг нь болохоороо Төрийн байгуулалтын байнгын хороон дээрээс Номинчимэг, Цогтбаатар нарын гишүүд санал гаргаад өөрчлүүлчихсэн 12:8-ын харьцаагаар. Тэгэхээр улсын Ерөнхий сайд нь болохлоор Ардын намын дарга Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ нь болохлоороо энэ цоо шинэ энэ манлайллын санаачилга гаргаад үзэл баримтлалын өөрчлөлт гарах гээд байдаг, парламентад байгаа гишүүд нь болохлоороо олонхын бүлэг нь энийг нь няцаагаад байдаг. Ийм зүй тогтол бол хэрхэвч байж болохгүй учраас би эсрэг санал өгсөн юм.

АНУ, Канад, Их Британи, Франц, Герман, Австрали, Япон, Өмнөд Солонгос, Сингапур, Швед зэрэг улсуудад яг энэ Шударга ёсны яамаар явж байгаа. Этимологи буюу үг зүйн, гарал зүйн судлалын хувьд ч тэр хэл шинжлэлийн хувьд ч тэр. Энэ Хууль зүйн яам буюу легал гэдэг ойлголтыг бид нар жастис /justice/ гэдэг рүүгээ явуулахад энэ асар чухал үнэ цэнтэй байсан. Тэгээд Ерөнхий сайдыг эзгүй хоорондуур нь энд хуралдаад, үзэл баримтлалаас нь, өөрсдийн намынх нь олонхын бүлэг буцаж байгаа юм. Энэ бол зарчмын асуудал байгаа. Хууль, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, авлигын эсрэг тэмцэх, хууль, эрх зүйн мэдээллийг олон нийтэд түгээх гээд энэ Хууль зүйн яамны өмнөх бүтэц дээр шударга ёсны энэ үзэл санааг нэмэх юм бол хандлага өөрчлөх, иргэний нийгмийн байгууллагуудыг иргэний эрх ашгийг хамгаалах маш олон давуу талууд байсан. Тэр Ерөнхий сайдын гаргаж

тавьж байгаа энэ манлайллын шинэ зарчим дээр харамсалтай нь та бүхэн ойлголтын зөрүү, бас тодорхой хэмжээний ашиг сонирхол байсан юм уу бүү мэд. Ингээд унагааж байгаа шүү. Энийг би протоколд тэмдэглүүлж байгаа. Чухамдаа Ерөнхий сайдыг өөрийнх нь намаас хамгаалах гэж энэ зүйлийг тайлбарлаад олонхын санал авсангүй. Үүнийг би протоколд тусгая. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Дэг байхгүй байгаа. Түрүүн саналтай гишүүн байна уу гэж асуусан. 1 гишүүн гар өргөсөн Эрдэнэболд гишүүн. Ингээд эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Цогтбаатар гишүүн

**Дам.Цогтбаатар:** Юу гэххэв? Би Швед хэл мэдэхгүй л дээ. Гэхдээ яаж яваад ийм би Швед дээр энэ юуг нь, яамыг юу гэж хэлдгийг би мэддэг юм л даа. Юстид Департамент гэдэг юм. Юстит буюу Герман хэл дээр юстиц, Славян хэлүүд дээр юстиция, Англи хэл дээр жастис /justice/ гэдэг чинь хуулийн контекстдоо бол хууль, эрх зүйн системийг хэлж байгаа юм. Түүнээс жастис /justice/ гэж шударга ёс гэсэн үг.

Би энэ юунуудыг нь хэлье л дээ. Юс Сэнгвинис /jus sanguinis/, Юс Солли /jus soli/, Юс Кожинс /jus cogens/ энэ бүгдээрээ хууль гэсэн үг. Римийн эрх зүйгээс гаралтай үгнүүд байгаа юм. Тэгээд энэ үгний этимологи нь нээрээ шударга ёс гэдгээс тэгээд бүр Римийн үедээ хуулийг л хэлдэг байсан юм. Юс гэж хуулийг хэлж байгаа юм. Жастис юс гэж шударга ёсыг бас хэлдэг.

Одоо доктор гээд үг байгаа. Эмч гэдэг үг, бас эрдмийн зэргийг хэлдэг. Тэгсэн эмч гэдгээр нь аваад, физикс доктор гэхлээр физикийн эмч гэж хэлэх нь л дээ. Физикийн доктор, эрдэмтэн

гэсэн үг байхгүй юу. Тэрийг ингээж хүчилж орчуулж болохгүй хөөе. Тийм учраас Герман дээр гректикайд гэж спревлюс буюу шударга ёс гэсэн үг. Герман дээр бундест миннестериум гректикайд гэж хэлдэггүй. Өөрөөр хэлбэл, шударга ёсны яам гэж хэлдэггүй. Бундест миннестериум юстиц гэдэг. Тэр нь Хууль зүйн яам гэсэн үг байхгүй юу.

Австри хэл дээр Бундест миннестериум фюр юстиц гэдэг бас Хууль зүйн яам гэсэн үг. Тэгээд ерөөсөө энд хар аа нэг аюултай юм явж байгаа юм. Яагаад зарчмын хувьд би зөвшөөрөхгүй байгаа вэ гэхлээр шударга ёс таслал хууль зүйн яам гэхлээр хуулиас гадуур шударга ёс тогтоох гэж байна шүү дээ. Энэ чинь 37 он байхгүй юу. Хуулийг дээдэлдэг нийгэмд хуульд шингэсэн шударга ёс л байдаг. Түүнээс үзэмжийн шударга ёс байхгүй шүү. Тэгвэл амийг амиар солино гэдэг.

Гэтэл өнөөдөр Монголын хуульд хамгийн хатуу шийтгэл нь насаараа хорих ял байгаа. Хохирсон хүмүүс хэзээ ч энийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэгэхдээ энэ чинь шударга ёс шүү дээ. Энэ 2 тусдаа ойлголт. Хэдэн мянган жил ингээж явж ирсэн. Тэр департамент оф жастис /Department of justice/ гэж байгаа чинь Англи дээрээ та нар аваад үзээрэй жастис /justice/ гэдэг үгийг яг хуулийн утгаар нь Админэйшн оф дэ лоо /admission of law/ гэж байгаа.

Департамент оф жастис /Department of justice/ гэдэг чинь хуулийг хэрэгжүүлдэг АНУ-ын нээрээ Ерөнхий прокурор нь Хууль зүйн яамаа удирддаг л даа. Тэгэхдээ хуулийг хэрэгжүүлдэг гол институц нь байхгүй юу. Хуулийг хэрэгжүүлдэг. Тэрний цаана шударга ёс яваад байгаа нь үнэн. Тэгэхлээр энийг ийм утгаар нь хэрэглэж болохгүй. Шударга ёсыг хуулиас салгаж ялангуяа Хууль зүйн яам ингэх юм бол аюул болно. Төрийн байгууллагууд бүгд шударга байх ёстой.

**Д.Амарбаясгалан:** Гишүүн саналаа хэлж дууслаа. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан хуулиуд

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгад найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гэсэн гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5.Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

6.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

7.Засгийн газар дахь хяналтын тухай хууль хуульд өөрчлөлт орох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

8.Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

9. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10. Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

12. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

13. “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо байгаа юу?

Одоо Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал Ерөнхий сайдын танилцуулга хийгдэж эхэлнэ. Бэлтгэл

хангая 10 минут. Түр завсарлая. Чуулганыхаа танхимыг бэлдье.

**Д.Амарбаясгалан:** Хуралдаанаа үргэлжлүүлье. Хэлэлцэх асуудал.

04.25 цаг

Лхагва гараг, 10 Долоодугаар сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
05 цаг 43 минут.

**Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу “Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүнийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

“Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтүяа, Баттогтохын Чойжилсүрэн нарыг Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны, Сандагийн Бямбацогтыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Ганзоригийн Тэмүүлэнг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Жанчивын Галбадрахыг Улсын



Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны, Лувсаннъямын Гантөмөр, Пүрэвжавын Сайнзориг нарыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Эрдэнэбилигийн Одбаяр, Тогтмолын Мөнхсайхан, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Сайнбуянгийн Амарсайхан, Чинбатын Ундрам нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Болдын Жавхланг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Борхүүгийн Дэлгэрсайхан, Буяагийн Тулга, Жадамбаагийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Жамбын Батсуурь, Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг, Ганзоригийн Тэмүүлэл нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Жанчивын Галбадрах, Чинбатын Ундрам нарыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны, Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Баттөмөрийн Энхбаярыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Болдын Жавхлан, Саруулсайханы Цэнгүүн нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Ингээд “Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт гар өргөж явагдана. Дэмжиж байгаа гишүүдийг гараа өргөхийг хүсье.

Баярлалаа. Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. Тогтоолын төсөл батлагдлаа олонхын саналаар.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэж эхэлбэ.

Засгийн газрын гишүүдийг томилсны дараа Байнгын хороод хуралдаж, даргаа сонгож, Улсын Их Хурлын чуулган дээр даргаа сонгосон талаар танилцуулга хийж тогтоол батална. Дэд хорооны бүрэлдэхүүнийг бас зарлаж тогтоол батална. Тэгээд анхдугаар чуулган завсарлана.

Тийм учраас гишүүд өнөөдөр анхдугаар чуулган завсарлатал ирцээ хангалттай бүрдүүлэх, санал хураалтад идэвхтэй оролцох дээр анхаарал тавина шүү. Дараагийн асуудалд оръё.

05.49 цаг

**Засгийн газрын гишүүнийг томилох тухай Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.**

Засгийн газрын гишүүдийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хүн нэг бүрээр танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр томилохоор Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний дагуу танилцуулж байна.

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар Лувсанн्याмын Гантөмөрийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар Сайнбуянгийн Амарсайханг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар Тогмидын Доржхандыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Ням-Осорын Учралыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээ харууцсан Үндэсний хорооны даргаар Эрдэнэбилигийн Одбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргаар Равжихын Эрдэнэбүрэнг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргаар Буяагийн Тулгыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдаар Батмөнхийн Батцэцэгийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдаар Болдын Жавхланг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Оюунсайханы Алтангэрэлийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар Цэвэгдоржийн Тувааныг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар Сандагийн Бямбацогтыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар Салдангийн Одонтуяаг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайдаар Пүрэвсүрэнгийн Наранбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдаар Борхүүгийн Дэлгэрсайханыг, Монгол Улсын газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаар Чинбатын Номинг,

Монгол Улсын газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар Жамбын Батсуурийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад нэр дэвшигч Жадамбын Энхбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаар Цэндийн Баатархүүг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдаар Баттогтохын Чойжилсүрэнг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдаар Тогтмолын Мөнхсайханг тус тус томилохоор танилцуулж байна. Нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй танилцуулгыг та бүхэнд тараасан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ингээд Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Кноп дарж нэрээ өгье. Чулуунбилигийн Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. 8 гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсанн्याмын Гантөмөрийг энэ сайдаар дэвшиж байгаад дэмжиж байгаа. 2012-2016 оны хооронд Боловсролын сайдаар ажиллаж энэ салбарт маш их том өөрчлөлтийг авчирсан, олон олон мянган оюутнуудыг сургаж, инженерүүдийг сургаж энэ Монголын хөгжилд бас тодорхой хувь нэмэр оруулсан. Дээрээс нь боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж түүнийг дагасан авьяас ном, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, үүний үндсэн дээр боловсролын салбар маань илүү сайн амжилтад хүрсэн ийм он жилүүд байгаа.

Тэгээд өнөөдрийг хүртэл 5, 6 сайд томилогдож байхад энэ цөм хөтөлбөрийг өөрчлөлгүйгээр авч явж байна гэдэг нь ямар чадвартай, ямар Монголын багш нарын, Монголын

эрдэмтдийн оюун санаан дээр суурилсан, туршлага дээр суурилсан ийм хөтөлбөр болсныг харуулж байгаа. Тэгэхээр энэ Эдийн засаг, хөгжлийн сайдыг маш өндөр түвшинд, Шадар сайдыг өндөр түвшинд хийнэ гэдэгт би огт эргэлзэхгүй байгаа. Мэдлэг боловсролын хувьд ч тэр, туршлагын хувьд ч тэр бүх зүйлээрээ. Найзын хувьд бас ганц зүйл хэлмээр байна. Үнэхээр Ардчилсан нам тал талдаа тарчихсан, тамга тэмдгийн хэрүүл хийчихсэн энэ үед нь энэ намыг бөөгнүүлж нэгд толгойтой болгож, энэ сонгуульд оролцуулж өнөөдрийн амжилтыг хэдийгээр бас олон нийтийн зарим нэгэн хүмүүсийн хүсэж байгаа тэр амжилтад хүрээгүй ч гэсэн бид нар өнөөдөр бас ийм олуулаа суугаад энэ хамтарсан засагт орох энэ ажлыг хийгээд явж байгаа.

Тэгэхээр энэ өрсөлдөгч нар ямар хатуу, харгис хүмүүс байдгийг бол сая өнгөрсөн сонгуулиар харсан. Гэр бүл, өөрийн нэр хүнд, үр хүүхэд бүх зүйлээр шүүрэн шанага болтол нэр хүндийг нь гутаах ийм зүйлийг бүх зүйлээр давж гарч, энэний ард энэ сонгуулийн ард гарч бас ийм тодорхой амжилт гаргасан найздаа улам их зүтгэж амжилт гаргахыг хүсэн ерөөе.

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ.  
Батын Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Улсын Их Хурлын 126 гишүүнээс 118 гишүүний дэмжлэгтэй Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ бүрэлдэж байна. Тэгээд та бүхний ажилд амжилт хүсье. Их Хурлын чуулганы танхимд 118 хүн хуралдаа суудаг биш 126 хүн бас хуралдайд суудаг байгаасай гэж хүсмээр байна. Одоо улс оронд эрх зүйн хувьд, улс төрийн хувьд, эдийн засгийн хувьд хийх ёстой олон ажил байгаа. Ийм том олонхтой Засгийн газар бараг урьд нь бүрдээгүй байсан байх өнгөрсөн цаг хугацаанд. Ингээд та бүгдийн ажилд амжилт хүсье.

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ.  
Буланы Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Та бүгдэд өглөөний мэнд хүргэе. Ерөнхий сайдын оруулж ирсэн Засгийн газрын гишүүдийг бүгдийг нь дэмжиж байгаа. Гэхдээ бас анхааруулж сануулж хэлэх хэд хэдэн асуудал байгаа. Би өнгөрсөн 4 жилд эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, хөдөө аж ахуйн салбарт бас нэлээн анхаарч ажиллалаа. Ялангуяа эрүүл мэндийн салбарт ингээд салбарын хүн томилж байгаадаа бас баяртай байгаа. Тэгээд Тогтмол сайд урьд нь бас хийж байсан, Мөнхсайхан сайд уучлаарай. Тэгэхээр өнгөрсөн 4 жил бид эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг нэмүүлж чадаагүй та мэдэж байгаа. Яагаад гэвэл хотын клиникийн эмнэлгүүдийн ихэнх нь сувилагч нарын дутагдалтай, эмч нарын цалин бага. Энийг нэмүүлэх тал дээр бас анхаарч ажиллаарай.

Нөгөө талаар хөдөөгийн ард иргэдийн тулгамдсан асуудалд хөнгөлөлттэй эм авч чадахгүй байгаа. Ялангуяа сум, багийн түвшинд эмнэлгийн тусламжийг ойртуулж ажиллаарай гэдгийг хэлмээр байна.

Боловсролын салбарын хувьд бас ХҮН нам авч байгаа юм байна. Энэ дээр бас анхаарч ажиллана уу. Улс төржихгүйгээр энэ дээр нэлээн анхаарч ажиллахгүй бол бас эмзэг салбар. Энэ дээр бас боловсролын салбарын сургууль, цэцэрлэгүүд дээр бас нэлээн анхаарлаа хандуулж ажиллахыг бас та бүгдэд хэлье.

Хөдөө аж ахуйн салбарын хувьд бас туршилагатай хүн очиж байгаа юм. Нөгөө талаар бас мал аж ахуйн салбарт бас төслийг хэрэгжүүлж байгаа хүний хувьд бас Энхбаяр гишүүн энэ тэр нэлээн анхаарч ажиллаж байх гэж бодож байна. Гол нь энэ түүхий эд боловсруулах үйлдвэр барихгүй бол малыг нь түгээд гадаа хаягдаж байна. Малын ноос,

ноолуур, арьс шир энэ жил нэлээн хаягдаж байгаа. Энэ асуудал дээр анхаарч ажиллана уу гэдгийг хэлье.

Нийт Засгийн газрын гишүүддээ ажлын амжилт хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Банзрагчийн Түвшин гишүүн.

**Б.Түвшин:** Та бүхэндээ энэ өглөөний мэндийг хүргэе. Сангийн сайдад баяр хүргэе нэр дэвшиж байгаад. Ер нь эдийн засаг гэж өөрөө манай Монгол Улсын нийт иргэдийн нийт эдийн засгийг хэлж байгаа. Төсөв, санхүүгийн хувьд бол зөвхөн төрийн хуримтлуулж байгаа мөнгө биш. Тийм учраас иргэдийнхээ ачааллыг бууруулж, татварыг бууруулах, нөгөө талаас ажлын байрыг нэмэгдүүлэх, нийт эдийн засгийнхаа нийт дүнг нь том болгох, иргэдийнхээ ахуйг дэмжих талын бодлого явуулаарай гэж энэ дээр бол анхаараарай гэж хэлэх байна.

Хоёрдугаарт, Хүнс, хөдөө аж ахуйн сайдад асуулт асуух гэсэн юм. Ер нь нүүдлийн мал аж ахуйг эдийн засгийн эргэлтэд оруулах, нүүдлийн мал аж ахуйг нүүдлийн чигээр нь явуулах тал дээр ер нь ямархуу бодлого барьж ажиллах вэ? Энэ талаараа бас товчхон мэдээлэл өгөөч гэж хүсэх гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Хүнс, хөдөө аж ахуйн сайдад нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Энхбаяр.

**Ж.Энхбаяр:** Нүүдлийн мал аж ахуй бол мэдээж манай мянга мянган жил бидний эцэг эхээс өвлөж ирсэн манай томоохон соёл. Мэдээж нүүдлийн мал аж ахуй Монголын өргөн дэлгэр нутаг оронд орших ёстой. Мөн үүнтэй зэрэгцэн газар тариалангийн бүс нутаг буюу тэжээлийн бааз суурь дээр тулгуурласан хүн амын төвлөрсөн өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг

хангахын тулд зарим бүс нутагт зайлишгүй эрчимжүүлэлтийг авч хэрэгжүүлэхээс өөр арга байхгүй. Тэгж байж тасралтгүй, байнгын хүнсний хангалтыг зохих түвшинд нь барина.

Мэдээж нүүдлийн мал аж ахуйгаа бид байгаль цаг уурын энэ эрсдэлээс онцгой хамгаалах, даван туулах тэр чадавхыг бий болгох зайлишгүй сорилт бидний өмнө тулгараад байгаа. Байгаль цаг уурын томоохон өөрчлөлт, ган, зудын давтамж, дэлхий ертөнцөөс гарч байгаа энэ дэлхийн цаг уурын өөрчлөлтийг бид нүүдлийнхээ мал аж ахуйгаа дасан зохицох эрсдэлийг бууруулахын тулд томоохон бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх ёстой болж байгаа. Мөн бэлчээрийн асуудал буюу бэлчээрийн талхлалтын асуудлыг санаа зовоож байгаа. Нутаг дэвсгэрийн 76 орчим хувь бэлчээр нэлээн доройтолд орсон. 96 хувь үндсэндээ цөлжилтөд нэрвэгдэж хөрсний бүтэц маш хүчтэй эвдэрч байгаа ийм тоо судалгаа байгаа.

Иймд нүүдлийн соёл иргэншлийг бид авч үлдэх нь нэг талдаа түүх, соёл, уламжлал, үнэт зүйлээ авч үлдэх, нөгөө талаасаа 200 гаруй мянган малчин өрхийнхөө амьдралыг тогтвортой байдлаар хангах энэ үүднээс Засгийн газар хэрэгжүүлж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан олон хөтөлбөрүүд байгаа. Энэ хөтөлбөрүүд энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт багтаж цааш үргэлжлүүлж, хэрэгжүүлэхээр тусах байх гэж найдаж байгаа. Энийг оруулахын төлөө ажиллах болно. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**С.Эрдэнэболд:** Баярлалаа. Монгол Улс Тулгар төрийн 2233 жилийн ойн Үндэсний их баяр наадмын босгон дээр Монгол Улсын 33 дахь Ерөнхий сайдын байгуулж байгаа кабинет дараагийн 30 жилийн манлайллыг зарлаж, Засгийн



газраа бүрдүүлж байна. Энэ Засгийн газраас хүсэх хамгийн гол зүйл бол улс төржиж, явцуурхаж, намчирхалгүйгээр, аль нэгэн намын эрх ашигт хэт авталгүйгээр Монгол Улсын Засгийн газар Монголын ард түмний хөгжил дэвшилд хөтөлсөн монголчуудад эрмэлзэл, мөрөөдлийг бий болгосон, залуучууд нь эх орондоо эзэн хүний ёсоор сайн сайхан амьдрах тэр боломжийг бодлогоор бий болгосон Засгийн газар байгаасай.

Тийм учраас нэгэнт хамтраад явж байгаа тохиолдолд бодлогын хувьд зангидагдаж Монгол хүн Монголын хөгжлийн төвд байх тэр бүхий л эрэлхийллийг хийж, их явж, их сууж, их уншиж, их харилцаж, дэлхийг Монголотой илүү сайнаар холбоход бүгдээрээ хичээн зүтгээсэй гэж хүсэж байгаа. Ил тод байдал, иргэдийн оролцоо, хариуцлага гэдэг зүйлийг бүх салбарт жигд хэрэгжүүлээсэй. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдыг томилогдох мөчид Үндэсний аюулгүй байдлын 1.1.4 үүнийг протоколд тэмдэглүүлсэн. Үүнийг бас Засгийн газрын гишүүд маань анхаарч ажиллаасай гэж бодож байна. Шинжлэх ухааныг бүхий л талаар хөгжлийнхөө суурь болгож ашиглаасай. Энэ удаагийн парламентад олон мэргэжлийн шинжлэх ухааны төлөөллүүд оролцсон байгаа. Тэр утгаараа ч гэсэн энэ үнэ цэнийг, энэ хүний нөөцийг ч гэсэн бас зөв ашиглаж, ер нь бид нар энэ популизмаас илүү шинжлэх ухаан руу чиглэсэн хөгжил рүүгээ Монгол Улс нэг үнэ цэнтэй яваасай гэж бодож байна.

Энэ таширамд манай Ардчилсан намаас Баатархүү, Алтангэрэл, Одбаяр нарын 80-аад оны залуучууд бас кабинетад байна. Манай Учрал, Батнайрамдал, Номинчимэг, Анар гээд бас залуучууд байна. Та бүхнийг ард иргэд бас нам харгалзахгүйгээр энэ залуу үеийн төлөөлөл, манлайллын шинэ үлгэрлэлийг гаргах байх гэж найдаж байгаа шүү. Тийм учраас энэ

үеийнхнийхээ итгэлийг алдахгүй, хуулийг ягштал баримталж, авлига, хулгай зэлгийгээс ангид байж, ил тод, амжилттай ажиллаарай гэж хүсэж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Заяабал:** Улсын Их Хурлынхаа эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе.

Өнөөдөр ингээд хамтарсан Засгийн газар үйл ажиллагаагаа эхлэхэд тун ойрхон ирж байна. Мэдээж Ардын намын дүрэмд заасны дагуу Бага хурлаараа шийдвэр гаргаад хамтарсан Засаг газар байгуулах энэ шийдвэр гараад өнөөдөр ингээд хэрэгжээд явж байна. Шинэхэн сонгогдсон гишүүн миний хувьд энэ хамтарсан Засгийн газраас маш их хүлээлттэй байгаа. Монгол Улсын хөгжил цэцэглэлттэй холбоотой маш их олон зүйлүүдийг энэ хамтарсан Засгийн газрын хүрээнд шийдэгдэнэ гэдэгт бол бас итгэж байгаа гэдгийгээ бас би бас юуны өмнө бас хэлэхийг хүсэж байна.

Хамтарсан Засгийн газар байгуулаад ирэх намрын чуулганаар энэ Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд бас бэлдэж оруулж ирэх байх. Энэ дээрээ бид нар ингээд 4 жилийн үйл ажиллагааг тусгасан ийм ерөнхий заалтуудыг битгий тавьж орж ирээсэй гэдэг ийм бас санал илэрхийлэх гэж байгаа юм. Энэ хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааг 1 жилийн дотор яг дараа жилийн өдөөд ямар ямар том том төслүүдийг ямар алхам хийчихсэн байх юм бэ гэдэг ийм хүрэх үр дүнтэй жил жилээр ингээд тодорхойлсон ийм Улсын Их Хурлын гишүүд болон иргэд сонгогчдод бас ийм ажлыг нь дүгнэх, үнэлэх ийм боломж олгосон ийм үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж оруулж ирээсэй гэдэг ийм бас саналыг бас хэлэх гэж байгаа юм.



Хоёрдугаар тойрог баруун бүс нутагт бас нэр дэвшиж иргэд олон нийттэй уулзаж байх хугацаанд бас нэлээдгүй асуудлууд яригдаж байсан. Энийг би бас дурдаж бас энийг шинээр бүрдэж байгаа Засгийн газраас анхаарч ажиллаасай гэдгийг би хүсэж хэлэх гэж байгаа юм. Яагаад гэвэл удахгүй наадам болно, орон нутаг руугаа явна. Намараас өгсүүлээд бас сонгогчид олон нийттэйгээ бас уулзана. Сонгогч олон нийт бол яг эргээд л яг сонгосон Их Хурлын гишүүдээсээ энэ ажлын гүйцэтгэлийг надаас шаардана. Тэгэхлээр энэ гүйцэтгэлийн шаардлагыг эргээд би Засгийн газраасаа нэхэх учраас та бүхэнд бас анхааруулж хэлэхийг бас хүсэж байгаа юм.

Хамгийн гол нь яригдаж байгаа зүйл энэ манай баруун бүс нутагт өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнүүд Улаанбаатар хот бас өндөр үнэтэй байдаг. Бензин шатахуун өндөр үнэтэй байдаг, ажлын байр л байр орлого багатай байдаг, мөн малчдын хувьд бас энэ орлого маш их буурсан мах, ноолуураар л орлогоо залгаж явж байна. Залуу халаа болсон залуу малчид бас байхгүй болж байна гэсэн бас ийм зүйлүүдийг манай сонгогч олон нийт бас хэлж байгаа. Төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчид маань бас энэ удаан жилийн нэмэгдэл өгөхгүй байна, агентлагуудын босоо, хэвтээгээр ялгаатай байна гэх мэтчилэн энэ Хөдөлмөрийн тухай хуульд орсон, орсны дагуу энэ ээлжээр ажилладаг ажилчдын хувьд бас ийм хүндрэлтэй байдал үүслээ гэх мэтчилэн зүйлүүдийг ярьж байгаа юм.

Тэгэхлээр үүнийг бас шийдвэрлэх тал дээр та бүхэн бас анхаарч ажиллаарай гэдгийг би хэлэхийг хүсэж байгаа юм. Ингээд цаг бас дуусчих шиг боллоо.

**Д.Амарбаясгалан:** Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**С.Эрдэнэбат:** Юуны өмнө их итгэлцэл, эв эеийг хүсэн хүлээж байгуулж байна. Анхны 126 гишүүнчлэлтэй энэ парламентаас эвслийн Засгийн газар нэртэй байгуулагдаж байгаа учраас шинээр томилогдож байгаа Засгийн газрын гишүүддээ нэгдүгээрт ард түмний өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа мартаж болохгүй. Зөвхөн өөрийнхөө өөрийнхөө нам эвслээс дэвшсэн мөрийн хөтөлбөрөөс гадна энэ танхимд байж байгаа 126 хүмүүсийнхээ итгэл найдварыг бас хүлээж ажиллах хэрэгтэй гэдгийг бас сануулж бас хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ салбарт олон ажилчид хүлээж байгаа сэтгэлээрээ, насаараа ажил амьдралаа зориулаад өгчихсөн байгаа олон албан хаагч нар ямар сайд ирж ямар зүйлийг хийх вэ гэдгээ хүлээж байгаа. Тэгэхээр тэр хүмүүсийн бас итгэл найдвар, эвлэлдэн нэгдэх эрх, тэр хүмүүсийн хүсэл эрмэлзлийг нээж өгсөн дарж дарамталсан биш тийм сайд нар байгаасай гэж би бас бодож байна.

Гуравдугаарт, өнгөрсөн хугацаанд бас хийж байсан томоохон бас амжилтуудыг цааш нь үргэлжлүүлэх, хийж амжаагүй алдаануудыг нь засаад явах ийм бас сайд нар байгаасай гэдгийг бас хэлмээр байна.

Ялангуяа нийгмийн түншлэлийн хувьд. Хамгийн түрүүнд очоод тухайн албан хаагчдын дуу хоолойг сонсоорой. Босгыг нь алхаад үүдэнд нь байж байгаа эгэл жирийн ажилчдаас нь авхуулаад мэргэшсэн албан хаагчдынх нь дуу хоолойг бас сонсож ажиллаарай.

Хоёрдугаарт, ажил олгогчдын тухайн салбарын хүсэн хүлээж байгаа ажил олгогч нар байдаг тэр хүмүүсийг бас хүлээж авч уулзаарай. Нийгмийн түншлэлийг өнгөрсөн хугацаанд бас багагүй хэмжээгээр шинэ шатад гаргаж ажилласан. Үүнийг өшөө илүү та бүгд

маань шинэ шат ахиулж бас ажиллаарай гэдгийг бас захимаар байна. Тэгээд бүгдэд нь бас амжилт хүсье. Томилогдсон цагаас нь авхуулаад бас нэг талаар хариуцлага, үр дүн нэхээж ажиллах болно. Сайн гаргаж байгаа үр дүнтэй ажлыг нам харгалзахгүй, талцаж хуваагдалгүй кабинетын зарчмаар ингээж ажиллаарай гэдгийг бас та бүгддээ захиж байна. Тэгээд бүгдэд нь амжилт хүсье.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Энэ чинь өө уучлаарай Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууж, үг хэлэх нь байна.

**Ч.Лодойсамбуу:** Баярлалаа. Сангийн сайд Жавхлангаас тодорхой 2, 3-хан юм асууж, тодорхой яг точный хариулаад өгөөрэй оршилгүй асуучихъя.

Төсвийн зардал хэдэн хувиар нэмэгдэх вэ нэг?

Хоёрдугаарт, татварууд буух уу?

Гуравдугаарт, тусад нь НӨАТ-ын хувь хэмжээ буурах уу? Буцаан олголт 2 хувь нэмэгдэх үү? Энд л тодорхой хариулт авчихъя.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн, нэр дэвшигч Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Лодойсамбуу гишүүний асуултад хариулъя. Эдгээр асуултуудад манай мөрийн хөтөлбөр дотор маш тодорхой хариултууд байгаа шүү. Улсын төсвийн зардлын хэмжээ бол ДНБ-ий өсөлт болон бусад төсвийн зохицуулалтын хуулиудын хязгаарлалт дотроо байна. 2024 оны болон 2025, 26 27 он хүртэл бид хуульчилчихсан ийм төсвийн хүрээн дотроо ингээд ойрын 2-3 жилийн бүх төлөвлөлтүүд хийгдчихсэн байгаа.

Тийм учраас тэрнээс хэтэрсэн зардал болон бусад орлогын хэмжээнүүд гэж байх боломжгүй. Энэ хүрээндээ явна гэсэн үг.

Хоёрдугаарт, татварын хэмжээ буурах уу гэж байна. Татвар бол өөрөө энэ мөнхийн сэдэв. Ганц Монгол Улсад ч биш, дэлхийн хэмжээнд, олон улсад энэ нь өөрөө мөнхийн сэдэв, мөнхийн сэдэв байдаг. Энэ дээр нэг л юмыг ойлгох хэрэгтэй. Тухайн үед эдийн засаг, нийгэм маань өөрөө ямар чадамжтай байна? Ингээд 1 удаагийн сонгууль харж байгаад татвараа нэмээд юу гэдэг юм төрийн үйлчилгээ, төр юмаа санхүүжүүлэх энэ юмаа хараад, эсвэл татвараа буулгаад энэ татвар төлөгчдийнхөө боломжийг хараад ч юм уу ийм тогтворгүй байдал үүсгэж хэрхэвч болохгүй. Хамгийн гол нь бид нарын суурь бол энэ татвар төлөх чадамжийг нь нэмэгдүүлэх, эдийн засаг, нийгмийнхээ боломжуудыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх л хамгийн чухал асуудал юм байгаа юм. Энэ талаар мөрийн хөтөлбөр дотор маш тодорхой заалтууд орсон байгаа. Мөн танай намын заалт нь мөрийн хөтөлбөр дотор ч гэсэн асуултууд орсон байгаа.

Гэхдээ дараагийн 30 хоногийн дотор нэгэнт хоёр том нам хамтарч байгаагийн хувьд хөтөлбөрөө хийхдээ энэ дээрээ харин маш сайн ярилцах, маш сайн судалгаатай ирээдүйгээ харсан, мөн сууриа их маш сайн тооцсон ийм байх ёстой болов уу гэж ингээж харж байна.

НӨАТ дээр НӨАТ бол өөрөө энэ татварын суурь асуудал шүү. Үүнийг ойрын хэдэн жилдээ хэдүүлээ оролдоод хэрэггүй болов уу гэж бодож байна. Тийм.

**Д.Амарбаясгалан:** Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Засгийн газрын гишүүдийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцлоо.

Одоо Засгийн газрын гишүүд тангараг өргөх ёслолын ажиллагаанд бэлтгэнэ. 20-оос 30 минутын хугацаа орно. Энэ хооронд Төрийн байгуулалтын байнгын хороо, Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороод хуралдаж даргаа сонгох, Дэд хороодын бүрэлдэхүүнийг эцэслэж Улсын Их Хуралд танилцуулахаар бэлтгэнэ. Түр завсарлалаа.

06.16 цаг

Лхагва гараг, 10 Долоодугаар сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
06 цаг 55 минут.

**Д.Амарбаясгалан:** Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Зарим байнгын хороон даргыг сонгох тухай” асуудал хэлэлцэнэ. Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар танилцуулна. Индэрт урья.

**Ч.Анар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн заалт 8.1.6 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг тус Байнгын хороо 2024 оны 7 сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршилага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн тухай

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулсан.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн 1981 онд төрсөн 2003 онд Америкийн их сургуулийг Олон улсын харилцааны бакалавр, 2005 онд Америкийн их сургуулийг Олон улсын удирдлагын магистраар төгссөн. Олон улсын харилцааны мэргэжилтэй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нь 2006-2007 онд Ашигт малтмал, газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтэст мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2008-2009 онд Ашигт малтмал, газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтсийн дарга, 2009-2014 онд Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХК-д дэд захирал, 2013-2015 онд “Оюутолгой” ХХК-д ТУЗ-ийн гишүүн, 2014-2015 онд Монгол Улсын Уур уурхайн яамны дэд сайд, 2015 оноос Нийгмийн ардчилал монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч, Монгол ардын намын Удирдах зөвлөлийн гишүүн, 2016-2020 онд Улсын Их Хурлын гишүүн, 2020-2024 онд Улсын Их Хурлын гишүүн, 2022 оноос Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа болно.

Байнгын хорооны хуралдааны үед нэр дэвшигчээс асуулт асуух, үг хэлэх гишүүд гараагүй болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнг нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнг нэр

дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдсон, ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээ сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэж заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг нь харгалзан Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг нэр дэвшүүлсэн болно.

Жадамбын Бат-Эрдэнэ 1983 онд нийслэлийн 75 дугаар дунд сургууль, 1989 онд ОХУ-Эрхүү хотын Политехникийн дээд сургууль, 1998 онд МУИС-ийн Хууль

зүйн сургууль Эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн.

Жадамбын Бат-Эрдэнэ 1990-эсрэг онд ОХУ-ын “Рыпкооп” улсын үйлдвэрийн газар менежер, 1994-2000 онд “Ашид-Эрдэнэ” ХХК-ийн захирал, 2000-2004 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто тээврийн газрын дарга, 2007-2012 онд Зам, тээвэр, ажлал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2008-2012 онд Монголын төмөр зам ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга, 2011-12 онд МИАТ-ийн ХК-ийн ТУЗ-ийн дарга, 2013-2016 онд Булган аймгийн Монголд Ардын намын хорооны дарга, 2016-20 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2017-2018 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, 2019 оноос Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны дарга, 2020-2024, 2024 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед нэр дэвшигчээс Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, саналаа илэрхийлээгүй болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийн нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Д.Амарбаясгалан:** Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн



Түвшин танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Түвшин:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг тус байнгын хороо 2024 оны 7 сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн саналаар Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн нь 1964 онд төрсөн. Тэрээр 1983 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийг дүүргэж, 1989 онд ЗХУ-ын Харьков хотын Политехникийн дээд сургууль, 1994 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт Бизнесийн удирдлагын менежер, 1998 онд Япон улсын Сайтомогийн их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн байна.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн нь 1989-1992 онд Төвийн эрчим хүчний системд автоматикийн инженер, 1995-1999 онд Сангийн яамны Валютын харилцааны газарт мэргэжилтэн, 1999-2000 онд Сангийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга, 1999 онд Сангийн яамны Эдийн засгийн

бодлогын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, 2000-2005 онд Санхүү эдийн засгийн яамны Төрийн сангийн газрын дарга, 2005-2008 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга, 2005 онд Шадар сайдын Эдийн засгийн зөвлөх, 2008-2012 онд Улсын Их Хурлын гишүүн, 2009-2010 онд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2012-2016 онд Улсын Их Хурлын гишүүн, 2012-2014 онд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2016-2020 онд Улсын Их Хурлын гишүүн, 2017-2020 онд Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд, 2020-2024 онд Улсын Их Хурлын гишүүн, 2021 онд Оюутолгойн түр хорооны дарга, 2023 оноос Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайд, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа болно.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нэр дэвшигчээс Төсвийн байнгын хорооны даргын хувьд ашиг сонирхлоос ангид ажиллаж чадах эсэхийг асуулт асууж, хариулт авсан болно.

Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг нэр дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны



Пүрэвдорж уншиж танилцуулна.  
Индэрт урьж байна.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 25 дугаар зүйлийн 25.7, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт заасныг үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 7 сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж тус Байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг нэр дэвшүүлсэн болно.

Дамдины Цогтбаатар 1988 онд Монгол, Оросын хамтарсан 14 дүгээр сургууль, 1994 онд ОХУ-ын Москва хотын Олон улсын харилцааны дээд сургуулийг Улс төр судлалын мэргэжлээр, 1988 онд Австралийн Холбооны Улсын Үндэсний их сургуулийг Олон улсын хуульч мэргэжлээр тус тус төгссөн.

1994-2002 онд Гадаад хэргийн яаманд, 2002-2008 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх, 2008-2011 онд Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2011-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2012 онд Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, 2014-2015 онд Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайд, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016 оноос 2018 онд Хүний эрхийн дэд хорооны дарга, 2017-2020 онд Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд, 2020-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 23-24 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин асуулт асууж, хариулт авсан болно.

Хууль зүйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна. Одоо санал хураалт явуулъя.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Ганзоригийн Тэмүүлэнг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье.

Татгалзаж байгаа гишүүд байна уу?

Алга байна. Батсуурь гишүүн татгалзаж байгаа юм уу, дэмжиж байгаа юм уу? Тэгвэл санал хураалтад 81 гишүүн оролцож, 81 дэмжлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороон даргаар Жадамбын Бат-Эрдэнийг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 83 гишүүн санал хураалтад оролцож нийт гишүүдийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хороон даргаар Цэдэнбалын Даваасүрэнг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулъя. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүн байна уу?

Алга байна. 83 гишүүн санал хураалтад орж, нийт гишүүдийн саналаар сонгогдлоо.

Хууль зүйн байнгын хорооны даргаар Дамдины Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалтыг явуулна. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзаж байгаа гишүүд байна уу?

Санал хураалтад 83 гишүүн оролцож дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Улсын Их Хурлын зарим Байнгын хорооны даргаар дараах Улсын Их Хурлын гишүүдийг сонгосугай.

1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Ганзоригийн Тэмүүлэн

2.Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Жадамбын Бат-Эрдэнэ

3.Төсвийн байнгын хорооны даргаар Цэрэнпилийн Даваасүрэн

4.Хууль зүйн байнгын хорооны даргаар Дамдины Цогтбаатар

2.Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

07.11 цаг

**Дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье.**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг энэ хуралдаагүй байгаа уучлаарай.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, 27.3.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 24 оны 7 сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд тараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон 9 гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллөөс оруулна. Гишүүдийн сонгогдсон тоо адил байгаа тохиолдолд тэдгээрийн харьяалагдах нам, эвслийн бүлгийн саналыг баримтална гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороог Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Халтмаагийн Баттулга, Жадамбын Бат-Эрдэнэ, Сандагийн Бямбацогт, Лувсаннъямын Гантөмөр, Цэрэнпилийн Даваасүрэн, Баттогтохын Чойжилсүрэн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Жадамбын Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, “Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүгдээсээ хүсье.

**Д.Амарбаясгалан:** Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Далайн

Батбаяр уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Батбаяр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 5, 10-ны өдрүүдийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Дамбын Батлут, Далайн Батбаяр, Ринчиндоржийн Батболд, Хүрэлбаатарын Булгантуяа, Пүрэвжавын Ганзориг, Гонгорын Дамдинням, Батжаргалын Заяабал, Загджавын Мэндсайхан, Банзрагчийн Түвшин, Даваахүүгийн Пүрэвдаваа, Даваагийн Цогтбаатар нарын нэрийг дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Батбаяр уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Бат-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлэг Байнгын хорооны зарим гишүүдийн саналыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүдийг оруулах саналыг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүний талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Н.Батсүмбэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, 27.3.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 7 сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс бичгээр ирүүлсэн санал, хуралдааны үеэр танхимаас бие даан дэвшүүлсэн саналуудыг үндэслэн Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулахаар нэр дэвшүүлээ.

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Отгоншиарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Энхбаярын Батиугар, Батбаярын Жаргалан, Мэндбаярын Мандхай, Баатаржавын Мөнхсоёл, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Агваанлувсангийн Ундраа, Мөнхчулууны Энхцэцэг нарын нэрийг дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.



**Д.Амарбаясгалан:** “Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Дэмжье гэсэн гишүүд гараа өргөхийг хүсье. Баярлалаа.

Татгалзсан гишүүд байна уу?

Алга байна. Санал хураалтад 82 гишүүн оролцож, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Ингээд тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Монгол Улсын Их Хурлын зарим дэд хорооны бүрэлдэхүүний тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын зарим дэд хороодийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд дотроо

1.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо

1.Норовын Алтанхуяг,  
2.Халтмаагийн Баттулга, 3.Жадамбын Бат-Эрдэнэ, 4.Сандагийн Бямбацогт,  
5.Лувсаннъямын Гантөмөр,  
6.Цэрэнпилийн Даваасүрэн,  
7.Баттогтохын Чойжилсүрэн,  
8.Лувсанцэрэнгийн Энх-Амгалан,  
9.Жадамбын Энхбаяр.

2.Төсвийн зарлагын хяналтын дэд хороо  
1.Далайн Батбаяр,  
2.Ринчиндоржийн Батболд,

3.Жигжидийн Батжаргал, Дамбын Батлут, 5.Хүрэлбаатарын Булгантуяа, 6.Пүрэвжавын Ганзориг, 7.Батжаргалын Заяабал, 8.Гонгорын Дамдинням, 9.Загджавын Мэндсайхан, 10.Даваахүүгийн Пүрэвдаваа, 11.Банзрагчийн Түвшин, 12. Даваагийн Цогтбаатар.

3.Хүний эрхийн дэд хороо

1.Хүрэлбаатарын Баасанжаргал, 2.Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, 3.Мөнхтөрийн Нарантуяа, 4.Одсүрэнгийн Номинчимэг, 5.Пүрэвжавын Сайнзориг, 6.Цэндийн Сандаг-Очир, 7.Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, 8.Гончигдоржийн Уянгахушиг, 9.Даваагийн Цогтбаатар, 10.Сүхбаатарын Батболд.

4.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Отгоншарын Батнайрамдал, Пүрэвийн Батчимэг, Энхбаярын Батшугар, Батбаярын Жаргалан, Мэндбаярын Мандухай, Баатаржавын Мөнхсоёл, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Агваанлуvsангийн Ундраа, Мөнхчулууны Энхцэцэг,

2.Энэ тогтоолыг 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хаана байна? Батын Батбаатар гишүүн.

**Б.Батбаатар:** Протоколд тэмдэглэж үлдээх үүднээс нэг санал хэлье. 118 гишүүн маань ерөнхийдөө ингээд эмхэрч цэгцрээд 40 орчим гишүүн Улсын Их Хурлын болон Засгийн газрын тодорхой байршил дээр оччихлоо. Энэ Дэд хороотой холбоотойгоор ялангуяа хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг



цөөнхөд байх ёстой Ёс зүйн, Төсвийн хяналтын, Хүний эрхийн ч гэдэг юм уу энэ дэд хороон дээрээ олон суудал авсан гэдгээр хуваарилахгүйгээр улс төрийн намууд, бүлгүүд ярилцаад бид нар ямар кнопоор илүү гарах юм байхгүй учраас цөөнх болж үлдэж байгаа тэр хэсэгтээ үлдээвэл сайн байна. Тэгэхдээ яах вэ энэ дээр их учиргүй их найдаад байгаа юм алга. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Санал сонслоо. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараачийн асуудалд орёё.

07.22 цаг

**Засгийн газрын гишүүд тангараг өргөх ёслолын ажиллагаа эхэлнэ.**

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр томилсон Ерөнхий сайдын захирамжийг гаргалаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдаар Лувсаннъямын Гантөмөрийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар Сайнбуянгийн Амарсайханг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар Тогмидын Доржхандыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Ням-Осорын Учралыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний

хорооны даргаар Эрдэнэбилигийн Одбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, 20 минутын хот хариуцсан Үндэсний хорооны даргаар Равжихын Эрдэнэбүрэнг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргаар Буяагийн Тулгыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдаар Батмөнхийн Батицэцэгийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдаар Болдын Жавхланг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Оюунсайханы Алтангэрэлийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар Цэвэгдоржийн Тувааныг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар Сандагийн Бямбацогтыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар Салдангийн Одонтуяаг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайдаар Пүрэвсүрэнгийн Наранбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдаар Борхүүгийн Дэлгэрсайханыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаар Чинбатын Номинг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар Жамбын Батсуурийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Жадамбын Энхбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаар Цэндийн Баатархүүг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдаар Баттогтохын Чойжилсүрэнг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдаар Тогтмолын Мөнхсайхан нарыг тус тус томиллоо.

Ингээд Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг өглөө болтол хуралдаж, Монгол Улсын Засгийн газрыг бүрдүүлж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн дагуу явуулах боломжийг олгож байгаад Ерөнхий сайдын хувьд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн эрхэм сайд нар та бүхэн ч гэсэн удахгүй Төрийн сүлдэнд тангараг өргөнө. Энэ тангараг өргөсөн цаг хугацаагаа хэзээ ч мартаггүйгээр төрийн сайд гэдэг бол албан тушаал биш энэ бол ард түмний төлөөх үйлчлэл гэдгийг хэзээ ч мартаггүйгээр улсын эрх ашгийг нэгдүгээрт тавьж, намын болон нөхдийн эрх ашгийг дараа нь тавьж, хувийн эрх ашгаа нийтийн эрх ашгийн төлөө умартан ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлэхийн төлөө хичээнгүйлэн зүтгэхийг та бүхэнд сануулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэндээ ажил хэрэгч хандсанд маш их баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Одоо Засгийн газрын гишүүд тангараг өргөнө. Нэгдсэн хуралдааны танхимын голд Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх байрлалыг бэлдсэн байгаа тул Засгийн газрын гишүүдийг байрлалаа эзлэхийг хүсэж байна.

**Засгийн газрын гишүүд:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсын ашиг сонирхлын эрхэмлэн төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээр тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

**Д.Амарбаясгалан:** Төрийн сүлдэнд хүндэтгэл үзүүлсэн та бүхэнд баярлалаа.

Одоо Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу гишүүдийг нэг нэгээр нь дуудаж төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урих тул та бүхнийг суудлаа эзлэхийг хүсье.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Лувсаннъямын Гантөмөр таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд таныг төрийн далбаанаасаа адис авч, тангаргийн бичигт гарын үсгээ зурна хэмээн урьж байна.

Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хороон дарга Эрдэнэбилигийн Одбаяр таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсгээ зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хороон дарга Буяагийн Тулга таныг төрийн далбаанаасаа адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хороон дарга Равжихын Эрдэнэбүрэн таныг төрийн далбаанаас

адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг таныг төрийн далбаанаасаа адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Сангийн сайд Болдын Жавхлан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Салдангийн Одонтуяа таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урьж байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Чинбатын Номин таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Жамбын Батсуурь таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Цэндийн Баатархүү таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Эрүүл мэндийн сайд Тогтмолын Мөнхсайхан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Засгийн газрын гишүүдэд баяр хүргэж, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. 126 гишүүнтэй парламент анхдугаар чуулганаа амжилттай үргэлжлүүлж Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуулиа баталж, Засгийн газрын гишүүдийг томилж дууслаа.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар их бүтээн байгуулалт, хөгжил дэвшил илүү хурдтай байх тэр бодлого зарчмын төлөө Улсын Их Хуралд суудалтай 3 нам хамтарч Засгийн газраа байгууллаа.

Засгийн газар бол кабинетын зарчмаар ажилладаг байгууллага гэдгийг

манай Засгийн газрын гишүүнээр сонгогдсон эрхэм Улсын Их Хурлын гишүүд дор бүрнээ анхаарч нэгдсэн бодлого, нэгдсэн зарчим, нэг зорилгын төлөө хичээж ажиллах нь та бүхний чухал үүрэг юм гэдгийг бас энэ таширамд хэлэхийг хүсэж байна.

Засгийн газрын зүгээс 30 хоногийн дотор үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж орж ирэх хуулийн заалттай. Энэ 30 хоногийн хугацаанд хамтарч засагт орсон улс төрийн намууд мөрийн хөтөлбөрөө нэгтгэж, хамтарсан хамтын ажиллагааныхаа гэрээг байгуулж, урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь та бүхний чухал үүрэг байгаа.

Монголын ард түмэн хамтарсан Засгийн газраас илүү хурдыг, илүү өндөр бүтээлийг, илүү хурдтай хөгжил дэвшлийг хүлээж байгаа гэдгийг та бүхэн минь цаг үргэлж санаж, илүү хариуцлагатай, өргөсөн тангарагтаа үнэнч хичээж зүтгэхийг нийт Улсын Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс хүсэж байна.

Амжилт хүсье та бүхэндээ.

Ингээд Засгийн газрын гишүүдийн Тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

07.50 цаг

**Монгол Улсын Ерөнхий сайд,  
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,**

Ардчилсан сонгуулийн үр дүнд байгуулагдсан 9 дэх удаагийн Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар гишүүд тангаргаа өргөж, намын бүлгүүд байгуулагдан, Байнгын хороодын бүрэлдэхүүнийг баталлаа. Түүнчлэн Монгол Улсын 33 дахь Ерөнхий сайдыг томилон Засгийн газрын бүрэлдэхүүнийг 22 сайд, 16 яамтай байхаар баталж, улмаар хамтарсан Засгийн газрын

гишүүдийг Улсын Их Хуралд танилцуулж тангараг өргүүллээ.

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд орсон өөрчлөлт сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдсэн анхны 126 гишүүнтэй Улсын Их Хурал эх орныхоо ардчилсан засаглалыг бэхжүүлэх, нийгэм, эдийн засгийн амьдралд хөгжил, дэвшлийг авчрах нэр төртэй үүрэг зорилтыг тээж байна.

Иймд нийгмийн олон бүлгийн төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй энэ удаагийн Улсын Их Хурал хууль тогтоомжийг хэлэлцэх, батлах, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, илүү мэргэжлийн түвшинд явуулах учиртай.

Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол эрх мэдэл гэхээс илүүтэй төр улсынхаа эрх ашгийг дээдлэн олон нийт, салбар салбарын дуу хоолой болж монголчуудын амьдралд тулгамдаж байгаа болон шинэ тутамд үүсэж буй асуудлуудыг бодит шийдлийг олж, зохих хууль тогтоомжид тусгуулан ажиллах үндсэн чиг үүрэгтэй.

Улмаар Улсын Их Хурал бол иргэдийн хүсэл зоригийг илэрхийлэгч байгууллага гэдгийг баталгаажуулж олон нийтийн зүгээс Улсын Их Хуралд өгөх үнэлэмж, итгэлийг дээшлүүлэх шаардлага бидний өмнө байна.

Иймд тангаргаа өргөсөн гишүүд та бүхэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын төрийн тогтолцоо, парламентын ардчиллыг бэхжүүлэхийн тулд Засгийн газар болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандах, асуудлыг анхааралдаа авахаас гадна улс орныхоо хөгжлийг хурдасгах үндсэн зорилгынхоо төлөө өндөр ёс зүйтэй ажиллахыг хүсэж байна.

Чуулганы завсарлагааны хугацаанд гишүүн бүр ажилтайгаа



сайтар танилцаж, ойрын хугацаанд хийж хэрэгжүүлэх ажил, санаачлах хууль тогтоомжийн чиглэлээ тодорхойлон иргэд олон нийттэй уулзалт, хурал зохион байгуулж идэвхтэй ажиллах нь зүйтэй байна.

Улсын Их Хурлын даргын хувиар та бүхний мэргэжил, туршлагад үндэслэн салбар, салбарын эрх зүйн орчинд тулгамдсан асуудлыг тодорхойлох, холбогдох хууль, эрх зүйн орчныг нарийвчлах, тодорхойгүй, тэгш бус байдлыг арилгах чиглэлээр гишүүн бүртэй тухайлан хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Эхний ээлжид хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үүрэг, хариуцлагын зохистой түвшнийг баталгаажуулах, зах зээлийн шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх зэрэг асуудлаар ойрын хугацаанд ажлын хэсэг байгуулж, зохих хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж олон нийтээр хэлэлцүүлэх болно.

Илүү мэргэжлийн, бүтээлч, ил тод, нээлттэй, шинжлэх ухаанч хэлэлцүүлгийн үр дүнд цагаа олсон, бодитой, үр ашигтай бодлогыг дэвшүүлж, хяналт тавьж, дүгнэж чаддаг шинэ цагийн улс төрийн соёлын төлөө хамтран ажиллацгаая. Шинээр бүрдэж байгаа хамтарсан Засгийн газрын зүгээс “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Үндэсний баялгийн сан”, “20 минутын хот”, “Шинэ хоршоо” болон Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” зэрэг чухал бодлого, арга хэмжээнүүдийг эрчимжүүлэхэд онцгой анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Эдгээр бодлогын баримт бичиг, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нь Монгол Улсын эрх ашигтай холбоотой асуудал юм.

Иймд энэ чиглэлээр Засгийн газрын бүрэлдэхүүнд багтаж байгаа намууд үндэсний зөвшилцлийг бий болгож, бодлогын залгамж чанарыг хадгалсан, ирээдүйг харсан, Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулна гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын 33 дахь Ерөнхий сайдаар томилогдсон Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ болон хамтарсан Засгийн газрын гишүүдэд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Анхдугаар чуулган хаагдсаныг мэдэгдье.

Лхагва гараг, 10 Долоодугаар сар 2024  
Төрийн ордон “Их хуралдай” танхим

07.50 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР



